



ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ



“ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН  
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ” ТӨСӨЛ

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

*Оюутны гарын авлага*

**Зөвлөх**

Ж.Амарсанаа

Академич, доктор (Sc.D), профессор

**Зохиогч**

Х.Гэрэлчулуун (Ph.D)

Энэхүү гарын авлагыг Хууль зүйн яамнаас хэрэгжүүлж буй  
Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах”  
төслийн хүрээнд боловсруулав.

Улаанбаатар хот  
2013 он

DDC  
345.052  
И-788

## ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

**Хөтөлбөр, гарын авлага зохиосон баг:**

**Зөвлөх:**

Ж.Амарсанаа

Академич, доктор (Sc.D), профессор

**Зохиогч:**

Х.Гэрэлчүлүүн (Ph.D)

Хэвлэлийн хуудас: 9.4  
Цаасны хэмжээ: В5  
Хэвлэсэн тоо: 1200  
Хэвлэсэн газар: “BCI” Хэвлэлийн компани



## Хууль зүйн сургуулийн багш, оюутан нарт



Монгол Улсын Засгийн газрын Хууль зүйн салбараа шинэчлэх санаачлагыг анхлан дэмжсэн хандивлагчдын тоонд Дэлхийн банк зүй ёсоор ордог билээ. Хууль зүй, дотоодхэргийн яамнаас 2002-2008 онуудад Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн хүрээнд эрх зүйн шинэтгэлийн чухал хэсэг болох Эрх зүйн бакалаврын боловсролын агуулга, чанарыг олон улсын түвшинд нийцүүлж, сайжруулах ажлын эхлэл тавигдсан юм. Тухайлбал, “Эрх зүйн дээд боловсролын Монгол Улсын стандарт”-ын анхны хувилбар, түүний дагуу 31 хичээлийн жишиг хөтөлбөр, эдгээрээс 14 хичээлийн оюутанд зориулсан гарын авлага зэргийг боловсруулж, сургалтын арга барилыг шинэчлэхэд чиглэсэн ажлууд хийгдсэн. Эдгээр хөтөлбөр, гарын авлагыг 2007-2008 онд эрх зүйч бэлтгэдэг бүх их, дээд сургуулиудын оюутнуудын хүртээл болгосон.

2009 оноос Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж эхэлсэн “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд дээрх ажлын үргэлжлэл болох оюутанд зориулсан нийт 20 гаруй хичээлийн гарын авлага боловсруулах ажил хийгдэж байна. Энэ ажлыг хууль зүйн салбарын нэр хүндтэй, туршлагатай эрдэмтэд, багш нар болон идэвх, санаачлагатай залуу багш нараас бүрдсэн нийт 60 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэж байна.

Төслийн зохицуулагч  
БОЛЬХОРЛООГИЙН СААНТУЯА

## Үр дүнд чиглэсэн сургалтын хөтөлбөр



Боловсрол судлаачид болон багш нар сургалт явуулах үзэл баримтлалыг боловсруулахдаа хоёр янзын хандлагаыг баримталж байна. Нэг дэх нь илүү уламжлалт хэлбэрийнх бөгөөд агуулгад чиглэсэн баримтлалыг дагадаг байхад хоёр дахь нь үр дүнд анхаардаг. Агуулгад чиглэсэн хандлагаар бол сургалтын агуулгыг тухайн шинжлэх ухааны мэдлэг, ойлголт тодорхойлдог. Харин үр дүнд чиглэсэн хандлага нь мэдлэгт анхаарахаас гадна суралцаагчдын үр чадвар, хандлага үнэт зүйлсийн хөгжилд анхаардаг.

1990-ээд оноос хийсэн эрх зүйн шинэчлэлт нь хууль зүйн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйг шинэчлэх, боловсронгуй болгохыг шаардсан юм. Хууль зүйн яам, Дэлхийн банкны “Хууль зүйн үйлчилгээг сайжруулах” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг дэмжих” дэд төслийн боловсруулсан сургалтын хөтөлбөр, гарын авлагын шинэлэг тал нь:

- Агуулгад суурилсан хөтөлбөрөөс агуулга, үр дүнд суурилсан хөтөлбөр боловсруулсан.
- Зорилго, хүрэх үр дүнг тодорхой болгосон.
- Онолын мэдлэгийг эзэмшиүүлэхийг зорихоос гадна мэргэжлийн чадвар эзэмшиүүлэх, үнэт зүйлсийн төлөвшийлд нь нөлөөлөх зорилго тавьсанд оршино.

Төслийн зөвлөх  
Ухнаагийн Туяа (Ph.D)

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА



## Жүтнээгийн АМАРСАНАА

*Монгол Улсын гавьяат хуульч, Шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн, Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), Профессор*

Шинжлэх Ухааны Академийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн захирал, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Харыцуулсан эрх зүй, олон улсын эрх зүйн судалгааны төвийн захирал, Олон улсын эрх зүйн тэнхимийн зөвлөх профессор, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, Монголын олон улсын эрх зүйн нийгэмлэгийн ерөнхийлөгч.

Сүүлийн 40 шахам жил 500 орчим хуулийн төсөл, олон улсын 40 орчим гэрээний төсөл бэлтгэх, гэрээнд нэгдэн орох (санал өгөх, ажлын хэсгийн гишүүн, санаачлан боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох зэрэг)-д оролцсон. Судалгааны ажил нь Үндсэн хууль, бусад 70 орчим хуульд тусгалaa олсон. Магистр (60), доктор (10)-ын ажлыг удирдаж хамгаалуулсан буюу удирдаж байна.



## Хорлоогийн ГЭРЭЛЧУЛУУН

*Хууль зүйн ухааны доктор*

ОХУ-ын Эрхүүгийн Улсын их сургуулийн хуулийн факультетыг 1994 онд төгссөн. ОХУ-ын Москвагийн их сургуульд 2010 онд “Монгол Улс хүний эрхийг хамгаалах, хөдөлмөрийн шилжих хөдөлгөөний асуудлаар олон улсын эрх зүйн харилцааны оролцогч болох нь” сэдвээр Хууль зүйн ухааны докторын (Ph.D) зэрэг хамгаалсан.

Монгол Улсын Хууль зүйн яаманд мэргэжилтэн, Хууль зүй, дотоод хэргийн яаманд ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга, Монгол Улсаас ОХУ-д суугаа ЭСЯ-ны хоёрдугаар нарийн бичгийн дарга, ГИХАЭГ-ын дэд даргаар ажиллаж байсан.

Монгол Улсын Иргэний харьяаллын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн ахлагчаар ажилласан.

2010 онд “Хүн амын шилжих хөдөлгөөн: олон улсын эрх зүйн зохицуулалт” номыг бичиж хэвлүүлсэн.

20 гаран эрдэм шинжилгээний өгүүллийг дотоод гадаадын сэтгүүлд нийтлүүлсэн. Гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлт, тэдний хариуцлагатай холбоотой 2 магистрын ажлыг удирдаж, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай 1 магистрын ажлын шүүмжлэгчээр ажилласан.



## ӨМНӨХ ҮТ

Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд “Иргэний харьялал ба шилжих хөдөлгөөн” сэдвээр оюутны гарын авлага боловсруулан олны хүртээл болгож байна.

Хууль зүйн их, дээд сургуульд олон улсын нийтийн эрх зүй, олон улсын хувийн эрх зүй, хүний эрх, харыцуулсан эрх зүйн хичээл нь заавал үзэх хичээл юм. Эдгээр хичээлийн зарим тодорхой сэдвийг сонгон суралцах хичээл хэлбэрээр орж байна. Иргэний харьялал ба шилжих хөдөлгөөн хичээлийг анх удаа сонгон суралцах хэлбэрээр хөтөлбөрт оруулах нь даяаршил, ардчилал, өрсөлдөөнт зах зээлийн харилцааны өнөө үед чухал ач холбогдолтой болох нь эргэлзээгүй.

Х.Гэрэлчулуун нь энэ чиглэлээр ОХУ-д хууль зүйн докторын (Ph.D) зэрэг хамгаалж нэг сэдэвт бүтээл нийтлүүлсний гадна хэд хэдэн өгүүлэл бичиж, илтгэл хэлэлциүүлсэн, практикийн байгууллагад ажилласан туршилага нь энэхүү гарын авлага чанартай болоход зохих түлхэц болсон нь харагдаж байна.

Зохиогч гарын авлагыг бүтээхдээ олон улсын гэрээ, Монгол Улсын хууль тогтоомж, монгол болон оросын эрдэмтэн судлаачдын бүтээл, түүнчлэн англи, герман хэл дээрх эх сурвалжийг ашигласан нь сайшалтай.

Монгол Улс гадаад шилжих хөдөлгөөний идэвхтэй оролцогч болохын хувьд дотоодын төдийгүй гадаадын иргэн, харьялалгүй хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, олон улсын эрх зүйн зарчим, үзэл баримтлалд нийцсэн үйл ажиллагаа явуулах, олон улсын гэрээ, конвенцийг судлах, амьдралд хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор гарч байна. Энэхүү хичээлийг судалснаар оюутан иргэний харьялал, шилжих хөдөлгөөний үндсэн ойлголтын талаар зохих мэдлэгтэй болно гэдэгт итгэлтэй байна.

*Зөвлөх Ж.Амаарсанаа  
Академич, доктор (Sc.D), профессор*

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

## ГАРЧИГ

НЭГ. ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ.....	8
ХОЁР. ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА.....	
I Бүлэг. Иргэний харьяаллын асуудал .....	11
1. Иргэний харьяаллын түүхэн хөгжил .....	11
2. Иргэний харьяалал, түүний ойлголт .....	17
3. Иргэний харьяаллын зарчим.....	21
4. Олон улсын эрх зүй дэх иргэний харьяалал.....	26
II. Бүлэг. Иргэний харьяаллын үндсэн асуудал.....	30
1. Иргэний харьяалалтай байх .....	30
2. Иргэний харьяалал дуусгавар болох.....	34
3. Хоёрдмөл харьяалалтай болон харьяалалгүй хүн.....	38
4. Гадаадын иргэн.....	43
III. Бүлэг. Шилжих хөдөлгөөний үндсэн ойлголт .....	47
1. Шилжих хөдөлгөөний тухай ойлголт .....	47
2. Шилжих хөдөлгөөний бүтэц, ангилал .....	51
3. Нийгэм ба шилжих хөдөлгөөн: нийгмийн төлөв байдал .....	54
4. Шилжих хөдөлгөөний орчин үеийн чиг хандлага .....	56
IV. Бүлэг. Шилжигч- шилжих хөдөлгөөний эрх зүйн харилцааны субъект болох нь .....	59
1. Шилжигчийн тухай ойлголт, тэдгээрийн төрөл .....	59
2. Хөдөлмөрийн шилжигчдийн эрх зүйн байдал.....	62
3. Дүрвэгч, орогнол хүсэгч .....	67
4. Хууль бус шилжих хөдөлгөөний хариуцлага.....	72
V. Бүлэг. Олон улсын эрх зүй ба шилжих хөдөлгөөн .....	77
1. Шилжих хөдөлгөөний зохицуулалтын зарчим ба эх сурвалж .....	77
2. Хүн амын шилжих хөдөлгөөн ба олон улсын байгууллага.....	81
3. Европын Холбооны Улсуудын шилжих хөдөлгөөний эрх зүйн зохицуулалт .....	87
4. Шилжих хөдөлгөөн ба хүн ам зүйн асуудал .....	92



## ТОВЧИЛСОН УГИЙН ТАЙЛБАР

ДДКГ	Дүрвэгчдийн асуудал эрхэлсэн комиссарын газар
ДОУБ	Дүрвэгчдийн асуудлаарх олон улсын байгууллага
ИУТЭОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
НТӨ	Нийтийн тооллын өмнөх
НТ	Нийтийн тооллын
НҮБ	Нэгдсэн үндэстний багууллага
ОУЭЗ	Олон улсын эрх зүй
ОУШХБ	Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ТУХНО	Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнууд
Шенгений хэлэлцээр	Хилийн хяналт шалгалтыг аажмаар халах тухай хэлэлцээр
ЭЗНСЭОУП	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
Европын конвенц	Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах Европын конвенц

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

## НЭГ. ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

### 1. ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

*Хичээлийн нэр:* Иргэний харьяалал ба шилжих хөдөлгөөн

*Кредит цаг:* 2

*Нийт цаг:* 40 (лекц 24, дасгал, семинар 16)

*Улирал:* VI

*Заавал судалсан байх хичээл:* Үндсэн хуулийн эрх зүй, Иргэний эрх зүй, Олон улсын нийтийн эрх зүй, Гэр бүлийн эрх зүй.

#### Иргэний харьяалал ба шилжих хөдөлгөөн хичээлийг судлах хэрэгцээ, шаардлага

Орчин үед хүн амын шилжих хөдөлгөөн нь нийгмийн төдийгүй эрх зүйн зохицуулалтын хувьд тулгамдсан асуудлын нэг болж байна. Улс хоорондын харилцаа өргөжин хөгжихийн хэрээр иргэд харилцан зорчих, хөдөлмөр эрхлэх, олон соёлт гэр бүл үүсэх зэргээр улс дамжсан шилжигчдийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байна. Энэ бүхэн нь иргэний харьяаллын асуудлыг хөндөж байдаг.

Иргэний харьяаллын институт нь төр, хувь хүний аль алиных нь хувьд чухал бөгөөд хувь хүн, төрийг хооронд нь холбож байдаг тогтвортой холбоо юм. Өөрөөр хэлбэл, иргэний харьяалал нь улс гүрний нутаг дэвсгэр дээр оршин суугаа ард түмнийг төртэй эрх зүйн холбоогоор нь нэгтгэж байдаг.

Дэлхийн аль нэг улсад иргэний харьяалалтай байх нь төвөгтэй асуудал биш. Тухайлбал, хүүхэд төрснөөр аль нэг улсын иргэний харьяалалтай болж насан туршдаа хадгалж явах боломжтой. Харин өөр улсад янз бүрийн шалтгаанаар шилжин суурышнаар иргэний харьяаллаа өөрчлөх асуудал гардаг байна. Ийнхүү иргэний харьяаллаа өөрчлөх үйл явц нь хүн амын шилжих хөдөлгөөний салшгүй нэгэн хэсэг юм.

Даяаршиж буй дэлхий ертөнцөд хүн амын хил дамнасан шилжих хөдөлгөөн улам бүр өсөн нэмэгдэж байгаа үед энэхүү нийгмийн үзэгдлийн эерэг ба сөрөг талыг судлан, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, түүнийг зохицуулж буй олон улсын эрх зүйн хэм хэмжээнд дун шинжилгээ хийх, түүнд тулгуурлан өөрийн улсын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал чухал байна.



Иргэний харьялал, шилжих хөдөлгөөний асуудал нь олон улсын нийтийн эрх зүйн гол салбар болохын хувьд эрх зүйн болон эдийн засаг, нийгмийн ухааны чиглэлийн их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт сонгон суралцах хичээл хэлбэрээр орно.

### **Иргэний харьялал ба шилжих хөдөлгөөн хичээлийн зорилго**

Энэхүү хичээлийн зорилго нь оюутныг иргэний харьялал, шилжих хөдөлгөөний талаарх эрх зүйн эх сурвалж болон онолын зохих мэдлэгтэй болгох, иргэний харьялал, шилжих хөдөлгөөний харилцан хамаарлыг ойлгож мэдэх, эрх зүйн соёлыг практикт бүтээлчээр хэрэглэх чадвар, хандлагад сургахад оршино. Түүнчлэн энэхүү хичээлийн явцад олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг зарчим, үзэл баримтлалын үүднээс аливаа асуудалд хандах арга барил, чадварыг оюутанд төлөвшиүүлнэ.

### **Иргэний харьялал ба шилжих хөдөлгөөн хичээлийн зорилт**

1. Иргэний харьялал гэж юу болох, түүний мөн чанарын талаар суурь мэдлэг олгох,
2. Төр, иргэн хоорондын харилцаа, түүний эрх үүргийн нэгдлийг дүгнэх чадвар эзэмшиүүлэх,
3. Иргэний харьялалтай байх, иргэний харьялал дуусгавар болох үндэслэлийн талаар мэдлэгтэй болох,
4. Иргэний харьяллын талаарх олон улсын эрх зүйн баримт бичгийг судлах, тэдгээрийг зөв хэрэглэх арга барилд сургах,
5. Шилжих хөдөлгөөний мөн чанар, онцлогийн талаар мэдлэг олгох,
6. Шилжих хөдөлгөөнтэй холбоотой хууль тогтоомжийн талаар тодорхой ойлголт өгөх,
7. Шилжигчдийн эрхийг хамгаалах, тэдний эрх зүйн байдлыг тодорхойлох чадвартай болгох,
8. Шилжих хөдөлгөөнтэй холбоотой нэр томъёог зөв хэрэглэхэд сургах.

### **Иргэний харьялал ба шилжих хөдөлгөөн хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, цагийн хуваарилалт**

Иргэний харьялал ба шилжих хөдөлгөөн хичээлийг заах багш нар оюутны цаашид ажиллах, мэргэшин суралцах хүсэл сонирхол, бие даан судлах боломж нөхцөл, хичээлийн хэрэглэгдэхүүний хангамж хүрэлцээг харгалzan сэдвийн сонголт, цагийн хуваарилалтыг хийж болно. Хичээлийн үндсэн сэдэв, тэдгээрийг заах хичээлийн хэлбэр, цагийн хуваарилалтыг жишиг байдлаар гаргалаа.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

№	Бүлгийн нэр	Хичээлийн сэдэв	нийт цаг	лекц	дасгал семи нар
1	Иргэний харьяаллын асуудал	1. Иргэний харьяаллын түүхэн хөгжил 2. Иргэний харьяалал, түүний ойлголт 3. Иргэний харьяаллын зарчим 4. Олон улсын эрх зүй дэх иргэний харьяалал	8	6	2
2	Иргэний харьяаллын үндсэн асуудал	1. Иргэний харьяалалтай байх 2. Иргэний харьяалал дуусгавар болох 3. Хоёрдмөл харьяалалтай болон харьяалалгүй хүн 4. Гадаадын иргэн	8	4	4
3	Шилжих хөдөлгөөний үндсэн ойлголт	1. Шилжих хөдөлгөөний тухай ойлголт 2. Шилжих хөдөлгөөний бүтэц, ангилал 3. Нийгэм ба шилжих хөдөлгөөн: нийгмийн төлөв байдал 4. Шилжих хөдөлгөөний орчин үеийн чиг хандлага	8	6	2
4	Шилжигч-шилжих хөдөлгөөний эрх зүйн хариулдааны субъект болох нь	1. Шилжигчийн тухай ойлголт, тэдгээрийн төрөл 2. Хөдөлмөрийн шилжигчдийн эрх зүйн байдал 3. Дүрвэгч, орогнол хүсэгч 4. Хууль бус шилжих хөдөлгөөний хариуцлага	8	4	4
5	Олон улсын эрх зүй ба шилжих хөдөлгөөн	1. Шилжих хөдөлгөөний зохицуулалтын зарчим ба эх сурвалж 2. Хүн амын шилжих хөдөлгөөн ба олон улсын байгууллага 3. Европын Холбооны Улсуудын шилжих хөдөлгөөний эрх зүйн зохицуулалт 4. Шилжих хөдөлгөөн ба хүн ам зүйн асуудал	8	4	4
	<b>Нийт</b>		<b>40</b>	<b>24</b>	<b>16</b>



## 2. ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН ХИЧЭЭЛИЙН ТОВЧ АГУУЛГА

### I Бүлэг. ИРГЭНИЙ ХАРЬЯАЛЛЫН АСУУДАЛ

#### СЭДЭВ 1. Иргэний харьяаллын түүхэн хөгжил

**Сэдвийн зорилго:** Иргэний харьяаллын тухай ойлголт үүсэх урьдчилсан нохцөлийг судалж, түүний мөн чанар, хэрхэн хөгжсөн, талаар суурь тэмдэг олгох, түүнчлэн төр-иргэн хоофондын хафилцаа холбоог үнэлж дүгнэх хандлага төлөөшигүүлэхэд оршино.

#### Сэдвийн товч агуулга:

Иргэний харьяаллын нийгэм - эрх зүйн мөн чанарыг илрүүлэхийн тулд түүний үүсэх болсон нийгмийн урьдчилсан нохцөл, байдлыг судалж иргэний харьяалал бий болсноор хүн төрөлхтний соёл иргэншил, улс төр, нийгэм, эдийн засгийн үйл явцын хөгжлийн түүхэнд хэрхэн нөлөөлснийг нээн илрүүлэх нь чухал юм. Иргэний харьяалал үссэн урьдчилсан нохцөлийг судлах явцад иргэний харьяалал, төр хоёрын аль нь анхдагч вэ өөрөөр хэлбэл, төр бий болсноор иргэний харьяалал бий болсон уу гэдэг асуулт гарна.

Төр хэзээ, хэрхэн үүссэн нь маргаантай хэдий ч орчин үед хязгаарлагдмал нутаг дэвсгэрт зайлшгүй хамтран амьдрах шаардлагатай хүмүүсийн бүлэг, нэгдэл гэдгийг төр гэж үздэг байна. Энгийнээр хэлбэл, төр гэдэг нь өөрийн гэсэн газар нутаг дээрх эрх зүйн зохион байгуулалттай ард түмэн юм.


Хүн амыг нутаг дэвсгэрээр хуваарилалт нь шинээр нийгмийн институт болох- харьяат, иргэний харьяалал гэх ойлголтыг бий болгосон.

#### Хүн ам түүний бүтэц

Олон улсын эрх зүйд тухайн цаг мөчид, аль нэг улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа нийт хүнийг бүхэлд хүн ам гэдэг. Тухайн улсын хүн амыг эрх зүйн байдлын ялгаагаар нь дараах байдлаар ангилдаг.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА



*Гадаадын иргэн гээдээ* нь тухайн улсын иргэний харьяалалгүй бөгөөд өөр улсын иргэний харьяалалтай хүнийг хэлнэ.

*Харьяалалгүй хүн гээж* аль ч улсын иргэний харьяалалгүй хүнийг хэлнэ.


Хүн амын дунд хоёрдмол болон олон харьяалалтай хүн байдаг. Энэ нь тухайн улсын иргэний харьяалалтай, бас өөр нэг буюу түүнээс олон улсын иргэний харьяалалтай байхыг ойлгоно.

Төрийн бүрэлдэхүүн, түүний үндэс нь хүн ам, өөрөөр хэлбэл, түүний эрх мэдэлд захирагдаж, тухайн улсын нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа хүмүүсийн нэгдэл мөн.

Аливаа нэг улсын нутаг дэвсгэр дээрх, ямар нэгэн нийгэм- улс төрийн хөгжлийн төлөө зорилготой нягтартсан хүн амыг ард түмэн гэдэг.

Орчин үед угсаатан гэдэг ойлголтод бусад бүлэг хүмүүсээс ялгарах нэг хэлээр ярьдаг, нэгдмэл гарал үүсэлтэйгээ хүлээн зөвшөөрсөн, цогц зан заншил, амьдралын хэв маяг, уламжлалаа хадгалсан бүлэг хүмүүсийг хэлдэг байна.

Аль нэг угсаатны төлөөлөл улс үндэстнээ байгуулсан, байгуулаагүйгээр, нэгдмэл байдалтай нягтран, эсвэл бусад угсаатны дунд тархан амьдарч болно.



## Иргэний харьяалал ба ард түмэн (үндэстэн)

Ард түмэн ба үндэстэн гэх ойлголт нь иргэний харьяалал гэх хувь хүн, төр хоорондын эрх, үүрэг, хариуцлагаар илэрхийлэгдсэн тогтвортой харилцаатай салшгүй холбоотой.



Иргэний харьяаллын холбоо нь нийгэм дэх төрийн үндэс болсон бусад холбоотой нэгддэг. Юуны өмнө энэ нь угсаатны хамаарал, оршин суугаа газар, соёлын хамаарал, шашин шүтлэг зэрэгтэй нэгддэг. Иргэний харьяалалтай болох, иргэний харьяалал дуусгавар болох нь нас, хүйс, нийгмийн байдал, итгэл үнэмшил зэрэг тодорхой хүчин зүйлд нөлөөлдөг байна.

Улс төр, эрх зүйн бүтээлүүдэд “ард түмэн”, “үндэстэн”-ий талаарх нэгдсэн санал одоогоор алга байна.

### **Иргэний харьяаллын үүсэл хөгжил**

Хүй нэгдлийн үеийн хүмүүс нэг хэл, нэг соёл, нэгдмэл шашин шүтлэг, зан заншлаараа холбогдсон ураг төрлийн холбоо байсан.

Иргэний харьяалал төр-эрх зүйн үзэгдэл болохынхoo хувьд боолын нийгмийн төртэй хамт хэлбэржсэн.

Боолын нийгэм задарч феодалын нийгэм бүрэлдэх явцад иргэний харьяалал гэдэг ойлголтод өөрчлөлт орсон. Иргэний харьяалал гэх ойлголтыг халж хувь хүнээс хамаарах “харьяат” гэх ойлголт үүссэн.

Иргэний харьяалал нь төрийн хөгжлийн тодорхой түүхэн нөхцөлөөс хамаарч түүний үйл явцын нөлөө дор оршиж ирсэн.

Тодорхой нэг улсын төрийн засаглал, бүрэн эрхийн орон зайн хязгаар, нутаг дэвсгэрийн хүрээ нь аль нэг улсыг нөгөө улсаас нь тусгаарладаг улсын хилээр зааглагддаг.

### **Эртний үеийн иргэний харьяалал**

Грекийн хүрээ, ромын иргэний овгоос өмнө иргэний харьяаллын тухай ойлголт нэг хэв, эрх зүйн хэлбэрт ороогүй байсан. Хувь хүн зөвхөн хүрээндээ (овогтоо) л хамааралтай. Хүрээнээсээ гадуур бол гол шинжээ алдана. Хүмүүсийн хүрээ, овогтойгоо холбоотой зөвхөн энэ л холбоос иргэн хүн “эрхэмсэг” байх ганцхан шинжийг баталгаажуулж байсан.


Нийгмийн үзэгдэл болох иргэний харьяалал анх Афин, Спарт, Ромд анхны боолын төртэй хамт хэлбэржсэн. Эртний Грект хүрээ нь төрийн байгууллагын хэлбэртэй байсан бөгөөд жижиг хот-улсын шинжийг агуулдаг байсан. Хүрээ нь хүн төрөлхтний түүхэн дэх анхны иргэдийн нөхөрлөл, нийгэмлэгийн хэлбэр юм. Эртний Грекийн түүхэн хувьслын үед иргэний харьяалал нь хүний үзэл бодлын дээд хэлбэр болох эх оронч үзэлтэй нягт холбогдсон.

Эртний хүрээнд юуны түрүүнд иргэний харьяалал нь эрх чөлөө, төрийн хэргийг шийдвэрлэх эрх, шүүх эрх мэдэлд оролцох зэрэг улс төрийн эрхтэй холбоотой байсан.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

Эртний Ром, Грект иргэний харьяалалтай байх гэдгийг түүнийг олж авсан арга хэлбэрээр нь дараах байдлаар ангилан үздэг.



## Афин

НТӨ 451-450 онд батлагдсан Периклийн хуулиар Афины бүрэн эрхт, уугуул иргэн эцэг, эхээс төрсөн эрэгтэйчүүдийг Афины иргэн гэж үздэг байсан.

Бусад хүмүүсийн хувьд арван найман насанд хурч, хоёр жилийн цэргийн алба хаасны дараа Афины иргэний харьяалалтай болж болно. Ардын хуралд 20 настайгаас оролцно. Газар тариалангаас бусад биений хүчний ажлыг “иргэн”-ий ажил биш гэж үздэг.

Мөн гадаадын иргэний хөдөлмөр эрхлэлтийг ч хуульчилсан. Тухайлбал, Гадаадын иргэд хувийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж, үл хөдлөх хөрөнгөөс бусад худалдаа ниймаа эрхэлж болох боловч Ардын хуралд оролцож, албан тушаал эрхлэх хориотой байсан. Тэд цэрэгт алба хааж, татвар төлдөг. Татвараа төлөхөөс зайлсхийсэн гадаадынхнийг боол болгож худалдаг байна.

Гэр бүлийн талаар ч тодорхой заалтууд байсан бөгөөд боолын эрх зүйн байдал нь гадаадын иргэнийхтэй адил байсан.

## Спарт

Спартын иргэн нь бүрэн ба бүрэн бус эрхтэйгээр ялгагддаг. Гучин нас хүрээгүй эрчүүдийг бүрэн бус эрхтэй гэж үзэж зарим захирагааны албан тушаал эрхлэхийг хориглодог. Иргэд нь эх орон, үндэсний соёлоо дотоод, гадаадын дайснаас хамгаалах зэрэг тодорхой үүрэг хүлээдэг байсан.

Эртний Грекийн хүрээ, овгийнхон шаардлагатай үед хоорондоо нэгдэн зохион байгуулагдаж өмч хөрөнгө, гэр бүл, иргэний харьяаллын асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар урьдчилан тохиролцдог байсан байна.

Хүрээ бүр нэр төдий ч гэсэн иргэний харьяалалтай байсан боловч баячууд хэд хэдэн хотын харьяалалтай байх нь бий. НТ I зуунд амьжиргаагаа дээшлүүлэх гэсэн хүн амын шилжих хөдөлгөөн, ялангуяа хот хооронд шилжих хөдөлгөөн эрс нэмэгдсэн.



Нийгмийн хувьсал, тэмцлийн явцад илүү их төлөвшсөн нь Ромын иргэний харьалал юм. Энэ нь “Би Ромын иргэн” гэдгээр бахархаж, бусдын хүндлэлийг хүлээж, эрх мэдэлтнүүдээс дэмжлэг аваход тустай байсан.

Ромын иргэний харьалал зөвхөн Ромчуудад хамааралтай байсан бол НТӨ 89 онд Итали, Эдикт, Каракалл-д, 212 онд хаант улсынхаа бүх эрх чөлөөт оршин суугчдад хамааруулсан.

### **Феодалын үеийн харьят**

Дундад зууны үеийн хувь хүний байдал нь Феодалын нийгмийн гишүүн хэн нэгнээс заавал хамаарч харин баян, хөрөнгөтэй нь эрх зүйн хувьд чөлөөт эрхтэй байсан. Энэ нийгэмд тариачид гол төлөв үе, удам дамжсан феодалаасаа алба, татвар төлж хараат байдаг. Тариачид, албад нь өмч хөрөнгө, эрх мэдэлгүй, эрх чөлөө нь хязгарагддаг. Тиймээс өмч, хөрөнгөтэй газрын эзэн феодалын өмчид уягдан тэднээс хараат байдлаар амьдарч байсан.

Төрийн эрх мэдэл төвлөрч, хэмжээлшгүй эрхт хаант засаглал үүсч хөгжихөд харьят нар нь эзэн хаанаасаа хараат болох үйл явц хөгжсөн.

### **Хөрөнгөтний үеийн иргэний харьалал**

Хөрөнгөтний нийгэмд хүн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй байх зарчмыг ёс төдий ч гэсэн тунхагласан. Жижиг гар урлалаас үйлдвэрийн хэмжээнд өссөн нийгмийн өөрчлөлт нь ажилчин өөрийн ажиллах хүчийг ажил олгогчид худалдах боломжийг бүрдүүлсэн.

Дундад зууны үед Европын хотуудад эдийн засаг хөгжиж, хүчирхэгжиж эхэлсэн нь эрх чөлөөний төлөө феодалтай тэмцэх тэмцлийг хурцатгаж засгийн эрхийн төлөөх тэмцэлд нэгтэгсэн. Хотын оршин суугчид феодалын харьят нарыг бодвол илүү эрх мэдэл, эрх чөлөөтэй болсон.

Францын хувьсгалын үед хэмжээгүй эрхт эзэн хаанаас хараат хүмүүсийн үзэл бодлоос илүү улс орны, улс төрийн амьдралд идэвхтэй оролцогч тэгш эрхтэй ард түмэн байх үзэл баримтлал хөгжих болсон.

Нийгмийнхувьсгал төрийн засаглалын шинэхэлбэрийг тодорхойлоод зогсдоггүй эрх зүй, хууль тогтоомжоос хамаарах нийгэм, хувь хүний харилцаа холбоог шинээр тогтоодог. Феодалын нийгмийн халаанд хувийн өмч, үйлдвэрлэлийн хэрэгсэлд тулгуурласан хөрөнгөтний байгуулал бүрэлдэн тогтсон.

Хөрөнгөтний үеийн иргэний харьалал нь эдийн засгийн баялгыг хүртэх, засаглалд оролцох эрхэд хүргэхгүйгээр хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байх зарчмыг тунхагласан.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

Шинэ эрины билэг тэмдэг болсон “Иргэн” гэх ойлголтыг анх 1789 онд Францын “Хүний болон иргэний эрхийн тунхаглал”-д улс төрийн амьдралд оролцох, эрхтэй хувь хүний чөлөөт байдалтай холбон тунхагласан. Хөрөнгөтний үеийн иргэний харьяалал нь феодалын нийгмийн харьят нарыг бодвол төрд эрх зүйн онцгой байр суурийг тогтоогоогүй, ангийн ялгааг нээлттэй гаргаагүйгээрээ ялгаатай.

Үүссэн нөхцөл байдал иргэний харьяаллыг хуульчлан баталгаажуулах, зохицуулалтыг шаардах болсон.

## **Хяналтын асуулт:**

1. Сэдвийн хүрээнд авч үзсэн дааарх нэр томьёог тайлбарлана уу. Үүнд:
  - хүн ам,
  - харьят,
  - иргэний харьяалал.
2. Иргэний харьяалал үүсэх урьдчилсан нөхцөл, түүний хөгжлийн талаар ямар мэдээлэл авсан бэ?
3. Нийгмийн хөгжлийн түүхэн үе бүрт иргэний харьяаллын тухай ойлголт, үзэл санаа хэрхэн өөрчлөгдөж ирсэн бэ?
4. Хэзэнээс иргэний харьяаллыг хуульчлан баталгаажуулсан бэ?
5. Францад иргэний харьяаллын асуудалд хэрхэн хандаж байсныг 1789 оны тунхаг, 1971 оны Үндсэн хуульд үндэслэн тайлбарлана уу.

## **Эх сурвалж**

1. Амарсанаа Ж. Хүний эрх. Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал. УБ., 2000.
2. Пунцагдаш О. Иргэний харьяалал. УБ., 2002.
3. Мэндсайхан Х. Монгол Улс дахь гадаадын иргэдийн харьяаллын асуудал (1921-1940 он). УБ., 2012.
4. Монголын харьят. Цагаачлалын түүх. Ц.Нэргүй, Н.Золзаяа, Х.Мэндсайхан УБ., 2006.
5. Кикоть В.Я. Прудников А.С. Российское гражданство, М., 2010.



## СЭДЭВ 2. Иргэний харьяаллын тухай ойлголт

*Сэдвийн зорилго:* Иргэний харьяаллын тухай ойлголтыг шинжлэх ухааны үүднээс тодорхойлох, түүний төн чанаар, улс орны тусгаар тогтнолд гүйцэтгэх үүргийг нээн илрүүлэх, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх чадвар эзэмшиүүлэхэд ошино.

### Сэдвийн товч агуулга:

Аливаа улс оронд болон олон улсын эрх зүйд хувь хүний эрх зүйн байдлыг иргэний харьяллаар нь тодорхойлдог.

Иргэний харьялал гэж төр, иргэн хоорондын харилцан эрх, үүргээр нөхцөлдсөн эрх зүйн тогтвортой холбоог хэлнэ.

Төрөөс бүрэн хэмжээгээр иргэний эрх, эрх чөлөө, тэр ч байтугай дипломат хамгаалалтыг хангаж байгаагаар хувь хүний эрх зүйн байдал тодорхойлогддог бөгөөд үүнд иргэний харьяаллын гол утга учир оршдог. Үүнийхээ хариуд төр иргэдээсээ зарим үүргийг биелүүлэхийг шаардаж харилцан эрх, үүргээр холбогддог байна.

### Иргэний харьялал ба харьят

Хувь хүн, төр хоорондын холбоо, харилцааны энэхүү ойлголтыг улс орнуудын хууль тогтоомжид янз янзаар нэрлэх нь бий. Тухайлбал, Бүгд найрамдах засаглалтай улс оронд дээрх харилцааг “иргэний харьялал” гэж нэрлэдэг бол, хаант засаглалтай улс оронд “харьят” гэсэн нэр томьёог хэрэглэдэг байна.

Англи, американын онол, практикт иргэн (citizen) ба харьят (subject) гэдэг үгийг өргөн хэрэглэхийн зэрэгцээ цөөн хэдэн улсад үндэстэн (national) гэсэн нэр томьёог хэрэглэх нь бий.

Иргэний харьялал нь тухайн улсын үндэсний хууль тогтоомжоор зохицуулдаг дотоод асуудал юм. Иргэний харьяаллын тухай хуульгүй улс байdag боловч энэ нь төрд хамаарахгүй гэсэн үг биш. Гэхдээ гадаад улсуудтай харилцах харилцааг төвөгтэй болгож болох талтай.

### Иргэний харьяаллын тогтвортой байдал

Хүн төрснөөр иргэний харьялалтай болж түүнийгээ насан туршдаа хадгалж явах эрхтэй. Иргэн, төр хоёр хоёулаа эрх, үүрэгтэй. Хүн хаана төрсөн, хаана амьдарч байгаа (тухайн улсын нутаг дэвсгэр дээр эсвэл түүний гадна)-аас үл хамаарч өөрийн улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, эрхээ эдэлдэг.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

Төр өөрийн иргэнээ өөр улсын нутаг дэвсгэрт оршин сууж байсан ч өөрийн улсын ивээл, хамгаалалтад байлгаж, түүний амь нас, эд хөрөнгийг хамгаалж, сайн сайхны төлөө санаа тавих үүрэгтэй. Аль нэг улсын иргэн өөр улсын нутаг дэвсгэрт байнга оршин суухаар явах нь өөрийн улсын иргэний харьяаллаа автоматаар (зарчмын хувьд) дуусгавар болгож буй хэрэг биш.

Тэрчлэн иргэнийг үүргээ зөрчсөн тохиолдолд төр шүүхийн журмаар хянан шийдвэрлүүлэх, эсвэл улс төрийн арга хэмжээ авдаг.

Иргэний харьяалал нь цаг, хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй, тогтвортой байх шинжтэйгээрээ онцлогтой.

## Төр, гадаадын иргэн хоорондын харилцаа

Эрх зүйн харилцаанд төр дан ганц өөрийн иргэнтэй бус өөрийн нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн: шилжин ирэгч (*immigrant*); түр ирэгч, дамжин өнгөрөгч, дүрвэгч болон тухайн улсад хууль бусаар оршин суугаа этгээдтэй ч оролцдог.

Аливаа улсын нутаг дэвсгэрт түр болон байнга оршин суугаа хэн боловч бүгд л хууль тогтоомжоор баталгаажсан эрх, үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, тэдний эрх зүйн байдлыг тухайн улсын үндсэн хууль бусад хууль тогтоомжоор тогтоосон байдаг.

Улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд тухайн улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалгүй хүний эрхийг хязгаарлах хязгаарлалтыг зөвхөн хуулиар тогтоодог.

## Иргэний харьяаллын мөн чанар

Иргэний харьяалал нь нийгэм - эрх зүйн хоёрдмол үүргийг гүйцэтгэдэг. Нэг талаас төр өөрийн иргэний эрхийг хамгаалах арга хэрэгсэл бол негеө талаас төр, нийгмийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах арга хэрэгсэл болгодог байна.

Иргэний харьяаллын мөн чанар нь харьяатын адил төрийн мөн чанараар тодорхойлогддог. Боолын нийгмийн үед боолын эээн иргэн нь – өмч хөрөнгөтэй, хувь хүнийхээ хувьд чөлөөт, онцгой эрхтэй байдлаар тодорхойлогддог байсан бол феодалын нийгэмд - улсынхаа тэргүүнд буюу хувь хүнд хамаарах байдлаар, хөрөнгөтний нийгэмд - төрийн засаглалын хэрэгт иргэн оролцох тэгш эрхийг ёс төдий илэрхийлсэн байдлаар тодорхойлогдоно.

Иргэний харьяалал нь төрийн тусгаар тогтнолтой шууд холбоотой. Энэ нь нэгдүгээрт: төр нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд иргэний эрх зүйн байдлыг зохицуулдаг. Энэ тохиолдолд иргэний харьяаллыг хуульчлах замаар түүний дээд хүчин чадлыг тогтоодог. Хоёрдугаарт: тухайн иргэн төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцох, тухайлбал, төрийн тусгаар тогтнолын баталгаа болдог.



## **“Хүн-бие (хүн)-иргэн” гэх ойлголтын харилцан хамаарал**

Иргэний харьяаллын мөн чанарыг ойлгохын тулд “хүн-бие хүн-иргэн” гэх ойлголтыг авч үзэх хэрэгтэй болдог.

Хүний гол шинж нь байгаль дэлхийн аяар дасан зохицох, түүнийг өөрийн хэрэгцээнд тааруулах чадвар юм. Хүн юмсыг өөрийн хэрэгцээ, сонирхолд зохицуулан байгалийн, түүнчлэн нийгмийн хүрээ үүсгэдэг байна. Хүн гэдэг нь хоёрдмөл утгатай буюу бионийгмийн, бие хүн гэдэг нь хүний нийгмийн шинж чанар юм. Бие хүн нь хүний, нийгэм дэх байр суурь, эрх зүйн чадамж, нийгэм эрх зүйн байдлыг илэрхийлсэн нийгмийн тодорхойлолт болдог.

Бие хүн бусад нийгмийн институт хоорондын харилцаанд өөр нэр томьёо хэрэглэдэг. Хот, төр, соёл иргэншил үүссэн тэр үеэс бие хүн, төр хоорондын харилцан үйлдлийг илэрхийлсэн “иргэн” гэх ойлголт үүссэн. Иргэн гэдэг нь төр, эрх зүйн харилцаанд хамтад нь авсан ойлголт.

Эцсийн дунд “хүн” гэх ойлголт нь -бионийгмийн, “бие хүн” нь - нийгмийн, “иргэн” нь - улс төр, эрх зүйн ойлголт юм.

## **Иргэний харьяаллын үүрэг**

Иргэний харьяалал нь ард түмний аж байдлыг эрх зүйн үүднээс томьёолж улс төрийн харилцаанд төрийг бүтээх, нийгэмд угсаатныг бүтээх үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь иргэний харьяаллын дотоод үүрэг болно. Иргэний харьяаллын гадаад үүрэг нь хүн амыг олон янзын улсад хувааж, хуваарилах хэрэгсэл болгодог.

Хувь хүний тухайд иргэний харьяалал нь тухайн хүн, төр хоорондын холбоог тухайлбал, аль улсад хамааралтай болохыг, тухайн хүний эрх зүйн байдлын үндэслэлийг тодорхойлох үүрэгтэй.

Иргэний харьяалал нь эрх зүйн институтын бүхэл бүтэн үзэгдэл болохын хувьд нийгэм, улс төр, ёс зүй, сэтгэл зүйн олон үүрэгтэй.

Эдгээр бүх үүрэг нь янз бүрийн улс оронд өөр ч гэсэн цогц байдлаар үйлдэгддэг.

## **Иргэний харьяаллын хууль тогтоомж**

Иргэний эрх үүргийг тухайн улсын Үндсэн хууль, Иргэний харьяаллын тухай болон бусад хууль тогтоомжоор тодорхойлдог.

Мөн иргэний харьяаллын олон янзын асуудал нь олон улсын эрх зүйн баримт бичигт тусгагдсан. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын (1948 он) 15 дугаар зүйлд “Хүн бүр иргэний харьяалтай байх эрхтэй” гэсэн заалт нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966 он), Хүүхдийн эрхийн тухай

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

конвенц (1989 он), Иргэний харьяаллын тухай Европын конвенцид (1997 он) тусгалаа олсон.

## **Хяналтын асуулт:**

1. Харьят, иргэний харьяалал гэх ойлголтыг тодорхойлж ялгааг гаргана уу.
2. Иргэний харьяалал гэж юу вэ, эрх зүйн шинжлэх ухаанд энэ ойлголтыг хэрхэн тайлбарладаг вэ?
3. Тогтвортой холбоо гэдэг ойлголтыг иргэний харьяалалтай холбож тайлбарлана уу.
4. Иргэний харьяалал ямар үүрэгтэй вэ?

## **Эх сурвалж**

1. Амарсанаа Ж. Англи-орос-герман-монгол олон улсын эрх зүйн толь. УБ., 2004.
2. Пунцагдаш О. Иргэний харьяалал. УБ., 2002.
3. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. //Төрийн мэдээлэл. I боть. УБ., 2004.
4. Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1992.
5. Харьяатын тухай хууль 1993.



### СЭДЭВ 3. Иргэний харьяаллын зарчим

**Сэдвийн зорилго:** Иргэний харьяаллын институтын төн чанаар, агуулга нь түүний зарчмаар илэрхийлэгддэг тул энэхүү зарчмыг дэлхийн улсуудын эрх зүйн зохицуулалтын жишээ дээр судалж танин тэдэх, үнэлэлт өгөх, дүгнэлт хийх чадваар эзэмшигүүлнэ.


#### Сэдвийн товч агуулга:

Улс бүр үндэсний хууль тогтоомждоо иргэний харьяаллын янз бүрийн зарчмыг тусгаж түүнийгээ удирдлага болгодог.

Эрх зүйн зарчим гэдэг нь тухайн нийгмийн харилцааг зохицуулах эрх зүйн хэм хэмжээний гол санаа, удирдлага болгох бүтцийн элемент, нэгдмэл байдлыг тодорхойлох, хөгжлийн үндсэн чиг хандлагыг хэлдэг.

Улсуудын иргэний харьяаллын талаарх үндэсний хууль тогтоомжид хүний эрх, эрх чөлөөг хэрхэн хамгаалах олон улсын хэм хэмжээг хэрхэн тусгасан байдлаас нь тухайн улсын ардчиллын түвшинг тогтоодог.

Эрх зүйн ерөнхий онолоор эрх зүйн зарчмыг 3 ангилааг.




Ерөнхий эрх зүйн зарчим нь салбарын зарчим, хэм хэмжээгээр дамжин хэрэгждэг. Иргэний харьяаллын институт болон бие хүний эрх зүйн байдлын үндэс нь адилхан эрх зүйн ерөнхий зарчимд тулгуурладаг бөгөөд хоёулаа төр, хүн хоорондын үндсэн харилцааг илэрхийлдэг.

Иргэний харьяаллын зарчмыг 2 ангилааг.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

## ИРГЭНИЙ ХАРЬЯАЛЛЫН ЗАРЧИМ



Холбооны улсуудад иргэний харьяаллыг эв нэгдэлтэй байдлаар томьёолдог. Тухайлбал, ОХУ зэрэг холбооны улсын доторх Бүгд найрамдах улсууд өөрийн гэсэн иргэний харьяаллаа шийдэх журамтай тул дээрх зарчмыг баримталдаг.

Төрийн нэгдсэн бүтэцтэй улсад иргэний харьяалал нэг байх зарчмыг баримталдаг. Жишээ нь: Украин Улсын Иргэний харьяаллын тухай хууль (2001 он)-д зааснаар Украинаы засаг захиргааны нэгжид иргэний харьяаллын өөр зарчим байхыг зөвшөөрдөггүй. Тус улсын бүрэлдэхүүнд өөрийн Үндсэн хуультай өөртөө засах эрхтэй Крымын Бүгд Найрамдах Улс байдаг хэдий ч тус улсын Үндсэн хуулийн ерөнхий зарчим болох иргэний харьяалал нэг байх зарчмыг хөнддөггүй байна.

### Иргэний харьяаллын тэгш эрхийн зарчим

Иргэний харьяаллын тэгш эрхийн зарчим нь хүн бүр гарал үүсэл, боловсрол, хэл, соёл, улс төрийн болон бусад итгэл үнэмшил, эрхэлж буй ажил, оршин суугаа нутаг дэвсгэрээс үл хамааран бүгд хуулийн өмнө тэгш эрхтэй байхыг ойлгодог. Тухайлбал, ОХУ-ын Үндсэн хуульд ОХУ-ын иргэн бүр тус улсын нутаг дэвсгэрт Үндсэн хуульд заасан тэгш эрхийг эдэлж, ижил үүрэг хүлээх тухай заасан.

Олон орны хуульд энэ зарчмыг тодорхойлсон байдаг. Узбекстан Улсын Үндсэн хуульд “Узбекстан Улсын иргэний харьяалал нь түүнийг олж авсан үндэслэлээс үл хамааран адил тэгш байна” гэжээ.

Балт орчмын улсууд, тухайлбал, Латви, Эстонид шилжин ирж байнга оршин суугчдаа үндсэн, үндсэн бус гэж ангилж, Америк, Франц зэрэг улсад иргэний харьяаллыг олж авсан байдлаар нь тэдний эрхийн хэмжээг тогтоож байгаа нь дээрх зарчимтай зөрчилддэг.

### Иргэний харьяаллыг чөлөөтэй, сайн дураар сонгох эрхийн зарчим

Энэ зарчмын гол агуулга нь хувь хүн иргэний харьяалтай болох, иргэний харьяаллаа дуусгавар болохтой холбоотой асуудлыг өөрөө бие даан шийдэх явдал



юм. Хэн ч эрх зүйн бүрэн чадамжтай этгээдийг албадан иргэний харьяаллыг нь өөрчлөхийг шаардах эрхгүй.

Иргэний харьяалал нь төр, хувь хүн хоорондын тогтвортой харилцаа болохынхоо хувьд хүнийг хүч хэрэглэн, албадан, иргэний харьяаллыг нь өөрчлөх асуудал гаргуулахгүй байх зарчимтай.

### **Иргэний харьяаллаас хасахгүй байх зарчим**

Иргэний харьяалал дуусгавар болох гэдэг ойлголтод иргэний харьяаллаас гарах, иргэний харьяаллаас хасах буюу алдах ойлголтыг хамруулдаг.

Иргэний харьяаллаас гарах гэдэгт тухайн иргэн өөр улсын иргэний харьяалалтай болох зорилгоор сайн дурын хүсэл зоригтоо илэрхийлж өөрийн улсын иргэний харьяаллаас гарч байгаа хэрэг.

Иргэний харьяаллаас хасахгүй байх зарчмыг улс бүр өөр өөрийнхөөр шийдвэрлэдэг. Эстони Улсын Үндсэн хуульд төрснөөр тус улсын иргэний харьяалалтай болсон иргэнийг тус улсын иргэний харьяаллаас хасахыг хориглосон заалт байдаг нь бусад хэлбэрээр тус улсын иргэний харьяалалтай болсон иргэдийг шууд бусаар ялгаварлан гадуурхаж байгаа гэж үзэж болох юм. Латви, Литви Улсын хуульд энэ талын заалт ер тусгагдаагүй.

### **Өөрийн иргэнээ өөр улсад шилжүүлэн өгөхгүй байх зарчим**

Олон улсын харилцаа өргөжин хөгжихийн хэрээр өсч буй сөрөг үзэгдэл бол хүн төрөлхтөний болон олон улсын эсрэг аюул занал дагуулсан үндэстэн дамнасан гэмт хэрэг өсөх явдал юм. Мөнгө угаах, хүний наймаа, хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлт, татвараас зугатах зэрэг гэмт хэргийн үйлдэгчид үндэсний хүрээнээс гарч өөр улсад, ялангуяа визгүй зорчдог улсад шилжин явах, орогнох болсон нь улс орнууд нягт хамтран ажиллах зайлшгүй шаардлагыг бий болгодог.

Олон улсын эрх зүйд дээрх асуудлыг шийдвэрлэх зорилгоор улс орнууд эрх зүйн туслацаа харилцан үзүүлэх, гэмт этгээдийг шилжүүлэх талаар гэрээ, хэлэлцэрэй байгуулан эрүүгийн хэрэгт татах, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, гэмт этгээдийг түр шилжүүлэх гурван хэлбэрийг тусгасан. Асуудлын гол нь хүсэлт хүлээн авагч орон өөрийн иргэнээ хүсэлт гаргасан улсад шилжүүлэн өгөхгүй байх тухай юм.

### **Олон харьяалал үүсгэхгүй байх зарчим**

Дэлхийн улсууд хоёрдмол (хоёр болон түүнээс дээш) харьяаллын асуудалд өөр өөрийн байр суурьтай байдаг.

Тэдний нэг хэсэг нь хоёрдмол харьяалалтай иргэд төрөлх эх орон, оршин суугаа орны хооронд соёлын болон бусад харилцааг хэвээр хадгалах талаасаа байж болох

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

асуудал гэж үздэг бол нөгөө хэсэг нь тэд хоёрдмол харьяалалтай байснаар илүү их сөрөг үр дагавар, олон улсын сөргөлдөөнийг үүсгэдэг гэж үздэг байна.

Гэсэн хэдий ч даяаршлын эрин үед хүн амын шилжих хөдөлгөөн улам эрчимжиж байгаа болон бусад нөхцөлийн улмаас улсуудын хоёрдмол харьяалалд хандах хандлага өөрчлөгджэй байна. (Илүү тодорхой асуудлыг хоёрдмол харьяалалтай болон харьяалалгүй хүн сэдвээс харна уу)

## Харьяалалгүй хүн үүсгэхгүй байх зарчим

Харьяалалгүй хүн гэж аль ч улсын иргэний харьяалалгүй хүнийг хэлдэг. Энэ байдал нь улс орнуудын иргэний харьяалалтай болох, иргэний харьяллын тухай хууль тогтоомжийн зөрүүтэй байдлаас үүсдэг.

Харьяалалгүй байдлыг туйлын ба харьцангуй гэж ангилж болно.

- Туйлын -хүүхэд төрөх үед үүсдэг,
- Харьцангуй нь -иргэний харьяаллаа алдсанаар үүсдэг.

Улсууд харьяалалгүй хүний асуудлаар ямарваа нэгэн үүрэг хүлээхээс аль болох татгалздаг. Гэхдээ харьяалалгүй хүн эрх эдлэхгүй гэсэн үг биш. Улсууд үндэснийхээ хууль тогтоомжид харьяалалгүй хүний эрх зүйн байдлыг тогтоодог. Тэд харьяалалгүй хүнд хүний үндсэн эрхийг эдлүүлэх, холбогдох дүрэм журмыг бэлтгэсэн байх шаардлагатай.

## Хилийн чанадад амьдарч байгаа иргэд өөрийн иргэний харьяаллаа хадгалах зарчим

Хүний эрхийн баримт бичгүүдэд дурдсан хүн чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох, эх орондоо эргэж ирэх эрхээ хэрэгжүүлж байгаа нэг хэлбэр нь төрөлх эх орноосоо гадагш явах, оршин суух газраа сонгож байгаа явдал юм.

Нөгөө талаар иргэний харьяллын тогтвортой шинж чанар нь тухайн улсын нутаг дэвсгэр дээр болон түүний гадна хэвээр хадгалагддагт оршдог. Энэ тухай улсууд хуульдаа заасан байдаг бол зарим улсын хуулиар тодорхой хугацааны туршид тухайн улсад амьдраагүй бол иргэний харьяаллаа алдах зохицуулалт ч байдаг.

## Гэр бүл болох, гэр бүл дуусгавар болоход иргэний харьяалал хадгалагдах зарчим

Энэ зарчим нь иргэний харьяалал бол зөвхөн хувь хүнд хамааралтай болохыг анхааруулсан зарчим юм. Өөрөөр хэлбэл, хуулиар тогтоосон журмын дагуу санаа зоригоо илэрхийлээгүй бол иргэний харьяаллыг нь өөрчлөхгүй. Янз бүрийн улсуудын иргэд хоорондоо гэр бүл болох, гэр бүл дуусгавар болох, тэдний үр хүүхэд төрөх,



хүүхэд үрчилж авах асуудал өөрөө гэр бүлийнхний хувьд иргэний харьяллаа сонгох эрх зүйн хүндрэлтэй асуудлыг дагуулдаг.

Зарим улсад, тухайлбал, итали эмэгтэй өөр улсын иргэнтэй гэр бүл болоход италийн иргэний харьяллаа автоматаар алддаг байхад латин американын зарим орны иргэдтэй гэр бүл болсон эмэгтэй автоматаар нөхрийнхөө улсын иргэний харьялалтай болдог. Энэ тохиодолд хүүхдийн иргэний харьялал тэр тусмаа гэр бүл дуусгавар болох үед асуудал дагуулдаг.

Гэр бүл болсон эмэгтэйн иргэний харьяллын тухай олон улсын конвенц гэр бүл болох, гэр бүл дуусгавар болох аль ч үед эмэгтэйчүүдийн иргэний харьяллыг тэдний хүсэл сонирхлоос гадуур шийдэхгүй байх, өөрийн хүсэл сонирхлоо илэрхийлсэн тохиолдолд хялбаршуулсан байдлаар шийдвэрлэх зохицуулалтыг тусгасан.

### **Хүндэт иргэн**

Хүндэт иргэн гэх ойлголт нь иргэний харьяллын ойлголтоос өөр. Гол төлөв хот, бүсийн удирдлагаас гавьяа байгуулсан хүнд “Хүндэт иргэн” цол хэргээнийг олгодог. Энэ нь нэмэлт эрх, үүрэгтэй холбоогүй.

#### **Хяналтын асуулт:**

1. Иргэний харьяллын зарчим, тэдгээрийг удирдлага болгох шаардлага юу вэ?
2. Тэгш эрхийн зарчмын зөрчилдөөнтэй байдлыг улсуудын жишээгээр дүгнэнэ үү.
3. Хилийн чанадад оршин суугаа иргэнээ хамгаалах гэдгийг юу гэж ойлгож байна. Монгол Улсын хууль тогтоомжид хэрхэн тусгагдсан бэ?
4. Иргэний харьяллын асуудлаарх олон улсын хэм хэмжээ, үндэсний хууль тогтоомж зөрчилдвэл алийг давуу эрхтэйгээр хэрэглэх вэ?
5. Хүндэт иргэн гэх ойлголт, түүний эрх зүйн байдлыг тайлбарлана уу.
6. Өөрийн иргэнийг өөр улсад шилжүүлэн өгөхгүй байх зарчмыг гэмт этгээдийг хүсэлт гаргагч улсад шилжүүлэн өгөх зарчимтай холбож тайлбарлана уу.

#### **Эх сурвалж**

1. Леонов Н.В. О гражданстве Российской Федерации, М., 2008.
2. Харьятын тухай хууль 1993.
3. Почётные граждане. Историческая справка. М., 2009.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

## СЭДЭВ 4. Олон улсын эрх зүй дэх иргэний харьяалал

*Сэдвийн зорилго:* Иргэний харьяаллын асуудлаарх олон улсын эрх зүйн зохицуулалтын эх сурвалж, зафчил, үзэл барагтлалын талаар тэдлэг олгох, үндэсний хууль тогтоомж, олон улсын барагт бичгийг судалж, тэдгээрийг хэрэглэх чадвар эзэмшиүүлэх зорилготой.

### Сэдвийн товч агуулга:

Олон улсын эрх зүйд хүн амын эрх зүйн байдалтай холбоотой чухал асуудлын нэг нь иргэний харьяаллын асуудал гэж үздэг. Энэхүү харилцааг зохицуулсан олон улсын эрх зүйн хэм хэмжээний цогц нь олон улсын эрх зүйн иргэний харьяаллын институтыг үүсгэдэг.

Иргэний харьяаллын олон улсын болон үндэсний институт нь ерөнхий хэм хэмжээгээр зохицуулагдаж хамтран үйлчилдэг.

Иргэний харьяаллын олон улсын эрх зүйн институт нь энэхүү харилцааг шууд болон шууд бусаар зохицуулахаар байгуулагдсан олон гэрээ, конвенцид тусгалаа олсон байdag.

Хүний эрхийн хамгийн наад захын эрх нь хувь хүн иргэний харьяалалтай байх явдал гэдгийг олон улсын хүний эрх, эрх чөлөөний тухай баримт бичгээр баталгаажуулсан.

### Иргэний харьяаллын асуудлаарх олон улсын гэрээ

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948 он),
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966 он),
- Алагчилах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (1966 он),
- Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1979 он),
- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны талаарх зөвлөгөөний төгсгөлийн баримт бичиг (1975 он),
- Гэр бүлтэй эмэгтэйчүүдийн иргэний харьяаллын тухай конвенц (1957 он),
- Орогнох нутаг дэвсгэрийн тухай тунхаг (1967 он),
- Оршин суугаа улсынхаа иргэний харьяалалгүй хүмүүст холбогдох эрхийн тухай тунхаг (1985 он),
- Харьяалалгүй байдлыг багасгах тухай конвенц (1954 он),
- Харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай конвенц (1948 он),
- Иргэний харьяаллын тухай хуулиудын зөрчилдөөнтэй холбоотой зарим асуудлын тухай конвенц (1930 он),



- Дүрвэгчдийн эрх зүйн байдлын тухай конвенц (1951 он).

### **Хүний эрхийн түгээмэл тунхаглал**

Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь хүн төрөлхтөний түүхэнд анх удаа “хүн төрөлхтөний гэр бүл” гэдгийг томьёолж хүний эрх, эрх чөлөө нэгдмэл байж харилсан хамаардаг болохыг тунхагласан түүхэн ач холбогдолтой.

Хүний үндсэн эрх дотроос улсынхаа дотор хүн бүр чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох, аль нэг улсыг түүний дотор төрөлх эх орноо орхиж явах, эргэж ирэх эрхийг баталгаажуулсан.

Түүнчлэн хүн бүр иргэний харьялалтай байх, дур зоргоороо хэнийг ч иргэний харьялалгүй болгох, эсвэл харьяллыг өөрчлөх эрхгүй болохыг баталгаажуулсан.

### **Хүүхдийн иргэний харьяллын талаар**

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Хүүхдийн эрхийн тухай конвенцид хүүхэд бүр иргэний харьялалтай байх, түүнийг хадгалах, сэргээх эрхтэй бөгөөд энэ эрхийг нь ямар нэгэн ялгаварлалгүйгээр төр хангаж өгөх үүрэгтэй гэж заасан.

### **Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенц**

Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенцид хүний нас хүйс, арьсны өнгө, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад итгэл үнэмшил, үндэсний болон нийгмийн гарал үүсэл, үндэсний цөөнхөд хамаарах, эд хөрөнгийн байдлаар ялгаварлан гадуурхахгүйгээр иргэний харьялалтай байх тухай заасан.

### **Гэр бүлтэй эмэгтэйчүүдийн иргэний харьяллын тухай конвенц**

Конвенцийн оролцогч улсууд эмэгтэй хүн өөр улсын иргэнтэй гэр бүл болоход тухайн улс хүсэл зоригоос нь гадуур автоматаар иргэний харьялалтай болгохгүй буюу өөрийн иргэний харьяллаа хадгалахад нь саад тоттор учруулахгүй байх, иргэний харьялалтай болохоор өөрийн хүсэл сонирхлоо илэрхийлсэн тохиолдолд хялбаршуулсан байдлаар иргэний харьяллыг нь шийдвэрлэж байх тухай тохиролцсон.

Хялбаршуулсан байдлаар иргэний харьялалтай болгох нь улс орны аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хамгаалахад харшилна гэвэл үзвэл зохих хязгаарлалтыг хийж болно.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

## Харьяалалгүй байдлыг багасгах тухай конвенц

Конвенцийн оролцогч улсууд өөрийн улсын нутаг дэвсгэрт байгаа аль ч улсын иргэний харьяалалгүй буюу “харьяалалгүй хүн” статусыг багасгах зорилгоор тодорхой зөвшилцэлд хүрсэн.

Ингэхдээ зарим нөхцөлийг тусгайллан зааснаас гадна дараах үндэслэлийг тохиролцсон.

- Хууль тогтоомжийн дагуу төрсөн хүүхдэд,
- Тухайн улсын хуульд заасны дагуу өөрийн хүсэлтээ гаргасан харьяалалгүй хүнийг хялбаршуулсан байдлаар өөрийн улсын иргэний харьяалалтай болгохыг зөвшилцсөн.

## Иргэний харьяаллын тухай Европын конвенц

Дараах нөхцөл байдлын улмаас дээрх конвенцийг батлах шаардлага гарсан.

1. Иргэний харьяаллын асуудлыг зохицуулсан олон конвенц батлагдсан боловч олон улсын болон улс орнуудын дотоод нөхцөл байдлын өөрчлөлтийг тусгасан нэг үзэл санаатай баримт бичиг бий болгох,
2. Улсуудын эрхийг залгамжлах чиглэлээр олон улсын эрх зүйг хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор шинээр заалт оруулах,
3. ЗХУ, Югослав, Чехославак Улсууд задарсан, хоёр Герман Улс нэгдсэний улмаас Төв болон Зүүн Европын геополитикийн карт өөрчлөгдөн шинээр зохион байгуулагдсан, ихэнх улсын хууль тогтоомж зөрчилдөөн үүсгэсэн зэргээс үүдэлтэй.

Конвенц нь иргэний харьяалалтай холбоотой дараах зарчмыг баталгаажуулсан.

1. Хүн бүр иргэний харьяалалтай байх,
2. Харьяалалгүй хүн үүсгэхээс зайлсхийх,
3. Хэнийг ч албадан улсынхаа харьяаллаас хасахгүй байх,
4. Гэр бүл болох, гэр бүл дуусгавар болоход хүсэл сонирхлоос нь гадуур автоматаар иргэний харьяаллыг өөрчлөхгүй байх зэрэг.

## Хяналтын асуулт

1. Иргэний харьяаллын талаарх олон улсын эрх зүйн зохицуулалт, үндэсний хууль тогтоомжийн харицсан уялдаа, холбоог тодорхойлно уу.
2. Шууд болон шууд бусаар иргэний харьяаллын асуудлыг тусгасан олон улсын эрх зүйн баримт бичгийг нэрлэнэ үү.



3. Харьяалалгүй байдал үүсгэхгүй, харьяалалгүй байдлыг багасгах тухай Конвенцийн ач холбогдлыг юу гэж дүгнэж болох вэ?
4. Иргэний харьяаллын холбогдолтой хууль тогтоомжийн зөрүүг хэрхэн зохицуулах вэ?
5. Иргэний харьяаллын тухай Европын конвенцийг батлах болсон шалтгаан, ач холбогдлыг тодорхойлно уу.
6. Харьяалалгүй хүн үүсэх шалтгаан юу вэ?

### ***Эх сурвалж***

1. Амарсанаа Ж. Хүний эрх. Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал. УБ., 2000.
2. Пунцагдаш О. Иргэний харьяалал. УБ., 2002.
3. Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948 он),
4. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966 он),
5. Гэр бүлтэй эмэгтэйчүүдийн иргэний харьяаллын тухай конвенц (1957 он),
6. Оршин суугаа улсынхаа иргэний харьяалалгүй хүмүүст холбогдох эрхийн тухай тунхаг (1985 он),
7. Харьяалалгүй байдлыг багасгах тухай конвенц (1954 он),
8. Харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай конвенц (1948 он),
9. Иргэний харьяаллын тухай хуулиудын зөрчилдөөнтэй холбоотой зарим асуудлын тухай конвенц (1930 он),

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

## II БҮЛЭГ. ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛЫН ҮНДСЭН АСУУДАЛ

### СЭДЭВ 1. Иргэний харьяалалтай байх

*Сэдвийн зорилго: Иргэний харьяалалын институтын гол шинж болсон иргэний харьяалалтай байх гэж юу болох, иргэний харьяалалтай болох үндэслэл, шалгуурыг тодорхойлох, түүнчлэн иргэний харьяалалын улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийн талааф үнэлэлт, дүгнэлт өгөх чадваар эзэмшигүүлэхэд чиглэгдэнэ.*

#### Сэдвийн товч агуулга:

Иргэний харьяалал нь улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнол, хүн ам зүйн асуудалтай салшгүй холбоотой. Тухайн улсын иргэн гэж хүлээн зөвшөөрөгдөх, төрснөөр болон хүсэлт гаргаснаар иргэний харьяалалтай болох асуудлыг үндэсний хууль тогтоомжоор зохицуулдаг.

Улс орон бүр хүн амын бодлогоо хэрэгжүүлэх хүрээнд иргэний харьяалалтай болохоор хүсэлт гаргагчид өөрийн гэсэн шалгуур үзүүлэлтийг тавьдаг байна.

#### Үндэсний аюулгүй байдал

Хүн амаа өсгөх бодлоготой улс орнууд нээлттэй, чөлөөт байдлыг бий болгодог. Иймд улс орны аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх нөлөөллийг судлах нь чухал.

Төр үүсч хөгжсөн цагаас түүний тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын тухай ойлголт үүссэн гэж үздэг.

Иргэний харьяалалтай байх тухай төрийн бодлого нь хоёр чиглэлтэй байдаг. Нэг бол хүсэлт гаргагчид иргэний харьяалалыг чөлөөтэй олгох, эсвэл нягт шалгууртай, тооны хязгаартай байх явдал.

Хүн амаа өсгөх төрийн бодлого нь улс орны нийгэм, улс төрийн тогтвортой байдал, иргэний эрх, эрх чөлөөг хангах, төр-хувь хүн хоорондын ашиг сонирхлын тэнцвэртэй байдлыг барих, эрх зүйн нэгдсэн орчинтой байхад тулгуурлах ёстой.

#### Иргэний харьяалалтай болох шалгуур

Ихэнх улсын хуульд тухайн улсын иргэний харьяалалтай болохоор хүсэлт гаргагч нь тус улсын нутаг дэвсгэр дээр тодорхой хугацаанд оршин сууж тухайн улсын нөхцөл байдалд урьдчилан дасан зохицсон (assimilation) байхаас гадна зохих шалгуурыг тавьдаг байна.



АНУ хүсэлт гаргагчаас англи хэлний болон америкийн түүх, улс төрийн тогтоолцооны талаар шалгалт авч, Шилжих хөдөлгөөний байгууллагаас хэрэг зөрчил гаргасан эсэхийг лавласны дараа шуухийн шийдвэр гаргадаг.

Норвеги, Финлянд Улс материаллаг эх үүсвэртэй байх, Грек, Канад, Скандинавын Улсууд амьдралын зөв хэв маягтай байх, Франц эрүүл биетэй байх зэрэг нэмэлт шалгуурыг тавьдаг бол Кувейт, АНЭУ, Саудын Араб зэрэг улс зөвхөн мусальман шашинтнууд байхад хангалттай гэнэ. Хэрэв араб гэр бүлийн гишүүн нь өөр шашинтай бол өөрийн шашинаасаа татгалзсаны дараа иргэний харьяалалтай болох хүсэлтээ гаргах эрхтэй.

Иргэний харьяаллын гол агуулга нь иргэний харьяалалтай байх, иргэний харьяалал дуусгавар болох тухай юм.


### Иргэний харьяаллыг хүлээн зөвшөөрөх

Иргэний харьяаллыг тогтоох буюу хүлээн зөвшөөрөх асуудал нь үндэсний хууль тогтоомжид тусгагдсан байдаг. Тухайлбал,

- Иргэний харьяаллын тухай хуулийг баталсан тэр өдөр тухайн улсын иргэний харьяалалтай байгаа бүх хүний,
- Хүчин төгөлдөр иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу тухайн улсын иргэний харьяалалтай болсон бүх хүмүүсийг тухайн улсын иргэн гэж хүлээн зөвшөөрдөг байна.

### Иргэний харьяалалтай байх

Иргэний харьяалалтай болох үндэслэл:



### Төрснөөр иргэний харьяалалтай болох

Ихэнх улс оронд хүүхэд төрснөөр иргэний харьяалалтай болдог.

Тухайн улсын хуулийн дагуу хүүхэд төрснөөр иргэний харьяалалтай болох /*filiation, филиация/* хоёр зарчим үйлчилдэг.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

1. ураг төрлийн зарчим (*jus sanguinis*)

2. нутаг дэвсгэрийн зарчим (*jus soli*)

Ураг төрлийн зарчим ёсоор тухайн улсын иргэдээс төрсөн хүүхэд бүр тэр улсын иргэний харьяалалтай байна. Зарим улсын хувьд эцэг, эхийн аль нэг нь тухайн улсын иргэний харьяалалтай байхад хангалттай гэж үздэг.

Хүүхэд аль улсын нутаг дэвсгэрт төрсөн нь бас чухал ач холбогдолтой. Эцэг, эх нь аль улсын иргэн байхаас үл хамааран тухайн улсын нутаг дэвсгэрт төрсөн хүүхэд бүр тэр улсын иргэний харьяалалтай болохыг нутаг дэвсгэрийн зарчим гэдэг.

## Өөрийн хүсэлтээр иргэний харьяалалтай болох (натурализаци)

Тухайн улсын иргэний харьяалалтай болохоор өөрийн хүсэл зоригоо илэрхийлж, хууль тогтоомжийнх нь дагуу, холбогдох төрийн байгууллагад хүсэлтээ гаргаж иргэний харьяалалтай болохыг олон улсын эрх зүйд натурализаци гэдэг. Ингэж хүсэлтээ гаргах нь гол төлөв өөрийн үндсэн харьяаллаа дуусгавар болгоход хүргэдэг.

Улсууд иргэний харьяалалтай болохоор хүсэлт гаргагчид тодорхой шалгуурыг тавьдаг. Зарим нийтлэг шалгууруyg харуулбал:

- тодорхой хугацаанд тус улсын нутаг дэвсгэрт оршин суусан байх,
- насанд хүрсэн байх,
- тухайн улсын хэлийг мэддэг байх,
- амьжиргааны эх үүсвэртэй байх,
- төвийг сахисан үзэл баримтлалтай байх,
- материаллаг эх үүсвэртэй байх,
- ёс зүйтэй байх зэрэг.

## Иргэний харьяаллаа сонгох (оптаци)

Иргэний харьяаллыг сонгох гэдэг нь ямар нэг улсын нутаг дэвсгэрийн хэсэг өөр улсын мэдэлд шилжихэд хүн ам нь аль нэг улсын иргэний харьяаллыг сонгож иргэний харьяалалтай болохыг хэлдэг. Өөрөөр хэлбэл, аль нэг улсын нутаг дэвсгэр өөр улсын мэдэлд шилжихэд тухайн газар нутаг дээр оршин сууж байсан хүн ам нь эрх зүйн тодорхойгүй байдалд ордог. Энэ үед улсууд хоорондоо харишсан тохиролцож аль нэг улсын иргэний харьяаллыг сонгох тодорхой хугацаа тогтоож иргэдээ сонголт хийлгэдэг байна. Иргэний харьяаллыг сонгох үйл явц нь үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээгээр зохицуулагддаг. Тухайлбал, 1955 оны Хятад, Индонез хоорондын гэрээгээр 2 жилийн хугацаанд аль нэг улсын иргэний



харьяаллыг сонгох үйл ажиллагаа явагдаж байсан. Харьяалалгүй хүмүүсийн дунд ч оптаци зарлах явдал байдаг. Оптаци нь нэгэн зэрэг иргэний харьяаллаас гарах, нөгөө улсын иргэний харьяалалтай болох үйл явц зэрэгцэх үндэслэл болдог.

### **Иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох (реинтеграци)**

Өмнө нь тухайн улсын иргэний харьяалалтай байгаад түүнийгээ үрчлэгдсэн, эцэг, эхийн харьяалал өөрчлөгдсөн зэрэг үндэслэлээр иргэний харьяаллаа алдсан эсхүл иргэний харьяаллаасаа гарсан хүний хүсэлтийг нь харгалзан холбогдох хууль тогтоомжийн дагуу төр иргэний харьяаллыг нь сэргээн тогтоодог.

Олон улсын эрх зүйд репатриаци гэж ойлголт байх бөгөөд энэ нь дайны улмаас олзлогдогсод, шилжин явагчид эх орондоо бөөнөөрөө, зохион байгуулалттайгаар эргэн ирж иргэний харьяаллаа сэргээхийг хэлдэг.

Олон улсын гэрээ болон бусад хуульд заасан үндэслэлээр (хүүхэд, эрх зүйн чадамжгүй этгээд асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтийр) иргэний харьяалалтай болж болно.

#### **Хяналтын асуулт:**

1. Төрснөөр иргэний харьяалалтай болох зарчмын үндсэн агуулгыг тодорхойлно уу.
2. Өөрийн хүсэлтийр (натурализаци) иргэний харьяалалтай болох гол шалгуурыг юу гэж ойлгож байна вэ?
3. Иргэний харьяаллыг сонгох (оптаци) эрх зүйн үндэслэл юу болохыг тайлбарлана уу.
4. Иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох, бусад аргаар иргэний харьяалалтай болохоос юугаараа давуу талтай болохыг жишээгээр тайлбарлана уу.
5. Улс орнуудын иргэний харьяалалтай болохоор хүсэлт гаргагчид тавьдаг шалгуурын онцлог юу вэ?

#### **Эх сурвалж**

1. Амарсанаа Ж. Хүний эрх. Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал. УБ., 2000.
2. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2009.
3. Леонов Н.В. О гражданстве Российской Федерации, М., 2008.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

## СЭДЭВ 2. Иргэний харьяалал дуусгавар болох

*Сэдвийн зорилго: Иргэний харьяалал дуусгавар болох гэдэгт иргэний харьяаллаас гарах, эсхүл алдахыг ойлгох бөгөөд үүний ялгаа, шалтгаан нохицол, түүний эрх зүйн зохицуулалтыг улсуудын жишээгээр судалж дүгнэлт гаргаж сурхад ошино.*

### Сэдвийн товч агуулга:

Иргэний харьяалал нь хоёр талын эрх зүйн холбоо болохын хувьд төр, хувь хүн хоёрын аль алиных нь санаа зоригийн илэрхийлэл нэгдэж байж тогтвортой холбоог үүсгэнэ. Санаа зориг нь нэгдэхгүй тохиолдолд аль нэг талын санаачлагаар холбоо харилцаа дуусгавар болдог.

Нийгмийн талаас авч үзэхэд иргэний харьяалал дуусгавар болох нь хувь хүнд илүү тохиромжтой хүмүүсийн нэгдлийг хайх боломжийг нээдэг.

### Иргэний харьяалал дуусгавар болох үндэслэл

1. Θөрийн хүслээр иргэний харьяаллаас гарах (экспатриаци)
2. Төрснөөр өөр улсын иргэний харьяалалтай болсон хүнийг улс нь (албадан) иргэний харьяаллаас хасах (денационализаци)
3. Θөрийн хүсэлтээр иргэний харьяалалтай болсон хүнийг албадан иргэний харьяаллаас хасах (денатурализаци)
4. Θөмөн оршин сууж байсан газартаа хүмүүс бөөнөөрөө буцаж тухайн улсын иргэний харьяалалтай болох (репатриаци)
5. Газар нутгийн эрх мэдэл шилжсэнээр оршин суугчид нь бөөнөөрөө аль нэг улсын иргэний харьяаллыг сонгох (оптаци)
6. Олон улсын гэрээ, хэлэлцээр болон хуульд заасан бусад үндэслэлээр

### Θөрийн хүслээр иргэний харьяаллаас гарах

Иргэн өөрөө хүслэлт гаргаж иргэний харьяаллаас гарах нь иргэний харьяалал дуусгавар болох нэг хэлбэр мөн. Иргэний харьяаллаас гарах хүслэлтээ гаргахад өөр улсын иргэний харьяалалтай болох баталгаа байх ёстой. Эс тэгвэл нэг улсын иргэний харьяаллаас гаралад өөр улсын иргэний харьяалалтай болж чадахгүй бол харьяалалгүй хүний тоог нэмнэ. Хэдийгээр энд харьяалалгүй хүний тоо нэмэгдэх мэт ойлгогдож байгаа боловч хувь хүний хувьд эрхийн баталгаа алдагдана гэсэн уг. Иймээс ч харьяалалгүй хүнийг нэмэхгүй байх, аль болох багасгах олон улсын конвенцийг баталсан.



## Иргэний харьяллаас гарахыг татгалзах үндэслэл

Иргэн өөрийн хүсэлтээ илэрхийлж иргэний харьяллаасаа гарах эрхтэй хэдий ч түүнийг татгалзах үндэслэлийг улсуудын хуульд тусгасан байдал.

### Татгалзах үндэслэлд:

- Төрийн өмнө үүргээ биелүүлээгүй (цэргийн алба хаах...),
- Иргэн байгууллага, аж ахуйн нэгжийн ашиг сонирхолтой холбоотой үүргээ биелүүлээгүй (гэрээгээр хүлээсэн үүрэг, татвар төлөх үүрэг зэрэг)

### Үнээс гадна иргэний харьяллаас гарахыг хойшлуулах үндэслэлд:

- Яаралтай цэргийн албандаа татах буюу дүйцүүлэн хаах алба,
- Эрүүгийн хариуцлагад татах, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг биелүүлэх,
- Нэг улсын иргэний харьяллаас гараад нөгөө улсын иргэний харьялалтай болох баталгаагүй буюу харьялалгүй хүн үүсэхээр бол,
- Тухайн иргэн харьяллаас гарснаар үндэсний аюулгүй байдал, ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэхээр бол.

### Иргэний харьялал ба “ухаантай тархи”-ийг татах

“Ухаантай тархи” гэдэг нь шинжлэх ухаан техникийн болон бусад өндөр мэргэжлийн боловсон хүчин түр болон байнга оршин суухаар өөр оронд шилжин явж байгаа шилжих хөдөлгөөний нэг хэлбэр юм.

1960-аад оноос эхлэн эдийн засгийн хөгжил, нөхцөл сайтай АНУ, Канад, Англи Улсуудад, 1980-1990 онд ӨАБНУ, Израиль, Саудын Араб болон Персийн булангийн зарим оронд дээрх зорилгоор олон хүн шилжин суурьшсан.

Өндөр боловсрол, мэргэжил, оюуны хүчин чадалтай иргэнээ алдах нь хөгжиж байгаа орнуудад хүнд цохилт болдог.

Иймээс зарим улсын хууль тогтоомжоор төрийн нууцтай холбоотой ажилтнаа өөр улс оронд гэрээгээр ажиллахыг хориглодог байна.

### Иргэний харьяллаа сонгосноор иргэний харьялал дуусгавар болох (оптаци)

Аливаа нэг улсын нутаг дэвсгэрийн эрх мэдэл нөгөө улсын мэдэлд шилжсэнээр тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байсан иргэд аль нэг улсын иргэний харьяллыг сонгох байдалд хүрдэг.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

Энэ сонголт нь нэг улсын хувьд бүлэг иргэд нь иргэний харьяаллаасаа гарах, нөгөө улсын хувьд бүлэг хүнийг иргэний харьяалалтай болгоход хурдэг. Энэ зохицуулалтыг олон улсын гэрээ, хэлэлцээр, хуулиар зохицуулдаг.

## Иргэний харьяаллаас хасах

Иргэний харьяаллын асуудлаар гаргасан шийдвэрийг хүчингүй болгох, иргэний харьяаллаас хасах хоёр нь хоорондоо харилцан холбоотой ойлголт билээ.

Энэ нь нэгдүгээрт: хувь хүний санаа зоригийн илэрхийлэлгүй иргэний харьяаллыг дуусгаж байгаа ганц үндэслэл, хоёрдугаарт: олон оронд хууран мэхлэх замаар иргэний харьяалалтай болсон бол түүнийг хүчингүй болгодог нь хэвийн үзэгдэл.

Иргэний харьяаллаас хасах нь тухайн хүний саналыг харгалзахгүй зөвхөн нэг талын саналаар холбоог таслаж байгаа хэрэг юм.

Хүний эрхийн баримт бичигт иргэнийг харьяаллаас хасч болохгүй тухай заасан хэдий ч ардчилсан үзэлтэй олон оронд, тухайлбал, Испани Улсын Үндсэн хуульд “нэг ч Испани гаралтай хүн үндэстнээсээ хасагдах ёсгүй” гэж заасан нь хүсэлтээрээ Испаний иргэний харьяалалтай болсон хүнд хамаarahгүй. Мөн Австралийн хуульд өөрийн хүсэлтээр тус улсын иргэний харьяалалтай болсноос хойш 6 жилийн хугацаанд иргэний харьяаллаас хасахыг хориглосон заалт байдаг байна.

## Иргэний харьяаллаа алдах

Олон орны хуульд иргэний харьяаллаа алдах үндэслэлийг өөрийн орны түүх, улс төр, эдийн засгийн болон бусад нөхцөлийн улмаас янз бүрээр тусгасан байдаг.

### Тухайлбал АНУ-д:

- Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчийн аль нэгний болон өөрийн хүсэлтээр (натурализаци) өөр улсын иргэний харьяалалтай болсон,
- Өөр улсын улс төрийн болон бусад байгууллагад тухайн улсад үнэнч гэдгээ тангарагласан, эсхүл ямар нэгэн байдлаар илэрхийлсэн,
- Тус улсын Төрийн нарийн бичгийн дарга, Батлан хамгаалахын сайдын тусгай зөвшөөрснөөс бусад тохиолдолд өөр улсын зэвсэгт хүчинд алба хаасан,
- Өөр улсын иргэний харьяалалтай болохоор тухайн улсын засгийн газрын болон улс төр- орон нутгийн байгууллагад албан тушаал хашсан,
- Иргэний харьяаллаасаа татгалзахаар эрх бүхий албан тушаалтанд бичгээр хүсэлтээ гаргасан,



- АНУ-ын засаг, төрийн эсрэг зэвсэгт хүчин, бусад хүч хэрэглэсэн үйл ажиллагаанд оролцсон бол АНУ-ын иргэний харьяаллыг алдах үндэслэл болдог байна.

#### **Хяналтын асуулт:**

1. Олон улсын эрх зүйд иргэний харьяаллаас хасахыг хориглодог хэдий ч улсуудын хуульд “хасах” заалт тусгагдсаныг юуг гэж дүгнэж байна?
2. Иргэний харьяаллаа алдах үндэслэлийг аль нэг улсын жишээгээр тайлбарлана уу.
3. Иргэний харьяаллаас хасах, иргэний харьяаллаа алдах ойлголтын ялгааг тайлбарлана уу.
4. Төрийн хүснэгтээр иргэний харьяаллаас гарах үед ямар үндэслэлээр татгалздаг вэ?

#### **Эх сурвалж**

1. Амарсанаа Ж. Хүний эрх. Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал. УБ., 2000.
2. Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1992.
3. Монгол Улсын Харьяатын тухай хууль. УБ., 1993.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

## СЭДЭВ 3. Хоёрдмол харьяалалтай ба харьяалалгүй хүн

**Сэдвийн зорилго:** Дэлхийн улсууд улс төр, соёл, хүн ам зүй, угсаатан болон газар зүйн нөхцөл байдлаас шалтгаалан хоёрдмол харьяаллын асуудалд өөр өөр байр сууринаас ханддаг. Тиймээс хоёрдмол харьяалал, түүний эсрэг харьяалалгүй хүн гэж юу болох, түүний үр дагавар, бусад шинжийг судлан эзрэг, сөрөг талыг дүгнэхийн зэрэгцээ асуудлыг зохицуулах механизмыг үнэлэх, цэгцүтэй тэдлэг олгоход чиглэгдэнэ.

### Сэдвийн товч агуулга:

Иргэний харьяаллын асуудал нь ихэнхдээ улс орны дотоод зохицуулалтад хамаарах боловч хоёрдмол харьяалал, харьяалалгүй хүний асуудал нь улс хоорондын хууль тогтоомжийн зөрүүтэй байдлаас үүсдэг. Практикт “хоёрдмол харьяалал” гэж ярдаг хэдий ч “олон харьяалал” гэх нэр томъёо бий. Хоёрдмол харьяалал нь улсуудын иргэний харьяаллын тухай хуулийн зөрчилдөөн, тухайлбал, нутаг дэвсгэрийн зарчим, ураг төрлийн зарчмын зөрүүтэй байдлаас үүсдэг.

Дээрх асуудлын бодит байдал улсуудыг иргэний харьяаллын хууль тогтоомждоо энэхүү зөрчилдөөнийг харгалзан үзэхийг шаардаж байгаа юм.

Хувь хүн нэгэн зэрэг хоёр улсын иргэний харьяалалтай байх нь тухайн хүний эрх зүйн байдлыг төвөгтэй болгодог. Түүний улс төр, эрх зүйн тогтвортой холбоо нь хоёр буюу түүнээс дээш улсад хамаарч олон эрх, олон үүргийг үүсгэдэг.

### Хоёрдмол харьяаллын (бипадрид) тухай ойлголт

Хоёрдмол харьяалал гэдэг нь хувь хүний улс төр, эрх зүйн онцгой холбоо бөгөөд нэгэн зэрэг хоёр буюу түүнээс дээш улсын иргэний харьяалалтай байхыг хэлдэг.

ОХУ-ын Үндсэн хуульд “Холбооны хууль, олон улсын гэрээний дагуу ОХУ-ын иргэн өөр улсын иргэний харьяалалтай байж болно” гэж заасан. Тэгэхдээ өөр улсын иргэний харьяалалтай Оросын иргэн энэ үндэслэлээр эрх нь хязгаарлагдах, үүргээ биелүүлэх, эсвэл хариуцлага хүлээхээс чөлөөлөгдөхгүй.

Өөрийн хүснэгтээр (натурализаци) аль нэг улсын иргэний харьяалалтай болоод Оросын иргэний харьяаллаас гараагүй иргэн хоёрдмол харьяалалтай (бипадрид) болно.

Иргэний харьяаллын зөрчилдөөнтэй асуудлыг олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах замаар шийдвэрлэж болно. Үүнтэй холбоотой хоёр төрлийн олон улсын гэрээ байдаг.



## Хоёрдмол харьяаллын асуудлыг шийдвэрлэх арга зам

1. Хоёрдмол харьяаллын үр дагаврыг арилгахад чиглэсэн олон улсын олон талт гэрээ:

- Иргэний харьяаллын тухай хуулиудын зөрчилдөөнтэй холбоотой зарим асуудлын тухай конвенц (Гаага, 1930 он),
- Иргэний олон харьяаллыг багасгах болон олон харьяалалтай иргэний цэргийн үүргийн тухай конвенц (Страсбург, 1963 он).

Олон улс хоёр талт гэрээ байгуулан хоёрдмол харьяаллын асуудлыг устгах биш харин зохицтойгоор шийдвэрлэхийг зорьдог.

- Баруун Европын улсуудын ихэнх нь хоёр талт гэрээ, хэлэлцээр байгуулан хоёрдмол харьяалалтай иргэний цэргийн алба хаах үүргийг тусгасан байдаг.
- ЗСБНХУ, Канад Улсын хооронд хоёр улсын иргэний харьяалалтай иргэдийг аль нэг улсад нэвтрэхэд саад тотгор болохгүй байх тухай гэрээг 1967 онд байгуулсан.
- ОХУ, Туркменстан Улсын хооронд хоёрдмол харьяаллын асуудлыг зохицуулах тухай хэлэлцээр (Ашхабад, 1993 он),
- ОХУ, Таджикстан Улсын хооронд хоёрдмол харьяаллын асуудлыг зохицуулах тухай хэлэлцээр (Москва, 1995 он).

Иргэний харьяаллын тухай Европын конвенц (Страсбург, 1997 он) олон харьяаллыг хүлээн зөвшөөрсөн төдийгүй түүнийг хэрхэн зохицуулах зохицуулалтыг тусгасан.

2. Хоёрдмол харьяаллыг арилгахад чиглэсэн гэрээ:

- Монгол Улс, ОХУ-ын хооронд хоёрдмол харьяалал үүсгэхгүй байх тухай гэрээ (1937 он)-нд өөрийн хүсэлтээр (натурализаци) аль нэг улсын иргэний харьяалалтай болж хоёрдмол харьяалал үүсгэхгүй байх тухай тохиролцсон.
- 1956-1958 оны хооронд социалист гэгдэх Югослав, Болгар, Румын, Польш, Чехословак, Орос улсууд хоёр талт гэрээ, хэлэлцээр байгуулсан.

## Хоёрдмол харьяалал үүсэх нөхцөл шалтгаан

1. Ихэнхдээ хоёрдмол харьяалал үүсэх нөхцөл нь улсуудын хууль тогтоомжийн зөрүүтэй байдлаас шалтгаалдаг. Тухайлбал, зарим улс “ураг төрлийн” зарчмаар (Монгол, Швейцарь, Румын, Болгар, Хятад зэрэг) төрсөн хүүхдэд эцэг, эхийнх нь харьяаллын дагуу иргэний харьяалал олгодог бол зарим улс “нутаг дэвсгэрийн” зарчмаар (Америк, Англи, Унгар, Канад, Итали) тухайн улсын нутаг дэвсгэрт төрсөн хүүхдэд бүрийг улсынхаа иргэний харьяалалтай болгодог байна.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА



Зарим улс нутаг дэвсгэрийн зарчмаар өөр иргэний харьяалалтай болсон хүүхдийг ураг төрлийн зарчмаар хаана төрснөөс үл хамааран өөрийн иргэний харьяалалтай болгодог.

2. Өөр улсын иргэнтэй гэр бүл болж тухайн улсын иргэний харьяаллыг автоматаар авах эрх зүйн зохицуулалттай улсад хоёрдмол харьяалалтай иргэн үүсдэг. Тухайлбал, Итали, Доминикан Улсууд,
3. Хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөг улсад өөрийн хүсэлтээр (натурализаци) иргэний харьяалалтай болоход,
4. Олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу.

## Хоёрдмол харьяаллын асуудлаарх улсуудын чиг хандлага

Дэлхийн улсууд хоёрдмол харьяаллын асуудлаар өөр өөр байр суурьтай байдаг.

Улсуудын хандлагыг 3 ангилж болно.

1. Хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөг (28.4%),
2. Хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй (30.3%),
3. Хоёрдмол харьяаллыг хязгаарлагдмал хүрээнд хүлээн зөвшөөрдөг (41.3%).

Хоёрдмол харьяаллыг хязгаарлагдмал хүрээнд хүлээн зөвшөөрөх гэдэг нь гол төлөв өөрийн иргэдийг хоёрдмол харьяалалтай байхыг зөвшөөрсөн заалтыг хууль тогтоомждоо тусгасан байдаг.

## Хоёрдмол харьяаллын үр дагавар

Хоёрдмол харьяалал нь эерэг, сөрөг үр дагавартай байдаг.

### Эерэг үр дагавар:

- Хоёрдмол харьяалалтай иргэн оршин сууж байгаа улсын иргэдийн нэгэн адил эрх, үүрэгтэй бөгөөд уугуул оронтойгоо соёлын болон бусад холбоо харилцаа нь хэвээр байдаг,
- Аль ч улсынхаа нутаг дэвсгэрт оршин суух, буцаж очих, холимог гэр бүлээ хадгалах эрхтэй,



- Хүлээн авагч улс нь хоёрдмол харьяалалтай иргэнд гадаадын иргэнээс хөнгөн ханддаг бол хөгжиж буй уугуул орон нь аль болох холбоо харилцаагаа таслахгүй байхыг чармайдаг,
- Хоёрдмол харьяалалтай олон хүн байх нь улс хоорондын харилцаа холбоог өргөжүүлэн хөгжүүлдэг. Хөгжлийн ерөнхий зүй тогтлоор хүн ядуу буурай орноос эдийн засгийн болон бусад нөхцөл байдал илүү газар, орон руу тэмүүлдэг учир хөгжиж буй орны иргэд хөгжингүй оронд оршин суух нь элбэг байдаг. Энэ нь бага буурай орны ажилгүйдлийг багасгах, мөнгөн шилжүүлэг ирэх, хилийн чанадад мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх зэрэг олон давуу талтай.

### **Сөрөг үр дагавар:**

- Аль аль улсдаа цэргийн алба хаах, татвар төлөх зэрэг давхар үүрэг хүлээдэг.
- Хоёр улсын иргэний харьяалалтай учраас энэ хоёр улсдаа харилцан дипломат хамгаалалт өдлэх боломжгүй.
- Зарим улсын хувьд хилийн чанадад (хоёрдогч оронд) үйлдэгдсэн тодорхой үйлдлийг эх орноосоо урвах гэж үздэг.
- Улс хоорондын харилцаанд хүндрэл учруулдаг. Нэг талаас хоёр улс тухайн иргэнийг өөрийн гэж үзэх, нөгөө талаас гуравдагч улс ямар нэгэн шалтгаанаар хоёрдмол харьяалалтай хүний харьяалах улсыг нь шилж сонгох болдог.
- Хоёрдмол харьяалал нь соёлын, хэлний, бусад ямар ч хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэдэггүй.

### **Харьяалалгүй хүн (апатрид)**

Улсуудын иргэний харьяаллын хууль тогтоомжийн зөрчилдөөнөөс хувь хүн аль ч улсын иргэний харьяалалгүй болох тохиолдол бий. Гол төлөв хэн нэгэн өмнөх иргэний харьяаллаа дуусгавар болгоод, өөр улсын иргэний харьяалалтай болж чадахгүйгээс үүсдэг.

Хоёр янзаар харьяалалгүй хүн үүсдэг.

1. Төрснөөр иргэний харьяалалгүй болох (зарим улсын хуульд харьяалалгүй хүнээс төрсөн хүүхэд харьяалалгүй хүн болдог),
2. Иргэний харьяаллаа алдсанаар иргэний харьяалалгүй болох.

Сөрөг үр дагавар нь харьяалалгүй хүн ямар ч улсад иргэний эрхээ эдлэж чаддагтгүйд байгаа юм. Харьяалалгүй хүнийг үүсгэхгүй байх арга зам нь улсууд үндэсний хууль тогтоомжийн зохицуулалтаар дамжуулан иргэний харьяалалтай

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

болгож болох юм. Тухайлбал, ОХУ-ын “Иргэний харьяаллын тухай хууль”-иар харьяалалгүй хүүхэд төрөхөд ОХУ-ын иргэний харьяалалтай болгодог.

Харьяалалгүй хүнийг багасгах арга нь улсууд хууль тогтоомжоо нэг мөр болгох, эсвэл олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах замаар тохиролцож болно.

Дээрх зорилгоор 1930 онд Гаага хотноо хуралдсан олон улсын хурлаас өөр улсын иргэний харьяалалтай болоогүй байхад нь өмнөх улс нь иргэний харьяаллас гаргахгүй байх, түүнчлэн өөр улсын иргэнтэй гэр бүл болсон эмэгтэйчүүдийг өөрийн улс нь иргэний харьяаллас хасахгүй байх зарчим дэмжлэг авч чадсан.

Орчин үед харьяалалгүй хүний эрх зүйн байдлыг 1954 оны “Харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай конвенц”, 1961 оны “Харьяалалгүй байдлыг багасгах тухай конвенц”-аар зохицуулдаг.

## **Хяналтын асуулт:**

1. Хоёрдмол харьяалалтай хүн үүсэх шалтгаан нь дан ганц улсуудын хууль тогтоомжийн зөрүүтэй байдлаас үүсч байгаа гэж ойлгож болох уу?
2. Хоёрдмол харьяаллын асуудлаарх дэлхийн нийтийн чиг хандлагыг тодорхойлно уу. Манай улс энэ талаар ямар байр суурьтай байдаг вэ?
3. Хоёрдмол харьяалалтай иргэдийн асуудлыг хэрхэн зохицуулах вэ?
4. Харьяалалгүй хүн үүсэх шалтгаан, үр дагаврыг тодорхойлно уу.
5. Эрх зүйн үүднээс харьяалалгүй хүн үүсэх нь ямар үр дагавартай вэ? Тэдний эрх зүйн байдлыг хэрхэн зохицуулах вэ?
6. Харьяалалгүй байдлыг эрх зүйн хувьд багасгана гэдгийг хэрхэн ойлгож байна?

## **Эх сурвалж**

1. Авакьян С.А. Россия: гражданство, иностранцы, внешняя миграция. М., 2003.
2. Иргэний харьяаллын тухай хуулиудын зөрчилдөөнтэй холбоотой зарим асуудлын тухай конвенц. 1930.
3. Харьяалалгүй байдлыг багасгах тухай конвенц. 1954.
4. Харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай конвенц. 1948.
5. Иргэний харьяаллын тухай Европын конвенц. 1997.
6. Монгол Улсын Харьяатын тухай хууль. 1993.



## СЭДЭВ 4. Гадаадын иргэн

**Сэдвийн зорилго:** Олон улсын харилцаа өргөжин хөгжлийг, иргэд харилцан зорчих нь ихэсч байгаа онөө үед гадаадын иргэн гэж хэн болох, түүний эрх зүйн байдлыг тодорхойлох нь чухал ач холбогдолтой. Энэ хүрээнд гадаадын иргэний эрх, үүрэгтэй холбоотой олон улсын хэм хэмжээг судлах, улсуудын иргэний харьяаллын тухай хуулийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулан дүгнэлт өгөх чадваф эзэмшигүүлэхэд чиглэгдэнэ.

### Сэдвийн товч агуулга:

Улс орнууд гадаадын иргэний эрх зүйн байдлыг олон улсын хэм хэмжээ дээр тулгуурлан үндэсний хууль тогтоомжоор зохицуулдаг.

Гадаадын иргэн оршин суугаа, эсвэл байгаа улсынхаа хууль тогтоомжийн дагуу зохих эрхийг эдэлж, холбогдох уүргээ хэрэгжүүлэх үүрэгтэй. Тухайн улс нь гадаадын иргэний эрх зүйн байдлыг тогтоохдоо олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмыг зөрчих эрхгүй. Гэхдээ улс орны тусгаар тогнол, аюулгүй байдалтай холбоотойгоор гадаадын иргэний эрхийг хууль тогтоомжоор хязгаарлах нь бий.

### Гадаадын иргэний тухай ойлголт

“Гадаадын иргэн” гэж байгаа улсынхаа иргэний харьяалалгүй бөгөөд өөр улсын иргэний харьяалалтайг нотлох баримттай хүнийг хэлдэг. Өөр улсын иргэний харьяалалтайг нотлох гол баримт нь хүчин төгөлдөр паспорт буюу түүнтэй дүйцэхүйц биеийн байцаалт байх ёстой.

Хэрэв иргэний харьяаллыг нь нотолсон баримт бичгийн хугацаа дууссан, түүнийг сунгуулах боломжгүй тохиолдолд байгаа улсынхаа нутаг дэвсгэрт харьяалалгүй хүнд тооцогдоно.

Гадаадын иргэн өөр улсын нутаг дэвсгэр дээр хууль ёсоор оршин сууж байж өөрийн улсаас хамгаалалт авах болно. Хэрвээ өөр улсын нутаг дэвсгэр дээр хууль бусаар оршин сууж байгаа бол албадан гаргагдах, бусад хуулийн хариуцлага хүлээх болно.

### Гадаадын иргэний эрх зүйн байдал

Гадаадын иргэний эрх зүйн байдал гэдэг нь тухайн улсын нутаг дэвсгэр дээрх гадаадын иргэний эрх, үүргийн нэгдлээр тодорхойлогдоно. Уламжлал ёсоор эрх зүйн байдлыг гурван хэлбэрээр тодорхойлсон байdag. Үүнд: үндэсний, илүү таатай, тусгай.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

- Үндэсний гэдэг нь тухайн улсад аль ч хүрээнд гадаадын иргэд өөрийн иргэдтэй нь адил байх,
- Аль нэг салбарт гадаадын иргэдэд гуравдагч орны иргэдийг бодвол илүү тааламжтай эрх эсвэл хөнгөлөлтэй үүрэг хүлээлгэх явдал. Энэ нь ихэвчлэн худалдааны болон шилжих хөдөлгөөний салбарын гэрээ, хэлэлцээрийн нөхцөлд тусгагддаг. Ихэвчлэн харилцаан адил байх зарчим дээр үндэслэлдэг. (хил орчмын иргэдийг улсын хилээр хялбаршуулсан байдлаар нэвтрүүлэх зэрэг)
- Тусгай дэглэм нь аль нэг салбарт зөвхөн гадаадын иргэдэд зориулсан өөрийн иргэдээс ялгаатай тусгайлсан эрх, үүргийг тогтоодог. (агаарын хөлгийн экипажийн бүрэлдэхүүнд гадаадын иргэнийг оруулахыг хориглох зэрэг)

## Гадаадын иргэний зарим эрхийн тухай

Гадаадын иргэн оршин суугаа, эсхүл байгаа орондоо цэргийн алба хаах үүрэгтүй. Гадаадын иргэнийг мэдээж өөрийн иргэний харьяалалтай улсынхаа эсрэг буу агсах байдалд хүргэхгүй. Гэхдээ сүүлийн үед улсуудын хууль тогтоомж энэ зарчмаас холдож байгаа нь ажиглагдаж байна. Зарим улсад гэрээгээр эсвэл зан заншлын хэм хэмжээгээр зарим гадаадын иргэнийг цэргийн албанц татах тохиолдол гарч байна.

Сайн дурын үндсэн дээр өөр улсын цэрэгт алба хаах нь олон улсын эрх зүйд харштахгүй хэдий ч энэ байдал нь өөрийн иргэний харьяалалтай улсад нь хариуцлага хүлээлгэх үндэслэл болж болно.

## Өөр улсын хилээр орох, гарах журам

Улс, тусгаар улс болохынхoo хувьд үндэсний хууль тогтоомжоороо иргэдийн улсын хилээр орох, гарах, дамжин өнгорөх дэглэмийг зохицуулдаг. Орчин үед гадаад, дотоодын иргэдэд аль алиинд нь зөвшөөрлийн үндсэн дээр улсын хилээр орох, гарах харилцааг зохицуулж байна. Зарим үед олон улсын гэрээ, хэлэлцээрийг үндэслэн хялбаршуулдаг.

Гадаадын болон дотоодын иргэдэд аль нэг улс руу орох, аль нэг улсаас гарахыг хязгаарлаж болно. Өөрийн иргэнээ улсаас гарахыг хязгаарлах нь тодорхой хугацаагаар хязгаарлагдаж болох боловч бүр мөсөн хязгаарлах нь хүний эрхийг (аль нэг улсыг түүний дотор өөрийн улсыг орхиж явах эрх ) зөрчиж буй хэрэг юм.

Гадаадын иргэнийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын үйл явцад байгаа зэрэг тодорхой, онцгой асуудлын улмаас гарахыг хориглож болно.

Улс орнууд гадаадын иргэнийг өөрийн улсын нутаг дэвсгэрт оруулах эсэхийг үндэсний хууль тогтоомжоор хязгаарладаг. Үүнд нь өөр улсууд шахалт үзүүлэх боломжгүй юм. Улсууд өөр улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох эрхгүй.



Олон улсын эрх зүйд өөрийн иргэнийг нөгөө улс хилээрээ нэвтрүүлэхгүй тохиолдолд өөрийн иргэнээ авахыг үүрэг болгосон байdag.

### Эрүүгийн шүүн таслах эрх

Улс бүр өөрийн иргэнийг эрүүгийн хэрэгт яллах асуудлыг үндэсний хууль тогтоомжоор зохицуулдаг. Өөрийн иргэнийг улсынхаа нутаг дэвсгэрт, зарим тохиолдолд хилийн чанадад гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татдаг.

Гадаадын иргэн байгаа улсдаа гэмт хэрэг үйлдсэн бол тухайн улсын хуулийн дагуу хариуцлага хүлээнэ. Олон улсын эрх зүйд гадаадын иргэн өөр улсад үйлдсэн гэмт хэргийн төлөө байгаа улсынх нь эрх ашгийг хөндөөгүй тохиолдолд хариуцлага хүлээхгүй тухай заалт бий. Энэ үед гэрээ, хэлэлцээрт үндэслэсэн гэмт этгээдийг шилжүүлэн өгөх асуудал үүснэ.

### Дипломат хамгаалалт

Хилийн чанадад байгаа иргэнээ хамгаалах дипломат хамгаалалт нь орчин үеийн олон улсын эрх зүйн чухал институтын нэг хэсэг юм.

Дипломат хамгаалалт нь зөвхөн хилийн чанадад байгаа иргэнээ хамгаалахаар хязгаарлагдахгүй төлөөлөгчөөр дамжуулан иргэнийхээ талаар сонирхсон мэдээллээ авах эрх юм. Дипломат хамгаалалт нь хуулийн хүрээнд явагдах бөгөөд хязгааргүй эрх өдлэх хэрэг биш.

Гадаадын иргэн байгаа улсынхаа хууль тогтоомжийг үнэхээр зөрчсөн бол дипломат хамгааллын хүрээнд нөхцөл байдлыг тодруулах, шаардлагатай бол өмгөөлөгчөөр хангагдах эрхтэй.

Олон улсын эрх зүйн хүрээнд улс орон хилийн чанадад байгаа иргэдээ хамгаалах, түүнийг нь бусад улс хүндэтгэн үзэх үүрэгтэй. Энэ эрхийг хэрэгжүүлэх эсэх нь улс орны үндэсний хууль тогтоомж, улс төрийн үзэл бодлоос шалтгаална.

Энэ асуудалд улс бүр өөр ханддаг. Тухайлбал, зарим улс хилийн чанадад байгаа иргэний эрх зөрчигдсөн тохиолдолд заавал хамгаалах ёстой гэж заасан байхад зарим улс дипломат болон консулын газрын шийдэх асуудал мэтээр үзсэн байдаг.

### Хяналтын асуулт:

- Гадаадын иргэн гэж хэн бэ? Монгол Улсын жишээгээр тайлбарлана уу.
- Гадаадын иргэний эрх зүйн байдлыг хэрхэн тогтоох вэ?
- Гадаадын иргэний эрх зүйн байдлыг тайлбарлана уу.
- Улс орны аюулгүй байдал ба иргэдийн хилээр орох, гарах асуудал хэрхэн холбогдох вэ?

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

5. Ямар эрх зүйн хүрээнд дипломат хамгааллыг үзүүлдэг вэ?
6. Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх асуудлыг хүний эрхийг хамгаалах асуудалтай хэрхэн холбож болох вэ?

## **Эх сурвалж**

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. //Төрийн мэдээлэл. I боть. УБ., 2004.
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. //Төрийн мэдээлэл. I боть. УБ., 2004.
3. Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1992.
4. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль. 2009.
5. Монгол Улсын виз олгох журам. //Мэдээлэл сэтгүүл. 2011. №2.
6. Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам. //Мэдээлэл сэтгүүл. 2011. №2.
7. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тоолох журам. //Мэдээлэл сэтгүүл. 2011. №2
8. Амарсаная Ж. Хүний эрх. Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал. УБ., 2000.
9. Гэрэлчулун Х.Гадаад шилжих хөдөлгөөн, түүний эрх зүйн зохицуулалт. Эрх зүйн үзэл баримтлал: шинэ хандлага. Олон улсын бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2012



## III БҮЛЭГ. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ

### СЭДЭВ 1. Шилжих хөдөлгөөний тухай ойлголт

**Сэдвийн зорилго:** Хүн амын шилжих хөдөлгөөн нь даяаршилын үйл явцыг тодорхойлогч, түүний салшгүй хэсэг болохынх нь хувьд түүний төн чанаф, тодорхойлогч хүчин зүйлийг судлах, танин тэдэх, түүнд дүн шинжилгээ хийх, уг асуудлын олон улсын эрх зүй дэх байр суурийг тодорхойлох чадваар эзэмшиүүлэхэд оршино.

#### Сэдвийн товч агуулга:

Шилжих хөдөлгөөн нь – хүн байнга оршин суух газраа урт, богино хугацаагаар сольж байгаа нийгмийн үзэгдэл. Гол шинж нь нутаг дэвсгэрийн хувьд өөрчлөгдөх явдал юм.

Хүн амын шилжих хөдөлгөөн нь улс орны эдийн засаг, улс төр, хүн ам зүйн хөгжилд онцгой нөлөө үзүүлдэг. Хүн амын шилжих хөдөлгөөнийг нэг талаас зайлшгүй, ашигтай үзэгдэл хэмээн ойлгох хандлага байдаг бол, нөгөө талаас орчин үеийн шийдвэрлэхэд хүндрэлтэй, хурц асуудлын нэг гэж үзэх нь бий. Тухайлбал, гаднаас ирж байгаа хүн амын урсгал нь хөгшрөлтийн хувь ихтэй, төрөлт багатай улсын хүн ам зүйн бүтцийг сайжруулан чадваржуулдаг. Олон улсын хөдөлмөрийн шилжих хөдөлгөөн нь тухайн улсын эдийн засгийн хөгжилд аятайгаар нөлөөлж гадаад эдийн засгийн харилцааг идэвхжүүлдэг.

#### Шилжих хөдөлгөөний онол

Хамгийн анхны шилжих хөдөлгөөнтэй салшгүй холбоотой шинжлэх ухааны бүтээлийг (1885-1889) Английн эрдэмтэн, судлаач Е.Равенштейн Лондоны их сургууль дээр хийж, шилжих хөдөлгөөний үйл явц зайлшгүй юм гэдгийг шинжлэх ухааны үүднээс нотлохын зэрэгцээ “Хүн оршин суугаа газраа байнгын болон түр зуурын хугацаагаар өөрчлөхийг хүн амын шилжих хөдөлгөөн гэнэ” гэсэн тодорхойлолтыг гаргасан.

Е.Равенштейний дүгнэснээр эдийн засгийн шалтгаан нь шилжих хөдөлгөөний чухалхүчин зүйлүү. Шилжих хөдөлгөөний үйль явц нь өөрийн гэсэн шат дамжлагатай. Хүмүүс эхлээд ойрхны тосгон суурин руу, дараа нь худалдаа, үйлдвэрийн хөгжил сайтай том хот руу нүүдэллэдэг. Шилжих хөдөлгөөний урсгалын эрч нь газар зүйн хоёр байрлалын зайнаас харилцаан хамааралтай. Шилжих хөдөлгөөний томоохон хэмжээний урсгал бүр нь өөрийгөө нөхөх “шилжих хөдөлгөөний цэвэр жин”-гийн үзүүлэлтээр илэрхийлэгдэх “эсрэг урсгал”-ыг бий болгож байдаг. Хүн амын шилжих хөдөлгөөн нь техникийн дэвшил, харилцаа холбооны хөгжлийн хэрээр нэмэгддэг.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

Шилжих хөдөлгөөний нэгэн шинж бол нутаг дэвсгэрийн хувьд засаг захиргааны, мөн цаашлаад улсын хил хязгаарыг давах явдал юм. Энэ шинж байдлаар нь гадаад, дотоод шилжих хөдөлгөөн гэж ангилдаг.



## Дотоод шилжих хөдөлгөөн

Дотоод шилжих хөдөлгөөн гэдэг нь хүмүүс аливаа нэгэн улсын нутаг дэвсгэрийн дотор урт болон богино хугацаагаар байнга оршин суух газраа өөрчлөхийг хэлнэ. Энэ хүрээнд шилжигчид өөрийн улсынхаа дотор засаг захиргааны нэг нэгжээс нөгөөд, суурингаас сууриннд, эсвэл суурингаас хот руу гэх зэргээр шилжин явдаг.

Шилжих хөдөлгөөний эрчимжилт нь нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчин зэрэг олон хүчин зүйлээс хамаарч өөрчлөлтийн хэмжүүр болдог.

### Дотоод шилжих хөдөлгөөний тулгамдсан асуудал нь:

- хүн амын байршил тэнцвэртэй бус болох (нэг нутаг дэсгэрт хэт төвлөрөх, зарим газар нутаг эзэнгүйдэх),
- хотжилтын эрх хүч нэмэгдэх,
- хууль бус шилжин суурьшигч нэмэгдэх,
- хөгжлөөс гадуур үлдэгсдийн тоо нэмэгдэх,
- төлөвлөлтөд тусгагдаагүй газар нутагт суурьшил бий болж эдийн засагт хүндрэл учруулах зэрэг.

Дотоод шилжих хөдөлгөөний бодлогыг хэрэгжүүлснээр хүн амыг зохицтой нутаг дэсгэрт жигд байршуулах, нийгэм, эдийн засгийн зорилтуудыг амжилттай шийдвэрлэхэд чухал нөлөөтэй.

## Гадаад шилжих хөдөлгөөн

Гадаад шилжих хөдөлгөөн нь хүмүүс байнга оршин суугаа газраа өөрчлөхдөө улсын хил хязгаарыг давж өөр улсад шилжин очдоороо онцлогтой. Гадаад шилжих хөдөлгөөнийг гол төлөв “олон улсын” гэж нэрлэдэг. Олон улсын шилжих хөдөлгөөн



нь хүмүүсийн гадагш шилжин явж байгаа (эмиграци), гаднаас шилжин ирж байгаа (иммиграци) хоёр урсгалтай. Гадагш шилжин явж байгаа буюу эмиграци нь хүмүүс нэг улсаас нөгөө улсад түр болон урт хугацаагаар оршин суухаар гарч явж байгааг, харин эсрэгээрээ шилжин ирж байгаа буюу иммиграци нь тухайн улсад өөр улсаас урт, богино хугацаагаар байнга оршин суухаар ирж байгаа шилжигчийн урсгалыг хэлнэ.



### Гадаад шилжих хөдөлгөөний эерэг ба сөрөг талууд илгээгч орны жишээн дээр:

Эерэг тал	Сөрөг тал
<ol style="list-style-type: none"> <li>Ажиллах хүчийг илгээж “экспортлож” байгаа оронд ажилгүйдэл багасч, ажилгүйчүүд, тэдний гэр бүл, ур хүүхдэд олгодог нийгмийн халамж, үйлчилгээний зарлага багасна.</li> <li>Гадаадад ажиллаж байгаа шилжигч өөрийн орлогын хэсгийг уугуул орондоо шилжүүлдэг нь тэр улс орны хүн амын амьдрал ахуй, төлбөрийн балансыг дээшлүүлдэг.</li> <li>Хилийн чанадад ажиллаж байгаа хөдөлмөрийн шилжигчид илүү өндөр мэргэжил эзэмшиж, боловсролын түвшнөө дээшлүүлэх боломжтой.</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>Үндэсний тодорхой нөөц хөрөнгөе зарж нөхөн үйлдвэрлэлд ажиллах боловсон хүчинийг бэлтгэсэн нь хожим нь гадаадад гарснаар дотоодын нийт бүтэгдэхүүнийг өөрийн улсад биш түүний ажиллаж байгаа хүлээн авагч улсад бий болгодог.</li> <li>Шилжин явагчдаас шилжүүлж байгаа хөрөнгө, мөнгө (капитал)-ийг ирээдүйтэй гэж найдах боломжгүй. Шилжин явагчид цаг хугацааны эрхээр адилших, тухайн нутагтаа бүрмөсөн үлдэх үед тэр мөнгөн шилжүүлэг багасч, сүүлдээ бүр ирэхгүйд хурдэг байна.</li> <li>Хилийн чанадад шилжин явагчдын ихэнх нь мэргэжил, боловсролтой, ур чадвар өндөртэй, ажил хөдөлмөр эрхлэх чадвартай, авхаалж самбаатай, насны хувьд залуу хүн амын хэсэг байдаг</li> <li>“Оюуны гадагшлах урсгал”-ын ур нөлөөг одоогоор тооцоолоогүй ч илгээгч орны шинжлэх ухаан, техникийн салбарт сөргөөр нөлөөлдөг.</li> </ol>

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

<p>Гадаадад ажиллаж байгаад буцаж ирэгчид ур чадвар, ажлын дадлана туршлагад суралцаж ирдэг. Тэд шинэ мэдлиг чадвар, технологийг эх орондоо дэлгэрүүлдэг.</p> <p>4. Түр хугацаагаар гадаадад ажиллахаар явсан шилжигчид буцаж эх орондоо ирэхдээ капиталыг мөнгөн ба материалыг хэлбэрээр авч ирдэг байна.</p>	<p>5. Их хэмжээний хөрөнгө мөнгө, орлоготой өмчийн эзэд байнга болон түр хугацаагаар оршин суухаар гадаадад гараадад улс орны дотоодод татвараар дамжсан төрийн болон хувийн салбарын санхүүжилт, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжилд оруулах хувь нэмэр багасана.</p> <p>6. “Оюуны гадагшлах урсгал”-ыг нөхцөлдүүлж буй шилжих хөдөлгөөн нь салбар, аж ахуйн нэгжийн бүтээмжийг бууруулах, бусад ажилчдыг ажлын байраа алдаад хүргэж болзошгүй.</p> <p>7. Гэр бүл салах, үр хүүхэд өнчрөх зэрэг зарим сөрөг үр дагавар нь эдийн засгийн гэхээсээ илүү нийгмийн шинжтэй байдаг.</p>
--	---

## Хяналтын асуулт:

1. Шилжих хөдөлгөөн, түүний онолын талаар ямар мэдээлэл авав?
2. Дотоод болон гадаад шилжих хөдөлгөөний эерэг, сөрөг талыг тодорхойлж харьцуулна уу.
3. Нийгмийн нөхцөл байдал гадаад шилжих хөдөлгөөний татах, түлхэх хүчин зүйл болдогтой санал нийлж байна уу?
4. Гадаад, дотоод шилжих хөдөлгөөний бодлогын ялгаа юунд оршиж байна вэ?
5. Яагаад шилжих хөдөлгөөн олон улсын нийтийн эрх зүйн салбарт хамаардаг болохыг тайлбарлана уу.

## Эх сурвалж

1. Амарсанаа Ж. Хүний эрх. Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал. УБ., 2000.
2. Гэрэлчулун Х. Хүн амын шилжих хөдөлгөөн. УБ., 2010.
3. Гадаадын иргэн, харьятын асуудал эрхлэх албаны тогтолцоо. УБ., 2008.
4. Монголын харьят. Цагаачлалын түүх. Ц.Нэргүй, Н.Золзаяа, Х.Мэндсайхан УБ., 2006.
5. Малахова В.С, Яковлева А.Ф. Гражданство и иммиграция. М., 2013.
6. Ravenstein E. The Laws of Migration //Journal of the Royal Statistical Society. 1885.



## СЭДЭВ 2. Шилжих хөдөлгөөний бүтэц ба ангилал

**Сэдвийн зорилго:** Ямарваа нэгэн юмс үзэгдэл, түүний тухай ойлголтыг модорхой шинж чанаараа нь ангилан авч үзэх нь түүний мөн чанарыг гүнзгийрүүлэн судлах, нэгтгэн дүгнэх, харьцуулахад хялбар байдаг. Шилжих хөдөлгөөний бүтэц, ангиллыг судалснаар түүний агуулга зорилго, шалтгаан нохцөл, хэлбэрийг судалж дүгнэлт өгөх чадварыг хөгжүүлэхэд ошино.

### Сэдвийн агуулга:

Ямарваа нэгэн юмс үзэгдэл, түүний тухай ойлголт нарийн төвөгтэй байх тусмаа ангилал нь олон янз байх нь бий. Ийм ч учраас судлаачид шилжих хөдөлгөөний үйл явцыг олон шинжээр нь янз бүрээр ангилан авч үздэг.

### ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙГ ТӨЛӨВЛӨСӨН АРГА ХЭЛБЭР



Хүн амын шилжих хөдөлгөөнийг эргэх холбоо үүсгэх шинж ба хугацаагаар нь буцах, үл буцах гэж ангилна. Буцах шилжих хөдөлгөөнд улирлын чанартай, мөн давтамжит маягийн хөдөлгөөн багтана.

Улирлын чанартай гэдэгт шилжигч нутаг дэвсгэрээ түр зуур сольж байгааг ойлгоно. Энэ төрлийн шилжигчид гол төлөв улирлын чанартай ажил, үйлчилгээ эрхлэх зорилгоор амьдрах орчноо түр хугацаагаар сольдог. Энэ ангиллын шилжигчдэд өөр хотод суралцдаг, амралт, эмчилгээнд явдаг хүмүүсийг ч оруулах нь бий.

Давтамжит маягийн шилжигчид нь оршин суугаа нэг газраас нөгөө рүү ажил эрхлэх, суралцахаар ирээд буцах байнгын эргэлтэд байхыг хэлдэг. Гол төлөв багавтар хот, суурингийн хүмүүс ажил, хөдөлмөр эрхлэхээр ийм маягийн хөдөлгөөний оролцогч болдог.

Шилжих хөдөлгөөнийг хэлбэрээр нь сайн дурын буюу сайн дурын бус (албадлагын) гэж хуваадаг. Хүн байнга оршин суугаа газар, эх орноо орхиж шинэ газар, шинэ улс оронд оршин суухаар өөрийн хүсэл сонирхлын дагуу, хэн нэгний албадлагагүйгээр шилжихийг сайн дурын шилжих хөдөлгөөн гэж нэрлэдэг.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

Хүмүүс өөрсдөө, эсвэл гэр бүлийн гишүүний аль нэг нь мөрдлөг, хавчлага, дарамт шахалт, зарим үед эдийн засаг, байгаль орчин, техник технологи, дайн байлдаан, зэвсэгт мөргөлдөөн зэргээс болж байнга оршин суугаа газраа өөрчлөхөд хүрдэг бөгөөд үүнийг сайн дурын бус шилжих хөдөлгөөн гэж нэрлэдэг. Эдгээр хүмүүс гол төлөв дүрвэгч болдог.

## Шилжих хөдөлгөөний шалтгаан


Шилжих хөдөлгөөний шалтгааныг танин мэдэхийн тулд “шалтгаан” хэмээх ухагдууныг ойлгох ёстой болдог. Байгаль дэлхий, нийгэм, бодол санаанд болж байгаа бүх үйл явдал, үйл явц өөрийн гэсэн бусад үйл явдал, үйл явцаас шалтгаалж байдаг нь тодорхой. Ямарваа нэгэн үйл явц нөгөө үйл явцынхаа шалтгаан болж, өөроөр хэлбэл эхнийх нь нэг үйл явцыг үүсэх, бий болох урьдчилсан нөхцөл болдог бол нөгөө нь тэр үйл явцыг хөгжих, өөрчлөгдөх шалтгаан нь болдог байна. Тэгэхээр зэрэгцүүлэн тавьж буй сайн дурын болон сайн дурын бус шилжих хөдөлгөөний гол утга санаа нь шинэ нутаг оронд нүүж очих, эсвэл орогнол хүсэх шалтаг болж байгааг гэрчилж буй хэрэг.

Олон багц хүчин зүйлс шилжих хөдөлгөөнийг залуурдаж байдал бөгөөд гол шалтгаан нь:

- ядуурал, дайн, гамшиг, мөрдлөг хавчлага, шахалт,
- хүн амын ачаалал,
- улс орны хөгжлөөс улбаатай цалин, орлогын тэгш бус байдал,
- хэт хотжих явц,
- хүний эрхийн баталгаагүй байдал,
- улс хоорондын тээвэр, харилцаа холбоо, үйлчилгээний хөгжлийн түвшин зэрэг хүчин зүйлс ч байна.

Энэ утгаараа шилжих хөдөлгөөнийг:

- эдийн засаг,
- улс төр,
- цэрэг дайн,
- байгаль орчин,
- хүн ам зүйн гэж ангилж үздэг.



Хууль ёсны, эсвэл хууль бус гэдэг нь гадаадын иргэн, харьяалалгүй хүн аль нэг улсын нутаг дэвсгэрт нэвтрэн орох, дамжин өнгөрөх, гарах, оршин суухдаа тухайн улсын хууль тогтоомжоор зохицуулагдсан журмыг зөрчсөн эсэхээр нь ангилж байгаа хэрэг. Өөрөөр хэлбэл, шилжих хөдөлгөөний хууль ёсны, хууль бус байдал нь юуны өмнө тухайн этгээд аль нэг улсын нутаг дэвсгэрт хууль журмын дагуу нэвтэрч, зохих зөвшөөрлийн дагуу оршин сууж байгаа шинжээр тодорхойлогдоно.

#### ***Хяналтын асуулт:***

1. Шилжих хөдөлгөөнийг ангилахын ач холбогдлыг тодорхойлно уу.
2. Шилжигчдийн хууль ёсны, хууль бус гэдгийг хэрхэн тогтоох вэ, Жишээ авч тайлбарлана уу.
3. Шилжих хөдөлгөөний шалтгаан гэж юу вэ?
4. Улс төрийн шилжих хөдөлгөөний талаар тайлбарлана уу.
5. Хөдөлмөрийн шилжих хөдөлгөөн гэж юу болох, ямар урсгалтай болохыг хэлнэ уу.

#### ***Эх сурвалж***

1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль. УБ., 2009.
2. Гэрэлчулун Х. Хүн амын шилжих хөдөлгөөн. УБ., 2010.
3. Бондырева С.К., Колесов Д.В. Миграция. Сущность и явление. М., 2007.
4. Ковалева А.А, Черниченко С.В. Международное право, М., 2006.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

## СЭДЭВ 3. Нийгэм ба шилжих хөдөлгөөн: нийгмийн төлөв байдал

**Сэдэвийн зорилго:** Хүн амын шилжих хөдөлгөөн үүссэн нөхцөл байдал, хүний нийглийн явцад хэрхэн хөгжсөн, шилжих хөдөлгөөний татах, түлхэх хүчин зүйл юу болохыг нэгтгэн дүгнэх чадвар өзөөшүүлэхэд оршино.

### Сэдэвийн товч агуулга:

Шилжих хөдөлгөөн нь хүн төрөлхтөний түүхийн бүхий л үед өөр өөрийн агуулга, шалтгаан, онцлог, шинж чанартай, бодитоор оршиж ирсэн. Шилжих хөдөлгөөн нь зөвхөн хувь хүний сонголтын үр дүн мэт харагдах боловч түүнийг бий болгосон улс орны амьжиргааны түвшний ялгаа, хүн амын өсөлт, нягтралын тэнцвэргүй байдал, хөгжлийн хүчин зүйл, илгээгч, хүлээн авагч улсын харилцаа, худалдаа, дэд бүтцийн эрчимтэй хөгжил зэрэг нийгэм-эдийн засгийн нийтлэг нөхцөлүүд шилжих хөдөлгөөний “татах”, “түлхэх” хүчин зүйл болдог онцлогтой.

### Эртний үеийн шилжих хөдөлгөөн

Хүй нэгдлийн үед хүмүүс үржил шим сайтай газар, бэлчээр эрэх, цаг уурын аятай нөхцөлийг хайж нүүдэллэдэг байжээ. Анхны овог аймаг Ази, Хойд Африк, Төв болон Өмнөд Европын нутгаар тархан байрлаж байсан.

Боолын нийгмийн үеийн хүн амын шилжих хөдөлгөөн нь эдийн засгийн таатай нөхцөлийг бий болгох, цэргийн байлдан дагуулал хийх, газар эзэмших, боол олзлох зорилготой байсан.

Феодалын нийгмийн эхэн үед илүү ажиглагдаж мөн л цэргийн язгууртуууд засгийн эрх барих байр сууриа бэхжүүлэх, бусад улсын ард түмнийг байлдан дагуулах, шинээр газар эзэмших, баяжих сонирхолтой нь холбоотой байв. Энэ зорилгоор НТ-ын V зуунд баруун франкчууд гали (odoogийн Франц)-д халдан довтолж, алеманчууд германы баруун урд хэсгийг эзлэн, англи, саксон, ютууд кельтуудыг шахан зайлцуулж британы арлуудад суурьшсан байна.

Шилжих хөдөлгөөний бас нэгэн чухал үе бол Европчууд үржил шим сайтай, аж ахуй эрхлэхэд таатай Хойд, өмнөд Америк, Австрали, Шинэ Зеланд, Сибирийг газар зүйн хувьд нээсэн явдал бөгөөд XVII зууны үеэс Англи, Франц, Испани, Орос болон Европын бусад орны шилжигчид шинэ газар нутаг эзэмшихээр их нүүдэл хийж эхэлсэн.

### XIX зууны үеийн шилжих хөдөлгөөн

Капиталист үйлдвэрлэлийн хөгжлийн үед олон оронд өрнөсөн шилжих хөдөлгөөн нь эдийн засгийн шалтгаанаас үүдэлтэй байв. Шилжих хөдөлгөөн



нь урьдын адил Хойд, Өмнөд Америк, зарим нь Австрали, Шинэ Зеланд, Өмнөд Африкийг чиглэж байсан.

XIX зууны 70-аад оныг хүртэлх хугацаанд шилжих хөдөлгөөнийг манлайлагчид нь гол төлөв Баруун, Хойд Европын орнуудаас гаралтай шилжигчид байсан бол энэ зууны төгсгөл рүү эсрэгээрээ Өмнөд болон Зүүн Европын улсуудын шилжигчдийн урсгал зонхиц, ойролцоогоор 50 сая хүн гадагш гарснаас ямар нэгэн шалтгаанаар дөнгөж гуравны нэг хувь нь л төрөлх нутагтаа эргэж ирсэн байна.

### **XX зууны үеийн шилжих хөдөлгөөн**

Энэ зуунд олон улсын шилжих хөдөлгөөний үйл явцын онцлог нь Зүүн Европын орнууд, түүний дотроос ОХУ-ын иргэдийн гадагш гарах урсгал идэвхжиж байгаатай холбоотой байна. Социалист нийгэмд иргэдийг гадаад улсад зорчихыг хязгаарладаг, хаалттай байснаас хүн амын шилжих хөдөлгөөний гол урсгалыг тосгон, суурингаас хот руу, эсвэл улс дотроо нэг улсаас нөгөө улс руу шилжсэн зэрэг дотоод шилжих хөдөлгөөн бүрдүүлж байсан бөгөөд энэ байдал 80-аад оны сүүлчээр үндсээрээ өөрчлөгдсөн. Энэ үед социалист гэгдэж байсан зарим улс задарч бутарснаас үүдэлтэй хүн амын шилжих хөдөлгөөний хяналтгүй урсгал бий болж, өнөөдөр энэ нь нийгмийн төвөгтэй асуудлын нэг болоод байна.

#### **Хяналтын асуулт:**

1. Шилжих хөдөлгөөн хэдийд үүссэн бэ? Шилжих хөдөлгөөн үүсэх шалтгаан нөхцөл юу байв?
2. Е.Равенштейны онол гэж юу вэ, түүний ач холбогдлыг дүгнэнэ үү.
3. Ye үеийн шилжих хөдөлгөөнийг харьцуулан онцлогийг тодорхойлно уу.
4. Хамгийн анх чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох эрхийг хаана хуульчилсан бэ?

#### **Эх сурвалж**

1. Хүний эрх, эрх чөлөөний тухай конвенц. 1963.
2. Гэрэлчулун Х. Хүн амын шилжих хөдөлгөөн. УБ., 2010.
3. Гэрэлчулун Х. Шилжих хөдөлгөөн ба Монгол Улс. «Эрдмийн ертөнц». УБ., 2010.
4. Хабриева Т.Я. Миграционное право России: Теория и практика. М., 2008.
5. Халх журам хууль. 1965.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

## Сэдэв 4. Шилжих хөдөлгөөний орчин үеийн чиг хандлага

**Сэдвийн зорилго:** Даяашилын үеийн томоохон үйл явцын нэг нь хүн амын шилжих хөдөлгөөн бөгөөд нийгмийн бүхий л салбарын нөлөөлдөг тул түүний цаашдын чиг хандлага, улс орнуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээг судлан дүгнэлт өгөх чадваар эзэмшиүүлэх зорилготой.

### Сэдвийн товч агуулга:

Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллагын тайланд дурдсандаар 2009 онд дэлхий дээр 193 сая хүн хүн төрөлх эх орноосоо ангид амьдарч байсан бол 2010 онд 214 сая болж өссөн байна. Мөн шилжигчдийн сүүлийн 10 жилийн өсөлтийн дундаж хурдыг харьцуулан тооцвол 2050 он гэхэд дээрх тоо 405 саяд хүрэх судалгаа байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн олон улс орны хөгжил хүн амын шилжих хөдөлгөөнөөс, тэр тусмаа олон улсын (гадаад) шилжих хөдөлгөөний үйл явцаас хамааралтай болох нь мэдрэгдэж байгаа билээ.

Нийгэм, эдийн застийн шинжтэй гадаад шилжих хөдөлгөөн нь нийгмийн амьдралын бүхий л үйл явцад нөлөөлдөг.

Зөв зохицуулсан хүн амын шилжих хөдөлгөөн нь хүний эрх, эрх чөлөөг хангаад зогсохгүй улс орныг хөгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, ард түмний итгэлцлийг нэмэгдүүлэх, харилцан ойлголцлыг бий болгох ач холбогдолтой.

### Шилжих хөдөлгөөний өнөөгийн нөхцөл байдал

Өнөөдөр хүн амын шилжих хөдөлгөөн дэлхийн бүх тив, улс орнууд, нийгмийн бүхий л давхрагыг хамарсан даяаршлын үйл явцын нэг хэсэг болж улс орнууд нэг бол илгээгч, эсвэл хүлээн авагч, угүй бол дамжуулагч болдог байна.

Урьдын адил гадны иргэдийг татах үндсэн төв нь Америк, Австрали, Канад байгаа бөгөөд эдгээр улсад ажил эрхэлдэг хүн амын 20-30 хувийг гадаадын иргэд эзэлж байгаа тооцоо байна. Мөн Бахрейн, Ливи, Саудын Араб, Катар, Кувейт, АНЭУ-д ажил эрхэлдэг хүн амын дотор гадаадын иргэдийн эзлэх хувь дээрхийн адил байдаг бол Баруун Европын орнууд дахь гадаад иргэдийн тоо ажил эрхэлдэг хүн амын 10-20 хувийг эзэлдэг ажээ.



## Улс орны хөгжилд шилжих хөдөлгөөний нөлөө

Эерэг талууд	Сөрөг талууд
<ul style="list-style-type: none"> <li>▶ хүн ам зүйн бүтэц сайжирна,</li> <li>▶ эдийн засгийн харилцаа өргөжине,</li> <li>▶ шинэ соёл нэвтэрнэ,</li> <li>▶ мэдлэг боловсролтой ажиллах хүч орж ирнэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▶ гэмт хэрэг зөрчил нэмэгдэнэ,</li> <li>▶ хууль бус шилжигчдийн нэгдэл- хяналтгүй зах зээл, үйлчилгээ бий болно,</li> <li>▶ гэр бүл салах, хүүхэд өнчрөх аюултай,</li> <li>▶ салбар, аж ахуйн нэгжийн бүтээмж буурах, бусад ажиллагсад ажлын байраа алдах эрсдэлтэй.</li> </ul>

### Хууль бус шилжих хөдөлгөөний үр дагавар

Орчин үед хууль бус шилжих хөдөлгөөний урсгал нэмэгдэх болсон нь тухайн улсын аюулгүй байдал, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж, үндэстэн дамнасан гэмт хэргийн өсөлтийн гол хүчин зүйл болж байна. Хууль бус шилжигчид нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, мөнгө угаах, зэвсгийн наймаа, цөмийн материалын худалдаа, хүн худалдаалах зэрэг гэмт үйл ажиллагаа эрхэлдэг бүлэглэлүүдтэй холбогдох нь олонтоо. Үүний сацуу аливаа улсад хууль бус шилжигчдийн үндэсний нэгдэл бий болох нь барааны хяналтгүй зах зээл, үйлчилгээ бий болох, тодорхой үйл ажиллагааны хүрээнд монополь байдал үүсэх нөхцөлийг бүрдүүлдэг бөгөөд энэ нь нутгийн уугуул иргэд, шилжигчдийн хооронд таагүй харилцаа, үл ойлголцлыг үүсгэх, үндэстэн хоорондын мөргөлдөөнийг өдөөх аюултай.

### Шилжих хөдөлгөөнийг зохицуулахын ач холбогдол

Улс орнууд шилжих хөдөлгөөнийг өөрийн хөгжилд ашигтайгаар зохицуулахыг эрмэлзэх болж, хөгжилд үзүүлэх үр нөлөөний талаар судалгааны ажлыг эрчимжүүлэхийн зэрэгцээ олон улсын, бус нутгийн, үндэсний хэмжээний онол, практикийн хурц маргааныг өрнүүлсээр байна.

Гадаад шилжих хөдөлгөөнийг зохицуулах гол аргын нэг бол олон улсын болон бус нутгийн хэмжээнд хоёр ба олон талт гэрээ, хэлэлцээр байгуулах явдал юм. Үүний зэрэгцээ улс орон бүр өөрийн хууль тогтоомжоороо дамжуулан шилжих хөдөлгөөний цэгцтэй бодлого боловсруулж хэрэгжүүлэх нь чухал байdag.

Гадаад шилжих хөдөлгөөний эерэг, сөрөг үр дагаврыг судалснаар тухайн үзэгдлийн мөн чанар, агуулга, онцлогийг мэдэрч, олон улсын эрх зүйн зохицуулалтад урьдчилан тусгах ач холбогдолтой.

Улс орнууд шилжих хөдөлгөөнтэй холбоотой бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхдээ хувь хүний болон нийтийн эрх ашиг, сонирхлын тэнцвэрийг зайлшгүй барих, өөреөр хэлбэл, улс орны эрэлт хэрэгцээнд сууринсан шилжигчдийн

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

эрх, эрх чөлөөг хангахыг эрмэлзэх учиртай. Энэ бүхэн гадаад шилжих хөдөлгөөнийг зохицуулсан олон улсын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, улмаар үндэсний хууль тогтоомжийг олон улсын энэхүү зохицуулалттай нийцүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

## ***Хяналтын асуулт:***

1. Шилжих хөдөлгөөний чиг хандлагыг судлахын ач холбогдол юу вэ?
2. Шилжих хөдөлгөөний цаашдын чиг хандлагыг жишээ авч тайлбарлана уу.
3. Шилжих хөдөлгөөний эерэг, сөрөг үр дагаврыг тодорхойлно уу.
4. Хууль бус шилжигчидтэй холбогдон үүсч болох асуудлын нийгэм, эдийн засаг, эрх зүйн учир холбогдлыг тодорхойлно уу.
5. Шилжих хөдөлгөөний зохицуулалт болон зохицуулсны ач холбогдлыг тайлбарлана уу.

## ***Эх сурвалж***

1. World migration report 2010. The future of migration: building capacities for change. Geneva. 2010.
2. Гэрэлчулун Х.Гадаад шилжих хөдөлгөөн ба эрх зүйн зохицуулалт. “Миграци ба түүх, даяаршил” Олон улсын эрдэм шинжилгээний VII хурлын эмхтгэл.УБ., 2010.
3. Монгол Улсын хүн ам зүйн хөгжлийн төлөв байдал. УБ., 2008.
4. Государственно-правовые основы миграции населения в Российской Федерации. Учеб. пособие для студентов. /Под ред. А.С.Прудникова, М.Л. Тюрина. М., 2006.
5. Хабриева Т.Я. Миграционное право России: Теория и практика. М., 2008.



## IV. БҮЛЭГ. ШИЛЖИГЧ -ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНЫ СУБЬЕКТ БОЛОХ НЬ

### Сэдэв 1. Шилжигчийн тухай ойлголт, тэдгээрийн төрөл

**Сэдвийн зорилго:** Олон улсын шилжих хөдөлгөөний эрх зүйн харилцаанд оролцогчдын бүтэц, олон улсын эрх зүйн хэм хэлжээ, хуулийг сонгон тэдний эрх зүйн байдлыг тодорхойлох, хүлээн зөвшөөрөх эрх зүйн үзэл барилтлалын талаар мэдлэг олгох, хэрэглэх чадваар эзэмшигүүлэхэд чиглэнэ.

#### Сэдвийн товч агуулга:

Олон улсын эрх зүйд аль нэг улсаас гадагш гарах, ногдоо улсаас шинэ газарт ирж урт, богино хугацаагаар амьдрах, оршин суух зорилготой шилжих хөдөлгөөний урсгалыг ерөнхий шинж тэмдэг, тодорхой араншингаар нь хэд хэдэн бүлэгт хувааж үздэг.

Олон улсын шилжих хөдөлгөөний үйл явцад оролцож байгаа хүмүүсийг шилжих хөдөлгөөний субъект буюу шилжигч (мигрант, migrant) гэж нэрлэдэг.

#### Шилжигч

Олон улсын шилжих хөдөлгөөний субъектыг оршин суугаа нутгаасаа гарч өөр улс оронд амьдрахаар явж байгаа шилжин явагч (эмigrant, emmigrant), өөр улс орноос шинэ газар нутагт амьдрахаар ирж байгаа шилжин ирэгч (иммигрант, immigrant) гэж ерөнхийд нь хувааж үздэг.



Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ) олон улсын шилжих хөдөлгөөний субъектыг албан ёсоор дараах хэлбэрээр ангилсан байна.

1. Тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суухаар шилжин ирэгчид;
2. Хүлээн авагч улстай харилцан тохиролцсон, тодорхой хугацаагаар ажиллах гэрээний ажилчид (гол төлөв мэргэжилгүй, мэргэжил багатай улирлын чанартай ажилчид);

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

3. Мэргэжилтнүүд (өндөр түвшинд бэлтгэгдсэн, боловсролтой, ажлын туршлагатай);
4. Хууль бус шилжин ирэгчид;
5. Аюул заналын улмаас эх орноо орхихоос аргагүй байдалд хүрсэн дүрвэгчид.

## Шилжигчдийн ангилал

Олон улсын шилжих хөдөлгөөний субъектыг дараах байдлаар тодорхойлж болно.

1. Шилжин явагч (эмigrant): янз бүрийн шалтгааны улмаас өөр оронд урт, богино хугацаагаар оршин суухаар шилжин явагч;
2. Дамжин өнгөрч байгаа шилжин явагч (эмigrantы транзитные): аль нэг улсын нутаг дэвсгэрээр дамжин гуравдагч оронд гарах зорилгоор дамжин өнгөрөгч;
3. Шилжин ирэгч (иммигрант): гадаадын иргэн, (харьяалалгүй хүн); өөр улсад амьдарч байгаад түр болон урт хугацаагаар оршин суухаар шилжин ирэгч; НҮБ-ын Дүрвэгчдийн эрх зүйн байдлын тухай конвенц (1951 он), түүний нэмэлт протокол (1967 он), болон тухайн улсын хуулийн дагуу дүрвэгчээр өргөдлөө өгөх гэж байгаа хүмүүс болон орогнол хүсэхээр тухайн улсад шилжин ирсэн гадаадын иргэн, (харьяалалгүй хүн);

## Хууль бус шилжигч

Хууль бус шилжих хөдөлгөөний субъектыг дараах байдлаар ангилан авч үзэж байна. Үүнд:

1. Хууль бус шилжин явагч: аль нэг улсын хилийг хууль бусаар нэвтрэн явж байгаа шилжигч;
2. Хууль бус шилжин ирэгч: хуурамч, хүчин төгөлдөр бус бичиг баримт болон бичиг баримтгүйгээр аль нэг улсад орж ирсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүн; тус улсад орохоор мэдүүлсэн мэдүүлэг нь санаа, зорилготой нь нийцэхгүй байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгоно.

Улс бүр өөр өөрийн хууль тогтоомжоор шилжигчдийг, тэдний эрх зүйн байдлыг тодорхойлдог.

## Шилжигчдийн эрх зүйн байдал

Олон улсын шилжих хөдөлгөөний субъекттэй холбоотой чухал асуудлын нэг бол тэдний эрх зүйн байдлыг тодорхойлох явдал юм. Олон улсын шилжигчдийн эрх зүйн байдлыг олон улсын эрх зүйн хэм хэмжээ болон илгээгч, хүлээн авагч улсын үндэсний хууль тогтоомжоор тэдний нийгэм дэх байр суурийг тодорхойлсон эрх үүргийн цогц гэж үздэг.



Олон улсын шилжих хөдөлгөөний хэв байдлаас нь хамаарч шилжигчдийн эрх зүйн байдал нь бие биенээс нь тусгаарласан онцлогтой байх бөгөөд аль нэгэн улс, нийгэмд тэдний асуудлыг олон улсын эрх зүйн үүднээс авч үздэг.

Шилжигчдийн эрх зүйн байдлын бүрэлдэхүүн хэсэг нь тэдний эрх, үүрэг байдаг.

Олон улсын шилжих хөдөлгөөний субъектын эрх гэдэг нь олон улсын хамтын нөхөрлөөс олон улсын нийтийн болон бусийн хоёр ба олон талт гэрээ, хэлэлцээр байгуулах замаар, олон улсын эрх зүйн үндсэн хэм хэмжээ, зарчмын шаардлагад нийцсэн, улс бүр тухайн асуудалд өөрийн онцлог алхмыг тусгасан, үндэсний эрх зүйн хэм хэмжээгээр тогтоогдсон буюу эцсийн дунд шилжин суурьшигчдын улс төр, эдийн засаг, нийгмийн болон бусад хамгааллыг зайлшгүй хангах, тэдний амьдрах үйл ажиллагаанд таатай нөхцөл бий болгох эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн, шилжигчдийн боломж юм.

Олон улсын шилжих хөдөлгөөний субъектын үүрэг гэдэг нь хүлээн авагч улсын хувьд шилжигчдийг бүртгэх, оршин суух, шилжих хөдөлгөөнийг зохих журмын дагуу явуулах, тэдний зүгээс эмх замбараагүй явдал гаргуулахгүй байх, уугуул иргэдийнхээ эрх ашиг, сонирхлыг хамгаалах, улс орны нийгмийн хэв журам, аюулгүй байдал, геополитикийн тэнцвэрийг хадгалах, хамгаалах зорилгоор хуулиар тогтоосон хязгаарлалт, зарим үед албадлагын цогц хэм хэмжээг хэлдэг.

### **Хяналтын асуулт:**

1. Олон улсын шилжих хөдөлгөөний субъект гэх ойлголтыг аль нэг улсын жишээгээр тайлбарлана уу.
2. ОУХБ шилжигчдийг ангилсан ангиллын талаар тайлбарлана уу.
3. Хууль бус шилжигч гэж хэн болох, тэдний онцлогийг тодорхойлно уу.
4. Шилжигчдийн эрх зүйн байдал гэж юу вэ?
5. Шилжигчдийн эрх, үүргийг өөрийн улсын жишээгээр тайлбарлана уу.

### **Эх сурвалж**

1. ОУШХБ-ын дүрэм. 1987.
2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2010. №8.
3. Гэрэлчулун Х. Хүн амын шилжих хөдөлгөөн. УБ., 2010.
4. Хөдөлмөрийн шилжих хөдөлгөөний бодлого ба менежмент. Сургалтын модулиуд. УБ., 2004.
5. Бондырева С.К., Колесов Д.В. Миграция. Сущность и явление. М., 2007.
6. Хабриева Т.Я. Миграционное право России: Теория и практика. М., 2008.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

## СЭДЭВ 2. Хөдөлмөрийн шилжигчдийн эрх зүйн байдал

*Сэдвийн зорилго: Гадаад шилжих хөдөлгөөний субъектын нэг хэсэг болсон эдийн засгийн шалтгаантай шилжигчдийн эрх зүйн байдлыг тусгайллан авч үзэх нь чухал билээ. Зарчмын хувьд энэ төрлийн шилжигчдийн гол зорилго нь өөр улсад хөдөлмөр эрхэлж өндөр цалин хөлс авах явдал юм. Иймээс эдгээр шилжигчдийн олон улсын эрх зүйн зохицуулалтыг судлан тэдний эрх үүргийг тодорхойлох, хэрэглэх чадвар эзэмшиүүлэх нь чухал байна.*

### Сэдвийн агуулга:

Тэднийг цагаач ажилчид, хөдөлмөрийн цагаач гэх зэргээр олон янзаар хөрвүүлж нэрлэдэг боловч “хөдөлмөрийн шилжигч” гэж нэрлэх нь илүү зохимжтой.

ОУХБ-ын 97 дугаар конвенцийн 11 дүгээр зүйлд хөдөлмөрийн шилжигч гэж ажил, хөдөлмөр эрхлэх зорилгоор, өөрийн хөрөнгөөр нэг улсаас нөгөө улсад шилжиж байгаа хүнийг хэлнэ» гэжээ. «Хөдөлмөрийн шилжигч» гэх энэхүү албан ёсны тодорхойлолт нь бүрэн гүйцэд томьёологдоогүй, давхардсан санааг агуулсан зэрэг учир дутагдалтай. Гэсэн хэдий ч уг тодорхойлолт нь шилжигчдээс хөдөлмөрийн шилжигч гэж хэн болох талаарх ерөнхий ойлголтыг өгч байна.

### Хөдөлмөрийн асуудал эрхлэх олон улсын байгууллага

НҮБ-ын төрөлжсөн байгууллага болох Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ) нь олон улсын хэмжээнд хөдөлмөрлөх болон хөдөлмөрийн шилжигчдийн асуудлыг эрхэлдэг. ОУХБ-ын чиг үүргийн нэг нь хилийн чанадад ажиллаж байгаа хөдөлмөрийн шилжигчдийг ажлаар бүрэн хангах, тэдний эрх ашгийг хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлэх явдал юм.

ОУХБ хөдөлмөрийн шилжигчдийн үндсэн эрх, эрх чөлөөг сахин хамгаалах, яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэг, хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх, өөрсдийн иргэдийн нэгэн адил буюу тэднээс дутуутгүйгээр цалин хөлс олгох, ажил амралтын цагийн зохицуулалт, ажилд авах нас, мэргэжлийн сургалт, орон сууцны асуудал, үйлдвэрчний эвлэлд нэгдэх, нийгмийн хамгаалал, татвар, шүүхийн үйл ажиллагаанд оролцох эрхийг хангах зорилгоор нэлээд олон конвенцийг соёрхон баталсан.

### Хөдөлмөрийн шилжигчдийн эрх зүйн байдал

Хөдөлмөрийн шилжигчдийн эрх зүйн байдлыг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын олон гэрээ, конвенцоор зохицуулж өгсөн.

Эдгээрт ОУХБ-ын үндсэн баримт бичиг болох Хөдөлмөрийн шилжих хөдөлгөөний тухай 97 дугаар конвенц (1949 он); Нийгмийн хамгааллын салбарт



гадаадын иргэн, харьялалгүй хүн бусад иргэдийн нэгэн адил эрх тэгш байх тухай 118 дугаар конвенц (1962 он); Шилжих хөдөлгөөний хүрээнд хөдөлмөрийн шилжигчдэд эрх тэгш хандах боломжийг зүй бусаар ашиглахын эсрэг 143 дугаар конвенц (1975 он) зэргийг дурдаж болно.

ОУХБ-ын 118 дугаар конвенцид: гишүүн орнууд, нийгмийн халамжийн тэтгэмжийг бусад гишүүн орны иргэдэд өөрийн иргэдтэй адил тэгшээр олгох,

ОУХБ-ын 143 дугаар конвенцид: хууль ёсоор оршин суугаа хөдөлмөрийн шилжигчид, нутгийн иргэдийн нэгэн адил ажил эрхлэх мөн ажилгүй, эсвэл суралцаж байгаа үедээ түр зуурын ажлаар хангуулах эрхтэй, мөн тэдний гэр бүлийн гишүүдийг ажил хөдөлмөр эрхлэх, нийгмийн халамж хүртэх, үйлдвэрчний болон соёлын эрх, эрх чөлөөг эдлэхэд чиглэсэн үндэсний онцлог, нөхцөл байдалд тулгуурласан бодлого боловсруулан хэрэгжүүлэхийг үүрэг болгодог.

Нөгөө талаар хөдөлмөрийн шилжигчид, түүний гэр бүлийн гишүүд тухайн улсын хууль тогтоомж, уугуул оршин суугчдын соёл, ёс заншлыг сахин биелүүлэх үүрэгтэй.

### **ОУХБ-ын гишүүн орны хүлээх үүрэг**

ОУХБ-ын конвенцийн оролцогч улсууд төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжоо боловсронгуй болгох, хэрэгжүүлэх үүднээс дараах үүргийг хүлээдэг байна. Үүнд:

- бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор дотоодын хууль тогтоомжид холбогдох заалтыг оруулах, хөтөлбөр боловсруулах;
- хөдөлмөрийн шилжигчид оршин суугаа тухайн улсад нь батлагдсан, тэдний эрх ашгийг хамгаалах, бодит туслалцаа үзүүлэх, эрх, үүргийг тусгасан бодлогын баримт бичигтэй бүрэн танилцахад чиглэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга хэмжээг зохион байгуулах, бусад үйл ажиллагааг дэмжиж урамшуулах;
- дотоодын нөхцөл байдал, практикт тулгуурласан нийгмийн бодлого хэрэгжүүлэх, хөдөлмөрийн шилжигчид, тэдний гэр бүлийнхэнд тухайн улсын иргэдийн нэгэн адил эрхийг эдлүүлэх;
- хөдөлмөрийн шилжигчид, тэдний гэр бүлийн гишүүдэд уугуул нутгийнхаа үндэстэн, ястны шинж чанар, соёлыг хадгалах, тэдний хүүхдүүдэд төрөлх хэлээрээ суралцах боломж олгох талаар холбогдох арга хэмжээг авах зэрэг болно.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалаас эхлээд олон улсын хүний эрхийн талаарх олон баримт бичигт гэр бүлийг нийгмийн бодит, үндсэн нэгж болохын нь хувьд төр, нийгмийн зүгээс зайлшгүй хамгаалах шаардлагатайг харгалзан гэр бүлийн нэгдлийг

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

хамгаалах, бэхжүүлэх тухай заалт орсон. Хөдөлмөрийн шилжигчид аргагүйн эрхэнд гэр бүлээсээ тусдаа амьдрах шаардлагатай болдог. Иймээс ОУХБ-ын 143 дугаар конвенцийн 13 дугаар зүйлд соёрхон баталсан оролцогч улсад өөрийн эрх хэмжээний хүрээнд бусад гишүүн улстай хамтран өөрсдийн нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа хөдөлмөрийн шилжигчдийг гэр булийн хамт амьдрах нөхцөл бололцоогоор хангах арга хэмжээг заавал авахыг даалгасан.

Хөдөлмөрийн шилжигчдийн тухай 86 дугаар зөвлөмжийн хавсралтын 14 дүгээр зүйлд шилжин суурьшигчдын оршин суугаа нутаг дэвсгэрийн холбогдох төрийн захиргааны байгууллагууд шилжин суурьшигчид, тэдний гэр булийн гишүүдэд цаг уур, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалд дасан зохицоход чиглэсэн боломжтой бүх арга хэмжээг авах, иргэний харьяаллыг хялбаршуулсан байдлаар шийдвэрлэхэд туслацаа дэмжлэг үзүүлэхийгuriалсан байdag.

## Хөдөлмөрийн шилжих хөдөлгөөний эерэг ба сөрөг тал

Хөдөлмөрийн шилжигчдийн хүлээн авагч буюу шинэ улс оронд хэрэглэгдэж байгаа техник, дэвшилтэт технологитой харьцаж, илүү өндөр хөдөлмөрийн стандарт, ёс зүй, сахилга бат, дэг журам, зохион байгуулалттай орчинд ажиллаж гадаад хэл сурч, орчиндоо дасан зохицож байгаа нь шилжигчдийн мэргэжил, мэдлэг, боловсролын түвшинг дээшлүүлж, улмаар илгээгч буюу донор орны эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулдаг байна.

Хөдөлмөрийн шилжих хөдөлгөөнд “мэргэжлийнхэн”-ээс гадна нутгийн уугуул иргэд хийхээс голсон, цаашид явцгүй, бага цалинтай ажилд ямар ч ажлыг гололгүй хийх мэргэжилгүй, дунд боловсролтой хүмүүс ч ихээр хамрагдах болсон. ХБНГУ-д шилжин ирсэн эдийн засгийн идэвхтэй суурьшигчдын бараг 85 хувь нь хүнд, аюултай, нэг хэвийн ажил эрхэлж, тэдний 60 хувь нь бага, бараг мэргэжилгүй ажилчдын эгнээнд багтадаг бол Франц Улсад өөр улсаас ирсэн шилжин ирэгчид ихэвчлэн “тар хөдөлмөр” эрхэлдэг байна

Ажиллах хүчээ гадаадад илгээдэг олон оронд хилийн чанадаас ирүүлж байгаа мөнгөн шилжүүлэг нь экспортын голлох, тэр тусмаа үндэсний орлогын чухал бүрэлдэхүүн хэсэг болдог байна. Ажиллах хүчээ “экспортлодог” уламжлалт орнуудад энэ үзүүлэлт экспортын 25-50 хувь, импортын 10-33 хувийг бүрдүүлж байна. Хөдөлмөрийн шилжих хөдөлгөөнөөс үүдэлтэй мөнгөн шилжүүлгийн хүрээ улам өсөн нэмэгдэж байгаа нь шилжигчдийн хүрээ өргөжиж байгаатай шууд холбоотой бөгөөд мөнгөн шилжүүлэг нь хөгжингүй орноос хөгжиж байгаа орны хөгжилд оруулж буй том хөрөнгө оруулалт болдог.

Зарим судлаачдийн үзэж байгаагаар шилжигчид эх орондоо эргэж ирээд өөрсдийн хуримтлуулсан ажлын хөлсөө хувийн аж ахуйдаа зарцуулан нэмж ажлын байр бий болгох замаар дундаж ангийнхний эгнээг өргөтгөдөг. Хөдөлмөрийн



шилжих хөдөлгөөн нь улс орны гадаад эдийн засгийн үйл ажиллагаанд сайнаар нөлөөлж гадаад харилцаа, холбоог идэвхтэй хөгжүүлдэг.

Хөдөлмөрийн шилжигч бүр хүлээн авагч, илгээгч орон хоорондын худалдааны харилцааг хөгжүүлэх, барааны экспорт, импортын эргэлтийг эрчимжүүлэх зэргээр хоёр талын зуучлагч болдог байна.

### **Хууль бус шилжигчид**

Аливаа гадаадын иргэн өөр улсын нутаг дэвсгэрт нэврэхдээ зорилгоо тодорхойлж холбогдох зөвшөөрлийг урьдчилан авсан байх шаардалгатай.

Дүрвэгчид, хөдөлмөрийн шилжигчид болон бусад олон улсын шилжих хөдөлгөөний оролцогчид хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт орох, оршин суухдаа хууль тогтоомжийн дагуу байгаа нь ховор байдаг.

Хэн нэгэн этгээд тогтоосон хууль тогтоомжийг зөрчин орогнол хүсэх, зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхлэхээр аль нэгэн улсад нэвтрэх нь өөрөө хууль бус үйлдэл юм. Хууль бус шилжигчид нь хүлээн авагч улсын зүгээс нутаг дэвсгэрт нь хууль ёсоор байгаа шилжигчдэд хамааруулсан эрхийг эдлэх боломжгүй. Энэ нь тэдний нийгмийн байдалд хүндрэл учруулахаас гадна эрүүгийн гэмт хэргийн хүрээнд татан оруулдаг байна.

### **Хяналтын асуулт:**

1. Хөдөлмөрийн шилжигч гэж хэн вэ, тэдний шилжих хөдөлгөөний бусад оролцогчдоос ялгарах онцлог нь юу вэ?
2. ОУХБ-ын баримт бичигт хөдөлмөрийн шилжигчдийн эрхийг хэрхэн зохицуулсан бэ?
3. ОУХБ-ын гишүүн, конвенцийн оролцогч улсуудын хүлээх үүргийг тайлбарлана уу.
4. Хөдөлмөрийн шилжигчийн эрх зүйн байдлыг тодорхойлно уу.
5. Хууль бус шилжигч гэж хэн болох, хууль бус хөдөлмөрийн шилжигчид ОУХБ-ын хамгаалтыг эдлэх эсэх?

### **Эх сурвалж**

1. Хөдөлмөрийн шилжигчдийн тухай ОУХБ-ын №86 зөвлөмж. 1949.
2. Хөдөлмөрийн шилжигчдийн тухай ОУХБ-ын №151 зөвлөмж. 1994.
3. Хөдөлмөрийн шилжигчид, тэдний гэр булийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц. 1990.
4. Шилжих хөдөлгөөний хүрээнд хөдөлмөрийн шилжигчдэд эрх тэгш хандах боломжийг зүй бусаар ашиглахын эсрэг 143 дугаар конвенц. 1975.

## **ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН**

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

5. Монгол Улсын Үндсэн хууль. 1992.
6. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль. 2001.
7. Гантулга А. Гадаадын иргэний хөдөлмөр эрхлэлт, түүний эрх зүйн онолын үндсэн асуудал. Магистрын дипломын ажил. УБ., 2013.



## СЭДЭВ 3. Дүрвэгч, оргонол хүсэгч

**Сэдвийн зорилго:** Сүүлийн үед дэлхийн бүх бүс нутаг, улс орныг бүрхсэн олон улсын шилжих хөдөлгөөний субъектын нэгэн бүлэг болох дүрвэгчдийн урсгал онцгой анхаафал татаж байгаа билээ. Иймээс олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэн дүрвэгчийг бусад шилжигчдээс ялгах, тэдний эрх зүйн байдлыг тодорхойлох чадваар эзэмшигүүлэх, оргонол олгох эрхийн тухай тэдлэг олгоход оршино.

### Сэдвийн агуулга:

Олон улсын шилжигч бүрийн эрх зүйн байдлыг нь тэдэнд чиглэсэн эрх зүйн хэм хэмжээний агуулга, нохцол байдлаас нь хамааран тодорхойлж болин.

“Дүрвэгч” гэдэг нэр томьёог олон улсын эрх зүйд анх дэлхийн I дайны дараа хэрэглэх болсон. Дайны үед эзлэгдсэн буюу эзлэгдэх аюул занал тулгарсан нутаг дэвсгэрээс өөрсдөө зугатан зайлсан буюу хүчээр зайлцуулагдсан хүмүүсийг ийнхүү нэрлэж байв. Дэлхийн II дайны үед бусад улсын нутаг дэвсгэрт албадан оруулсан хүмүүсийг “албадан шилжүүлсэн хүмүүс” гэж нэрлэдэг байсан.

### Дүрвэгчдийн асуудал эрхлэх байгууллага

Дайны дараа дүрвэгчид ба албадан шилжүүлсэн хүмүүсийг нутагт нь яаралтай шилжүүлэх асуудлыг зохицуулахын тулд гитлерийн эсрэг нэгдсэн холбооны улсууд гэрээ байгуулсан. Дүрвэгчдийг нутагт нь буцаах асуудлыг НҮБ эрхлэхээр болж Ерөнхий Ассамблейн 1946 оны тогтоолд “өөрийн нутаг дэвсгэрт байгаа дүрвэгчид болон шилжүүлэгдсэн хүмүүсийг нутаг буцаахад бүх улс гүрэн туслаалцаа дэмжлэг үзүүлбэл зохино” гэж заасан байдаг. Тиймээс ч улс гүрнүүдийн хамтын ажиллагааг зохицуулах зорилгоор олон улсын байгууллагыг бий болгож хожим нь буюу 1949 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейн шийдвэрээр Дүрвэгчдийн асуудлыг эрхлэх дээд комиссарын газар (ДДКГ) болгон өөрчилсөн. Эл газрын үйл ажиллагаа нь улс төрөөс ангид, хүмүүнлэгийн шинжктэй бөгөөд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1951 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар Дээд комиссарын газрын дүрмийг баталсан. ДДКГ-ын төв байр нь Швейцарь Улсын Женев хотноо байрладаг ба дэлхийн олон орны халуун цэг дээр төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг.

### Дүрвэгч гэж хэн бэ?

Олон улсын эрх зүйн баримт бичигт дурдсанаар “дүрвэгч” хэмээх томьёололтой хүмүүс нь улс төр, цэрэг, дайны хүчин зүйлээс шалтгаалан шилжин нүүдэллэсэн олон улсын шилжих хөдөлгөөний субъектын нэг бүлэг юм. Иймээс дүрвэгчдийн эрх

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

зүйн байдал нь нэлээд онцлогтой. Эдний эрх зүйн байдлыг тодорхойлсон олон улсын эрх зүйн тулгуур баримт бичиг нь НҮБ-аас 1951 онд баталсан Дүрвэгчдийн эрх зүйн байдлын тухай конвенц бөгөөд түүнд нэгдэн орсон улсууд дүрвэгчдийн эрх зүйтэй холбоотой нэмэлт протоколд 1967 оны 1 дүгээр сард гарын үсэг зуржээ. Дээрх конвенцийн I хэсгийн 1 дүгээр зүйлд “дүрвэгч” гэдэг ойлголтын тодорхойлолтыг өгсөн. Энэхүү тодорхойлолтын дагуу “дүрвэгч” гэж 1951 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө болсон хэрэг явдлын улмаас, түүнчлэн арьсны өнгө, шашин шүтлэг, иргэний харьяалал, нийгмийн тодорхой байдал, эсвэл улс төрийн үзэл бодлын улмаас мөрдлөг хавчлагын аюулд өртөнө гэж үзэх бүрэн үндэслэл бүхий болгоомжлолоос улбаалан харьяалагдах улсынхаа гадна байгаа, тухайн улсынхаа хамгаалалтыг авч чадахгүй буюу дээрх шалтгаанаар авахыг хүсэхгүй байгаа; эсвэл тодорхой иргэний харьяалалгүй бөгөөд дээр дурдсан хэрэг явдлын улмаас хэвийн оршин сууж байсан улсынхаа гадна байгаа болон болгоомжлолын үүднээс буцаж чадахгүй байгаа, буцахыг хүсэхгүй хүмүүсийг ойлгодог байна.

## Олон улсын эрх зүйн үндсэн баримт бичиг

Дүрвэгчдийн эрх зүйн байдлын тухай конвенцийг боловсруулж байх явцад олон орон урьдчилан харах боломжгүй үүргийг тусгахгүй байх хүсэлт гаргаж байсантай холбоотойгоор 1951 онд хэрэг явдлыг цаг хугацаагаар хязгаарлан улсуудын хүлээх үүргийг тодорхой тусгасан. Гэсэн хэдий ч олон хэрэг явдал дэлхий дээр өрнөж цаг хугацааны хязгаарлалтаас давж гарсан. Гагцхүү газар зүйн хязгаарлалт л тогтоон барих хүчин зүйл болсон.

Ийнхүү хугацааны хязгаарлалтыг үгүй болгосон олон улсын эрх зүйн баримт бичгийг батлах зайлшгүй шаардлагаар 1967 онд Дүрвэгчдийн эрх зүйн байдлын тухай конвенцийн нэмэлт протоколыг баталж 10 дугаар сарын 4-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон. Протоколд “дүрвэгчид” гэдэг нэр томъёонд конвенцийн 1 дүгээр зүйлийн “1951 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө болсон хэрэг явдлын үр дүнд...”, “... иймэрхүү хэрэг явдлын үр дүнд” гэсэн тодорхойлолтод багтсан бүх хүнийг өргөн хэмжээнд ойлгохоор заасан. Түүнээс гадна оролцогч улсууд ямар нэгэн газар зүйн байрлалын хаягаарлалтгүйгээр хэрэглэх тухай заалтыг протоколд тусгасан.

## Бүсийн баримт бичиг

Африкийн эв нэгдлийн байгууллага Африкийн дүрвэгчдийн асуудлаарх Конвенцийг 1969 онд батлан “дүрвэгч” гэдэгт: хүчирхийлэл, эзлэн түрэмгийлэл, өөр улсын ноёрхол, эсвэл иргэний харьяалал, нийгмийн байдлаас шалтгаалан улс орон нь бүхэлдээ буюу хэсэг газарт нийгмийн хэв журам ноцтой зөрчигдсөний улмаас байгаа газраа орхихоос аргагүй байдалд хүрч тухайн улсаас гадна өөр улсад орогнол хүсч байгаа бүх л хүнийг багтаасан байна.



80-аад онд төв америкт гарсан зэвсэгт мөргөлдөөний оч олон хүн бөөнөөрөө дурвэх шалтгаан болж улмаар 1984 онд Картахений дурвэгчдийн тухай тунхаглалыг батлахад хүргэсэн. Энэхүү Тунхаглаалд зааснаар бус нутагт хэрэглэх “дүрвэгч” гэх тодорхойлолтод 1951 оны Конвенц, 1967 оны Протоколд тусгагдсан тодорхойлтоос гадна өөр орны халдлага, дотоодын зөрчилдөөнөөс улбаатай бүх нийтийн хучирхийллээс болж, амь нас, аюулгүй байдал, эрх чөлөө нь аюулд дайрагдах, түүнчлэн олон хүнийг хоморголсон хүний эрхийн зөрчил болон нийгмийн хэв журмын бусад ноцтой зөрчлийн улмаас нутгаа орхиж буй хүмүүсийг хамруулан ойлгоно.

Орчин үеийн нөхцөл байдалтай уялдуулан “дүрвэгч” нэр томъёог 1993 онд ТУХН-ийн хүрээнд дүрвэгч, сайн дурын бус шилжигчдэд туслалцаа үзүүлэх тухай хэлэлцээрт илүү тодорхой тайлбарласан байдаг. Хэлэлцээрийн 1 дугээр зүйлд зааснаар “дүрвэгч” гэдэг нь зэвсэгт мөргөлдөөн, үндэстэн хоорондын зөрчилтэй холбоотойгоор хэн нэгэн этгээдийг буюу түүний гэр бүлийн гишүүнийг хучирхийлэх, янз бурийн хэлбэрээр мөрдөн мөшгих, эсвэл арьсны өнгө, үндэстний хамаарал, шашин шүтлэг, хэл соёл, улс төрийн итгэл үнэмшил, нийгмийн тодорхой бүлэглэлд багтаж байгаа байдалтай нь холбоотой бодит аюул занал тулгарч, байнга оршин суугаа улсынхаа газар нутгийг орхихоос өөр аргагүй болж тухайн улсын иргэний харьяалалгүй боловч орогнох эрх авсан хүнийг хэлдэг байна.

### **Дүрвэгчийн эрх зүйн байдал**

Дүрвэгчдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны конвенцийн 12 дугаар зүйлд зааснаар дүрвэгчийн хувийн эрх зүйн байдлыг түүний байнга оршин суугаа (домициль) орны хуулиар, хэрвээ тийм газар байхгүй бол оршин суугаа орны хуулиар тодорхойлно.

Конвенцийн 2 дугаар зүйлд заасны дагуу дүрвэгч бүр оршин суугаа улсынхаа хууль тогтоомжид захирагдан, нийгмийн хэв журмыг сахиулах талаар авч байгаа арга хэмжээг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. Үүний зэрэгцээ хүлээн авагч улс ч Конвенцийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу албадан гаргахыг хориглох (non-refoulement) зарчмыг дагах үүрэгтэй. Дүрвэгчдийг албадан буцаах буюу хөөн гаргаж, амь нас эрх чөлөөг нь аюул заналд оруулахгүй байх нь олон улсын хамгаалалтын чухал хэсэг байдаг. Арьсны өнгө, шашин шүтлэг, иргэний харьяалал, нийгмийн тодорхой бүлэглэлд багтаж байгаа байдал, эсвэл улс төрийн итгэл үнэмшлээс нь улбаатай мөрдлөгөөс болгоомжилж байгаа дүрвэгчдийг албадан нутагт нь буцаах нь олон улсын эрх зүйн зарчимд нийцэхгүй.

Товчхондоо олон улсын шилжих хөдлөгөөний энэ бүлэг шилжигчдийг тодорхой тохиолдолд хүлээн авагч улсын иргэний нэгэн адил эрх, эрх чөлөөг эдлүүлэх үндэсний хууль тогтоомжид тусгагдсан журам дэглэмтэй гэж үзэж болох юм.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

## Оргонол хүсэгч

Төрийн иргэний харьяалалтай эсвэл оршин суугаа орондоо улс төрийн шалтгаанаар хавчигдан мөшгигдөж байгаа хүн өөр улсад орох эрх олгохыг оргоног эрх гэдэг. Улс төрийн шалтгаан гэдэгт дан ганц улс төрийн үзэл бодол биш, шашин шүтлэг, шинжлэх ухааныг үзэх үзэл, үйл ажиллагаа, арьсны өнгө, үндэс угсаагаар гадуурхахыг хэлдэг байна.



Оргоног эрх олгох асуудлыг улсуудын үндэсний хууль тогтоомжоор зохицуулах ба олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр оргонол олгосон улсыг бусад улс нь хүндэтгэн үзэх зарчимтай.

## Оргоног эрхийн үр дагавар

1. Улс төрийн шалтгааны улмаас хэн нэгэнд оргоног эрх олгосон бол түүнийг өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно.
2. Хилийн чанадад оргоногчийн эрх хөндөгдсөн тохиолдолд оргонол олгосон улс дипломат хамгаалалт үзүүлнэ. Өөрөөр хэлбэл, оргоногч түр хугацаагаар гуравдагч улсад зорчих явцад эрх нь зөрчигдөх асуудал юм.
3. Оргонол олгосон улс тухайн оргоногчийн үйл ажиллагааны өмнөөс хариуцлага (хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох үүрэгтэй) хүлээнэ.

## Олон улсын эрх зүй ба оргоног эрх

Орчин үед нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн оргоног эрхийн тухай акт байхгүй бөгөөд энэ асуудал гол төлөв зан заншлын хэм хэмжээгээр зохицуулагддаг. Энэ нь:

- Хүн бүр улс төрийн болон бусад шалтгааны улмаас өөр улсад оргоног эрх хүсэх эрхтэй,
- Улс бүр өөрийн бүрэн эрхийн хэмжээнд үндэсний хууль тогтоомждоо оргоног эрх олгох журмыг тогтоох,
- Оргоног эрх олгох нь улс хооронд дайсагнасан хэрэг биш хүмүүнлэгийн шинжтэй гэдгийг ухамсарлах,



- Оргнол хүсэгч мөрдөн мөшгигдөж байгаа улсдаа цөллөгдөх ёсгүй,
- Олон улсын гэмт хэрэгтэн болон эрүүгийн хэрэгт яллагдагчид оргнох эрх олгохгүй.

Оргнол олгох асуудлыг НҮБ-ын Оргнох нутаг дэсгэрийн тухай тунхаг (1967 он), Европын Холбооны Оргнох нутаг дэсгэрийн тухай тунхаг (1977 он), Оргногчийн тухай Гаваны конвенц (1928 он), Дипломат оргнолын тухай конвенцид (1954 он)-д тус тус тусгагдсан.

### ***Хяналтын асуулт:***

1. Дүрвэгч гэж хэн бэ, тэдний эрх зүйн байдлыг тодорхойлно уу.
2. Дүрвэгчдийн асуудлыг зохицуулах олон улсын болон бүсийн баримт бичгүүд, тэдгээрийн агуулга, эрх зүйн учир холбогдлыг тайлбарлана уу.
3. НҮБ-ын Дүрвэгчдийн асуудлыг эрхэлсэн дээд комиссарын газрын чиг үүргийг тодорхойлно уу.
4. Оргнол хүсэгч гэж хэн болох, түүний дүрвэгчээс ялгагдах онцлогийг нэрлэнэ үү.
5. Оргнол олгох эрхийг улс орнуудын хууль тогтоомжид хэрхэн тусгасан бэ? Өөрийн улсын жишээн дээр ярина уу.

### ***Эх сурвалж***

1. Оргнох нутаг дэвсгэрийн тухай тунхаг. 1967.
2. Малахова В.С, Яковleva A.F. Гражданство и иммиграция. M., 2013.
3. Влияние незаконной миграции на криминогенную обстановку в РФ. Тенденции правового регулирования противодействия незаконной миграции» //Миграционное право. 2008. №1.
4. Кузнецов В.И, Тузмухамедов Б.Р. Международное право, M., 2010.
5. Ковалева А.А, Черниченко С.В. Международное право, M., 2006.
6. Wolfgang Graf Vitzthum. Völkerrecht. Berlin., 2011.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

## СЭДЭВ 4. Хууль бус шилжих хөдөлгөөний хариуцлага

**Сэдвийн зорилго:** Шилжих хөдөлгөөн нь аль нэг улсын хилийн боомтооф шилжигч орох, гараг, дамжин өнгөрөхөд, нөгөө талаас тухайн улсын эрх бүхий байгууллага хяналт, шалгалт тавихтай холбоотой эрх зүйн цогц асуудал ют. Шилжих хөдөлгөөн өсөн нэмэгдэж байгаа үед хууль бус шилжигч гээж хэн болох, тэдэнтэй хариуцлага тооцох механизмыг судлах, хэрэг маффаанд хууль зүйн дүгнэлт өгөх чадваар эзэмшиүүлэхэд чиглэгдэнэ.

### Сэдвийн товч агуулга:

Улсуудын хууль ёсны ашиг сонирхол, шилжигчдийн эрх, эрх чөлөө, шилжих хөдөлгөөний үйл явцын зохицуулалт нь эрх зүйн зүй ёсны дүрэм журам дээр үндэслэн зохион байгууллагдаж байж зөв хэрэгжинэ.

Хууль зөрчигчидтэй тэмцэх гол арга нь эрх зүйн хариуцлагын тогтолцоон дээр суурилсан хууль бус үйлдлийн үр дагаврыг буруутгасан, үүрэгжүүлсэн, хүмүүжлийн механизм байх нь үр дүнтэй.

Орчин үед хууль сахиулах байгууллагын үндсэн чиг үүргийн нэг хэсэг нь хууль бус шилжих хөдөлгөөний асуудлыг шийдвэрлэхэд оршиж байна.

### Хууль зүйн хариуцлага

Хууль зүйн хариуцлагын арга хэмжээ нь үндсэндээ аль нэг улсад орох, оршин суух, тухайн улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тогтсон журмыг зөрчигчдөд чиглэдэг. Шилжих хөдөлгөөний харилцаанд оролцогчид нь дан ганц гадаадын иргэн биш тэднийг хүлээн авч байгаа холбогдох байгууллагын албан тушаалтан хамаарна.

Хууль бус шилжих хөдөлгөөний хүрээ нь улсын үндэсний аюулгүй байдал, төр, иргэний ашиг сонирхолд заналхийлж байдаг. Асуудлыг шийдэх арга зам нь зөвхөн хууль зөрчигчдийг залхаан цээрлүүлэх, арилгахад бус хууль бус шилжих хөдөлгөөнтэй тэмцэх цогц арга хэмжээ авахад оршино.

Эдийн засгийн нөхцөл байдал хүндрэлтэй (сүүдрийн) газарт гадаадын иргэдийн хөдөлмөрийг ашиглах зорилгоор гадаад, дотоодын гэмт хэргийн бүлэглэлүүд хуурамч бичиг баримтаар хангах, зохион байгуулах ажлыг хийдэг. Иймээс шилжих хөдөлгөөний хууль тогтоомжийг зөрчигчдөд үйлдлийнх нь нийгмийн аюултай байдал, хор хөнөөлөөс нь шалтгаалан захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай ерөнхий зарчим бий.



## Захиргааны хариуцлага

Гадаадын иргэн, харьялалгүй хүн аль нэг улсын нутаг дэвсгэрт оршин суух, улсын хилийг хамгаалахтай холбоотой зөрчлийг 2 хувааж болно.

Улсын хилийг хамгаалахтай холбоотой захиргааны зөрчилд хил хамгаалах байгууллагын тогтооосон дүрэм, журмыг зөрчсан, гэхдээ бүгд хууль бус шилжих хөдөлгөөнтэй хамааралтай бус зөрчил багтана. Тухайлбал, хилийн халдашгүй байх журмыг зөрчсон, хилийн бүс нутагт аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх дүрэм зөрчих, нутаг дэвсгэрийн далайн хэсгээр зорчих журам зөрчих зэрэг.

Шилжих хөдөлгөөнтэй холбоотой зөрчилд улсын хилийн шалган нэвтрүүлэх боомтоор нэвтрэхтэй холбоотой зөрчил хамаарна.

Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл гэдэгт төмөр зам, усан зам, авто зам агаарын зам болон тусгай тоноглосон байраар хүн, амьтан, ачаа, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэхийг хэлнэ. Улсын хилийн боомтоор нэвтэрч байгаа гадаадын иргэн, харьялалгүй хүний үйл хөдлөлд гэмт хэргийн болон захиргааны зөрчлийн шинж илэрвэл хууль тогтоомжид заасны дагуу хариуцлагад татна.

Эрүүгийн болон захиргааны хариуцлагад татах үндэслэлгүй бол хилийн байгууллага албан ёсоор аль улсын нутаг дэвсгэрээр дамжиж ирсэн тэр улсад нь шилжүүлэн өгнө.

Шилжих хөдөлгөөний субъектийн зөрчлийг 3 хувааж үзэж болно.



## Захиргааны шийтгэл

Энэ төрлийн зөрчилд гол төлөв торгууль ногдуулах, онцгой тохиолдолд сануулах, захиргааны журмаар баривчлах, үйл ажиллагааг нь загсоох арга хэмжээ авдаг.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

Олон улсад зөрчлийн байдлыг харгалзан гадаадын иргэнийг тухайн улсын нутаг дэвсгэрээс албадан гаргах арга хэмжээ авдаг.

Албадан гаргах арга хэмжээг шүүхийн журмаар эсвэл захиргааны эрх мэдэлтний шийдвэрээр захиргааны хариуцлагын тусгай субъект болох гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хэрэглэдэг.

## Хуульд заасан үндэслэл нь:

- Тухайн улсын нутаг дэвсгэрт оршин суух журам зөрчсөн,
- Хязгаарлалт хийсэн тусгай үйл ажиллаганы төрлийг зөрчсөн,
- Гадаадын иргэдийн ажиллах хүчийг оруулах, ашиглах журмыг зөрчсөн зэрэг.

Захиргааны журмаар албадан гаргах нь шийтгэл хүлээх болсон цаг хугацаагаар тооцогдоно. Зарим улсын хууль тогтоомжид албадан гаргагдсан гадаадын иргэнийг тухайн улсад тодорхой хугацаанд орохыг үл зөвшөөрсөн байдаг. Тухайлбал, “ОХУ-аас гарах, ОХУ-д орох журмын тухай хууль”-д захиргааны журмаар албадан гаргагдсан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд албадан гаргагдсанаас хойш 5 жилийн хугацаанд ОХУ-д орохыг хориглосон, “ОХУ-ын иргэний харьяаллын тухай хууль”-д тус улсаас албадан гаргагдсан гадаадын иргэн, харьяалалгүй хүний ОХУ-ын иргэний харьяалалтай болох, иргэний харьяаллаа сэргээн тогтоо тухай гаргасан хүсэлтийг хүлээн авахыг хориглосон байдаг.

## Эрүүгийн хариуцлага

Захиргааны зөрчлийг бодвол нийгмийн илүү их аюул дагуулсан зөрчил нь хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

Шилжих хөдөлгөөний хүрээний гол зөрчил нь улсын хилийг янз бүрийн байдлаар (явланаар, тээврийн хэрэгслээр, усаар зэрэг) хууль бусаар нэвтрэх – хүчин төгөлдөр бус бичиг баримтаар нэвтрэн орох эсвэл гарах, хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллагын зөвшөөрлийг зохих ёсоор аваагүй зэрэг зөрчил орно.

Хүчин төгөлдөр бус бичиг баримт гэдэгт хуурамч, өөр хүний, хугацаа дууссан, буруу бичигдсэн бичиг баримтыг хэлнэ.

Улсын хилийг зөвшөөрөлгүй нэвтрэх гэдэгт хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаас шилжигчийн зорилгод нийцсэн зөвшөөрөл аваагүй байхыг ойлгоно.

Гэмт хэргийн субъект нь 16 нас хүрсэн хүн, субъектив тал нь санаатай үйлдсэн гэм буруутай үйлдэл байна.

Хууль бус шилжих хөдөлгөөн нь төрөөс тогтоосон дурэм журмыг зөрчих бөгөөд гэмт хэргийн объект нь эрүүгийн хууль тогтоомжоор хамгаалагдсан нийгмийн



харилцаа, ашиг сонирхолд гэмт хэргийн улмаас хор хөнөөл учруулах, аюул занал үүсэхийг хэлнэ.

### **Хэрэг, зөрчлийг багасгах нь**

Шилжих хөдөлгөөнтэй холбоотой хэрэг зөрчлийг шалгах гол үндэс нь тухайн улсын нутаг дэвсгэрт орж ирсэн, оршин сууж байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл юм. Энэ зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох, биеийн өгөгдлийг оруулсан үндсэн мэдээллийн санг бүрдүүлэх нь чухал.

Ялангуяа хэрэг зөрчил гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүний улсын хилээр орсон, гарсан, оршин сууж байгаа мэдээллийг бүртгэлжүүлэх нь зохимжтой. Зарим улсад “тааламжтүй этгээд”-ийн бүртгэл хөтлөн хяналт тавьж байх шаардлагатай гэж үздэг.

Орчин үед улс бүр хууль бус шилжих хөдөлгөөнтэй бүсийн болон олон улсын хэмжээнд тэмцэх, энэ үүднээс харилцан мэдээлэл солилцох, туршлагаа хуваалцах зорилгоор олон улсын хурал, зөвлөгөөнийг зохион байгуулж байна.

### **Хууль бус шилжин суурьшигчийг буцаах асуудал (реадмисс)**

Улс хооронд иргэдийн шилжих хөдөлгөөн идэвхжихийн хэрээр үндэсний аюулгүй байдлыг хамгаалах асуудал хурцаартавигдана. Хууль бус шилжих хөдөлгөөн, шилжигчтэй тэмцэх чиглэлд олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудал чухал байдаг. Үүний нэг нь хууль бус шилжин суурьшигчийг албадан буцаах хэлэлцээр (readmission) байгуулах юм.

Реадмиссийн хэлэлцээр нь хууль бус шилжин суурьшигчидтай тэмцэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг зөрчиж нутаг дэвсгэрт нь нэвтрэсэн, эсхүл оршин сууж байгаа нөгөө улсын иргэн, зарим тохиолдолд гуравдагч улсын иргэн, харьяалалгүй хүнийг албадан буцахаар хүсэлт гаргагч талын эрх бүхий байгууллага хүсэлт хүлээн авагч талын эрх бүхий байгууллагад шилжүүлэн өгөх, хүлээж авах, дамжуулан өнгөрүүлэх ажиллагааг харилцан тохиролцдог.

Хууль бус шилжин суурьшигчийг албадан буцаах хэлэлцээрийг ихэвчлэн хоёр улсын хооронд байгуулдаг бөгөөд зарим улс хилийн чанадад байгаа өөрийн иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор реадмиссийн хэлэлцээр байгуулах сонирхолгүй байдаг.

Хууль бус шилжин суурьшигчийг албадан буцаах олон талт хэлэлцээрийг Европын Холбооны зүгээс бусад улсуудтай байгуулсан байдаг. Улсуудын нутаг дэвсгэрт хууль бусаар оршин суугаа дамжин өнгөрөгч гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг албадан буцаах асуудал нэлээд төвөгтэй байдаг.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

Сүүлийн жилүүдэд улсуудын хооронд визгүй зорчих, эсвэл визийн хөнгөлөлтэй нөхцөлөөр зорчих үед хууль бус шилжин суурьшигчдийг албадан буцаах хэлэлцээр байгуулах болсон. Тухайлбал, 2006 онд ОХУ, Европын Холбоотой визийн хөнгөвчилсөн байдлаар зорчих хэлэлцээрийн нэг нөхцөл нь хууль бус шилжигчдийг албадан буцаах асуудал байсан. ОХУ өөрийн зүгээс хууль бус шилжигчдийг албадан буцаах хэлэлцээрийг хууль бус шилжигчдийг ОХУ руу илгээгч болон тус улсаар дамжин Европын Холбооны Улсуудад шилжин явагч улсуудтай байгуулахыг зорих болсон.

ОХУ одоогийн байдлаар “Реадмисс (Readmission)-ын тухай хэлэлцээр”-ийг 2003 онд Литва Улстай, 2006 онд Европын Холбоо, Украина Улстай, 2007 онд Норвег, Узбекстан Улстай, 2008 онд Дани, Исланд, Вьетнам Улстай, 2009 онд Швейцарийн Холбооны Улстай, 2011 онд Турк Улстай тус тус байгуулсан байна.

## **Хяналтын асуулт:**

1. Хууль бус шилжих хөдөлгөөн гэж юу вэ?
2. Шилжих хөдөлгөөний хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын тогтолцооны талаар ярина уу.
3. Албадан гаргах эрх зүйн үндэслэл, түүнийг хэрэгжүүлэх байгууллагын талаар өөрийн улсын жишээгээр тайлбарлана уу.
4. Хууль бус шилжих хөдөлгөөнтэй тэмцэх үр дүнтэй арга замыг тодорхойлно уу.

## **Эх сурвалж**

1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2010. УБ., №8.
2. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тоолох журам. //Мэдээлэл сэтгүүл. 2011. №2.
3. Гэрэлчулун Х. Хүн амын шилжих хөдөлгөөн. УБ., 2010.
4. Давааням.Д. Гадаадын иргэний зөвшөөрөл бүртгэлийн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа: боловсронгуй болгох зарим асуудал. Магистрын дипломын ажил. УБ., 2010.
5. Безвербный В.А. Миграционные процессы как фактор внутренней безопасности и территориальной целости государства //Миграционное право. М., 2008. №2.
6. Влияние незаконной миграции на криминогенную обстановку в РФ. Тенденции правового регулирования противодействия незаконной миграции» //Миграционное право. 2008. №1.



## V. БҮЛЭГ. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

### СЭДЭВ 1. Шилжих хөдөлгөөний зохицуулалтын зарчим ба эх сурвалж

**Сэдвийн зорилго:** Гадаад шилжих хөдөлгөөний нэг онцлог нь хүмүүс нэг улсын хил хязгаарыг давж нөгөө улсад нүүдэллэдгийн хувьд олон улсын хамтын нөхөрлөл, улс орнуудын төр засгаас үйл явцынхаа бүхий л шатанд анхаафал хандуулж зохицуулалт хийхийг шаарддаг. Оюутнааф энэхүү зохицуулалтын зарчим, эх сурвалжийг судлуулж тэдгээрийг хэрэглэх чадваар эзэмшиүүлэхэд оршино.

#### Сэдвийн товч агуулга:

Хүн амын шилжих хөдөлгөөнд улс орнууд өөрийн эрхгүй татагдан орж энэхүү үйл явцын оролцогч болдог. Иймээс гадаад шилжих хөдөлгөөнийг зохицуулахад олон улсын хамтын нөхөрлөл бүхэлдээ оролцож олон улсын эрх зүйн болон үндэсний хууль тогтоомжийн хэм хэмжээгээрээ зохицуулдаг.

Гэхдээ улс бүр энэ чиглэлийн хуулийг боловсруулахдаа шилжигчдийн эрхийг хамгаалахтай холбоотой олон улсын стандарт, хэм хэмжээ дээр үндэслэж үндэсний хууль тогтоомжоо боловсруулах зарчимтай. Энэ зорилгоор дотоодын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, бусад эрх зүйн актыг олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ, шаардлагад нийцүүлэн өөрчлөх шаардлага гарна. Олон улсын эрх зүйн баримт бичиг нь дотоодын хууль тогтоомжийг бодвол шилжигч, суурьшигчдын эрх ашиг, сонирхлыг илүү хамгаалсан байdag.

#### Эрх зүйн эх сурвалж

Шилжигчидтэй холбоотой олон улсын эрх зүйн баримт бичгийг хоёр хэсэгт хувааж үзэж болно.

Эхний хэсэгт шилжигчидтэй холбоотой, тэдэнд бүгдэд нь хамаардаг ерөнхий хэм хэмжээ бөгөөд ихэвчлэн хүмүүнлэгийн шинжтэй янз бүрийн гэрээ, хэлэлцээрт тусгагдсан байдаг. Эдгээр гэрээнд заасан ихэнх эрх нь оролцогч улсын нутаг дэвсгэрт, хууль ёсоор байгаа бүх хүнд тэр тусмаа шилжин суурьшигчдад хамаарах юм. Тухайлбал, гэр бүлтэй байх эрх нь бүгдэд л хамаатай. Гэхдээ шилжин суурьшигчдын хувьд энэ эрх нь гэр бүлтэйгээ нэгдэх тухай асуудал юм. Түүнчлэн бүх төрлөөр ялгаварлан гадуурхах, хүнлэг бусаар харьцахын эсрэг, ажил хөдөлмөр эрхлэх, чөлөөтэй зорчихтой холбоотой хэм хэмжээг дурдаж болно.

Хоёрдахь хэсэгт шилжигчдэд зориулан тусгайлан боловсруулсан эрх зүйн баримт бичгүүд орно. Үүнд бүхий л хэлбэрийн шилжигчдийн эрх зүйн байдлыг тодорхойлсон, иргэний харьяаллын асуудлыг хөндсөн, тэтгэвэр тэтгэмж, шилжин

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

суурышигчдын гэр бүлийн гишүүдийн эрх зүйн байдал зэрэг асуудлыг тусгасан олон улсын эрх зүйн баримт бичгүүд юм.

## Анхдагч эх сурвалж

Олон улсын шилжих хөдөлгөөн нь зөвхөн хүний үндсэн эрх болох –чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох эрхийг хэрэгжүүлэх үйл явц биlleэ. Шилжих хөдөлгөөнийг хүмүүнлэгийн талаас нь авч үзвэл, түүнийг журамласан эрх зүйн үндэс суурь нь хүний үндсэн эрх, эрх чөлөөг тунхагласан олон улсын хэлэлцээр юм. Иймээс гадаад шилжих хөдөлгөөнтэй холбоотой эрх зүйн эх сурвалж нь хүний үндсэн эрх, эрх чөлөөг тунхагласан анхдагч эрх зүйн хэм хэмжээ, хоёрдахь нь эхний хэсэг дэх хэм хэмжээг илүү тодорхой болгож, хөгжүүлж өгсөн болно. Анхдагч эх сурвалж нь онцгой ач холбогдолтой.

Хамгийн анхны хүний эрх, эрх чөлөөний нэг хэсэг болсон чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох эрхийг 1215 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Английн хаан Иоанн төрийн баримт бичигт хуульчлан тунхагласан. Агуу эрх чөлөөний энэхүү баримт бичиг нь 49 зүйлээс бүрдэх бөгөөд хүний эрх, эрх чөлөө, түүний дотор чөлөөтэй зорчих эрхийг хуульчлахдаа «Үнээс хойш хүн бүр манай эзэнт гүрнээс явах, мөн усаар, хуурай газраар буцаж ирж болох бөгөөд гагцхүү бидэнд үнэнчээ хадгалах ёстой» гэжээ.

## Хүний эрхийн түгээмэл тунхаглал

Дээрх тунхаглал нь үе үеийн үндэсний болон олон улсын эрх зүйн баримт бичигт, юуны өмнө НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1948 онд баталсан Хүний эрхийн түгээмэл Тунхаглалд тусгалаа олж олон улсын үйл явц, чухамдаа гадаад шилжих хөдөлгөөнийг зохицуулах эрх зүйн зохицуулалтын үндэс, эх сурвалжийг бий болгосон.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь хүний эрх, эрх чөлөөг хангах, түүний дотроос хүн бүр чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох (13.1), хэн боловч аль нэг улсыг, түүний дотор төрөлх улсаа орхин явах, эх орондоо эргэж очих эрхийг (13.2) зарлан тунхагласан, олон улсын стандартыг тодорхойлсон, олон улсын анхны эрх зүйн баримт бичиг болсон.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан олон улсын шилжих хөдөлгөөнтэй холбоотой чухал заалтын нэг бол хэн боловч мөрдөлт мөшгилтөөс зугтаж, өөр улсад орогнох боломжийг эрэлхийлэх болон орогнох эрхийн тухай юм. Тунхаглалд заасан мөрдөлт мөшгилт гэдэг нь улс төрийн шалтгаанаас үүдэлтэй байх бөгөөд улс төрийн бус гэмт хэргийн улмаас буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилго, зарчимд харш хэрэг үйлдсний улмаас зайлшгүй мөрдөгдөж буй тохиолдолд дээрх эрхийг эдлэх боломжгүй тухай заасан (14.2).



## Бусад эх сурвалж

Олон улсын хүний эрхийн баримт бичгийн хоёр, гурав дахь хэсэг нь болох Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1966 онд баталсан.

Дээр дурдсан баримт бичгээс гадна НҮБ-ын ивээл дор батлагдсан хүний чөлөөтэй зорчих эрхийг хангах баталгааг агуулсан олон улсын эрх зүйн баримт бичиг бий. Тухайлбал, Арьсны өнгөөр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай 1966 оны конвенц, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай 1979 оны конвенц зэргийг дурдаж болно.

## Бүсийн хэмжээний баримт бичиг

НҮБ-ын ивээл дор батлагдсан, хүний эрхийг хангахтай холбоотой нийтэд хамааралтай олон улсын хэлэлцээрээс гадна олон улсын бүсийн байгууллагын санал санаачлагаар батлагдсан хүмүүнлэгийн шинжтэй, олон улсын эрх зүйн актууд энэ харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хүний үндсэн эрх, эрх чөлөө, чөлөөтэй зорчих эрхийн баталгааг илүү нарийвчлан, нээлттэй байдлаар тусгаж өгсөн бүсийн чанартай олон улсын хэлэлцээр бол Хүний эрхийн тухай Америкийн конвенц (1969 он), Хүний эрх ба ард түмний тухай Африкийн харти (1981 он), Хүний эрх, эрх чөлөөний тухай ТУХН-ийн конвенц (1995 он) юм.

Дээр дурдсан нийтлэг болон бүсийн чанартай олон улсын эрх зүйн гэрээ, хэлэлцээр нь бүхэлдээ олон улсын хамтын нийгэмлэгийн нийт оролцогчдод хүний эрх, эрх чөлөөг бодитоор тунхаглан, үр дүнтэйгээр хангахыг зарласан олон улсын шилжих хөдөлгөөний эрх зүйн зохицуулалтын эх сурвалж, үндэс нь юм.

Эдгээр олон улсын эрх зүйн хэлэлцээр нь нийтийн болон салбарын хэмжээнд ч тэр олон улсын эрх зүйн үндсэн зарчмыг агуулсан заавал биелүүлэх хэм хэмжээ болж чадсан байна.

## Шилжих хөдөлгөөний үндсэн зарчим

Олон улсын шилжих хөдөлгөөн, шилжигч бүрийн эрхийг хангахтай холбоотой анхдагч эх сурвалжийн зарчмыг дараах хэдэн бүлэгт хувааж үзэж болно. Үүнд:

1. хүний эрхийг бүх нийтээрээ хүндэтгэх, тухайлбал, хүн бүр чөлөөтэй зорчих, аль нэг улсыг, түүний дотор төрөлх улсаа орхиж явах, буцаж ирэх, мөрдлөг хавчлагын улмаас өөр улсаас орогнох эрх хүсэх, тэр эрхийг эдлэх;
2. Хүний эрхийг бүх нийтээрээ хүндэтгэх, сахин хамгаалах асуудлын нэг хэсэг нь улс орнуудын харилцаа, хамтын ажиллагаа болохыг хүлээн зөвшөөрөх;

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

- Олон улсын шилжих хөдөлгөөний үйл явцыг зохицуулах, түүний субъектын эрх зүйн байдлыг хамгаалахтай холбоотой улс орнууд олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ сайн дураараа биелүүлэх зэрэг.

Олон улсын шилжих хөдөлгөөнийг зохицуулагч хоёрдогч эх сурвалж нь хүмүүнлэгийн чиглэлийн олон улсын эрх зүйн анхдагч эх сурвалжид үндэслэн олон улсын эрх зүйн үндсэн зарчим дээр тулгуурлан илүү тодорхой хэм хэмжээг агуулж байдгаараа онцлогтой.

Дүрвэгчдийн эрх зүйн байдлын тухай конвенцид (1951 он) дүрвэгчдийн асуудлыг зохицуулснаас гадна оролцогч улсын хүлээх үүрэг, зарчмыг тусгаж өгсөн.

Картагены дүрвэгчдийн тухай тунхаглалд (1984 он) оролцогч улсын дүрвэгчдийг албадан гаргахгүй байхад уриалсан уриалга нь заавал биелэгдэх зарчим (*jus cogens*) юм.

ОУХБ олон улсын шилжих хөдөлгөөний нэг субъект болсон хөдөлмөрийн шилжигчидтэй холбоотой хэм хэмжээ, зарчмыг ч өөрийн конвенц, зөвлөмжид тусгасан.

Дээрх зарчим нь хүний эрхийн салбар дахь олон улсын эрх зүйн стандарт, гадаад шилжих хөдөлгөөний үйл явцыг зохицуулахтай холбоотой улс орны хүлээх үүргийг тодотгож буй хэрэг мөн.

## Хяналтын асуулт:

- Шилжих хөдөлгөөний эрх зүйн эх сурвалжийн бүтцийн талаар ярина уу.
- Шилжих хөдөлгөөний анхдагч эх сурвалж гэж юу вэ?
- Хүн чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох эрхийг хамгийн анх хаана, хэн, юу гэж хуульчилсан бэ?
- Хүний эрхийн түгээмэл тунхаглалын ач холбогдол юу вэ?
- Шилжих хөдөлгөөний үндэсний эх сурвалжийг нэрлэнэ үү.
- Шилжих хөдөлгөөний зохицуулалтын зарчим гэж юу вэ?

## Эх сурвалж

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал. //Төрийн мэдээлэл. I боть. УБ., 2004.
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт. //Төрийн мэдээлэл. I боть. УБ., 2004.
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. //Төрийн мэдээлэл. I боть. УБ., 2004.
- Амарсанаа Ж. Хүний эрх. Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал. УБ., 2000.
- Гэрэлчулун Х.Гадаад шилжих хөдөлгөөн, түүний эрх зүйн зохицуулалт. Эрх зүйн үзэл баримтлал: шинэ хандлага. Олон улсын бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2012.



## СЭДЭВ 2. Хүн амын шилжих хөдөлгөөн ба олон улсын байгууллага

**Сэдвийн зорилго:** Улс орнууд ямар нэгэн үйл явцыг зохицуулсан гэрээний хэм хэлжээг хэрэгжүүлэх, зорилгодоо хүрэх, холбоо харилцааг хөгжүүлэх зайлшгүй шаардлагаар олон улсын хамтын ажиллагааны механизмыг бий болгодог. Олон улсын шилжих хөдөлгөөнийг зохицуулагч байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээ, үйл ажиллагаатай танилцах нь бусад олон улсын байгууллагатай харьцуулан судлах, үнэлэлт дүгнэлт өгөх чадваар эзэтшихэд чиглэгдэнэ.

### Сэдвийн товч агуулга:

Шилжих хөдөлгөөний үйл явцыг зохицуулсан олон улсын механизмын жишээ нь олон улсын засгийн газар хоорондын байгууллага болох Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага (ОУШХБ), НҮБ-ын Дүрвэгчдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар (НҮБ-ын ДДКГ) байдаг.

Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллагын анхны суурь 1951 онд Европын шилжих хөдөлгөөний засгийн газар хоорондын хороо нэртэйгээр байгуулгадсан бөгөөд дэлхийн II дайн дуусч, Европ тив шилжигчдийн хөл үймээнд дарагдаж байсан тэр үеийн зайлшгүй шаардлагаар бий болсон.

Төв нь Швейцарийн Женев хотноо байрладаг. Одоогийн байдлаар 125 гишүүн, 18 ажиллагч орныг эгнээндээ нэгтгэсэн олон улсын нэр хүнд бүхий томоохон байгууллага болон хөгжөөд байна.

ОУШХБ дэлхийн 100 гаран улсад 400 гаруй төлөөлөгчийн газрыг нээн 5600-аад ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж, олон төсөл хэрэгжүүлдэг.

Байгуулдаж байсан дайны дараах нөхцөл байдлыг бодвол орчин үед эдийн засгийн боломжоо дээшлүүлэх зорилготой дэлхийгээр нэг тарж, оршин суух газраа өөрчилсөн шилжин суурьшигч, хөдөлмөрийн шилжигч нарыг төлөвшүүлэх асуудал тухайн байгууллагын өнөөгийн үйл ажиллагааны гол чиглэл.

### ОУШХБ-ын дүрэм

ОУШХБ-ын дүрмийг 1953 онд анх баталж, 1987 онд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Дүрмийн удиртгал хэсэгт зааснаар дэлхий даяар олон улсын шилжих хөдөлгөөний ургалыг илүү аятай, таатай зохицуулах, журамлахыг гол үүрэг зорилгоо гэж тодорхойлсон. Үйл ажиллагааны гол зарчим нь шилжих хөдөлгөөнийг хүмүүнлэг бөгөөд бүгдэд ашигтайгаар зохицуулах явдал юм. Энэ үйл ажиллагааг шилжигчид болон хүлээн авагч улсын засгийн газарт зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх журмаар хэрэгжүүлдэг.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

Үүнээс харахад шилжих хөдөлгөөнийг журамлан зохицуулах, хүмүүнлэг хандах нь шилжин суурьшигчид төдийгүй нийгэмд ч ашигтай байх ёстой бөгөөд үүний тулд ОУШХБ дүрмийнхээ дагуу дараах үргийг өөртөө хүлээдэг байна.

- Байгаа боломж, нөхцөл байдал нь хангалтгүй, эсвэл тусгай туслалцаа дэмжлэггүйгээр суурьших боломжгүй шилжигчдийг зохион байгуулах арга хэмжээ авах;
- Олон улсын шилжих хөдөлгөөний хүрээнд хүлээн авагч улс, байгууллага хоорондын тохиролцооны дагуу зохион байгуулалттайгаар ирж байгаа дүрвэгч, бусад шилжигчдийг суурьшуулах;
- Улсуудын хүсэлт, эсвэл тэдэнтэй тохиролцсоноор шилжигчдийг нэгтгэн бүрдүүлэх, тэдний шилжин суурьших бэлтгэлийг хангуулах, хэлний мэдлэгийн бэлтгэл хийлгэх, шилжигчдэд мэдээлэл өгөх, эмнэлгийн үзүүлэг болон бусад арга хэмжээг зохион байгуулах, зөвлөгөө өгөх, тусlamж үзүүлэх зэрэг байгууллагын зорилго чиглэлд нийцсэн үйл ажиллагаа явуулах;
- Улсуудын хүсэлтээр бусад сонирхогч олон улсын байгууллагуудтай хамтран, шилжигчдийн сайн дураараа буцах хөдөлгөөнийг зохион байгуулах;
- Олон улсын шилжих хөдөлгөөний бодлогын хүрээнд бусад улс орон, байгууллагатай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, хүчийг нэгтгэх, санал бодлоо солилцох хурал, зөвлөгөөнийг зохион байгуулах;
- Шилжих хөдөлгөөний дагуул, сөрөг үр дагавар болсон хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх зэрэг болно. Энэ асуудлын хүрээнд олон нийтийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл түгээх, хууль сахиуулах байгууллагын боловсон хүчнийг чадваржуулж гэмт этгээдийг илрүүлж таслан зогсоох, тэдэнд тохирсон ял оногдуулах, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэхэд анхаарлаа хандуулдаг байна.

## Үйл ажиллагааны чиглэл

ОУШХБ нь шилжих хөдөлгөөн ба хөгжил; шилжих хөдөлгөөнд дэмжлэг үзүүлэх; шилжих хөдөлгөөнийг зохицуулах; сайн дурын бус шилжих хөдөлгөөн гэсэн дөрвөн үндсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ төрлийн цогц арга хэмжээнд шилжих хөдөлгөөний талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгох, стратеги төлөвлөгөө боловсруулахад туслалцаа үзүүлэх, шилжигчдийн эрхийг хамгаалах, шилжигчдийн эрүүл мэнд ба жендерийн асуудлаар үнэлэлт өгөх асуудлууд багтдаг байна.

ОУШХБ нь Удирдах зөвлөл, Гүйцэтгэх хороо, Захиргааны газар гэсэн үндсэн бүтэцтэй. Удирдах зөвлөл нь ОУШХБ-ын гишүүн улсын төлөөллөөс бүрдэж, байгууллагын бодлогыг тодорхойлох, илтгэлийг хэлэлцэх, Гүйцэтгэх хорооны ажлыг батлах үүрэгтэй.



ОУШХБ-ын Гүйцэтгэх хороо нь тус байгууллагын гишүүн есөн орны төлөөлөгчдөөс бүрдэж байгууллагын үйл ажиллагаа, хөтөлбөр, санхүү төсөв, бодлогын төлөв байдлыг хэлэлцэх, Удирдах зөвлөлд санал оруулах асуудлыг эрхэлдэг. Захиргааны газарт нь Ерөнхий захирал, түүний орлогч, Удирдах зөвлөлөөс томилогдсон мэргэжилтнүүд ажиллана.

ОУШХБ-ын Ерөнхий захирал нь Удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны хоёрын саналаар таван жилийн хугацаагаар сонгогдож Удирдах зөвлөлөөс өгсөн чиг, үүргийн дагуу байгууллагын гүйцэтгэх болон захиргааны үүргийг эрхлэн гүйцэтгэдэг.

### **Цаашдын чиг хандлага**

Орчин үед тус байгууллага нь шилжих хөдөлгөөний дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагыг харгалзан өөрсдийн хүмүүнлэгийн хөтөлбөр, судалгаа, мэдээллээр дамжуулан улсуудын засгийн газар, хувь хүмүүст шилжих хөдөлгөөний асуудлыг шийдвэрлэх талаар туслалцаа дэмжлэг үзүүлэхийг санал болгож байна. Энэ зорилгод хүрэхийн тулд ОУШХБ улсуудын засгийн газар, бусад олон улсын байгууллага, түүний дотор НҮБ-ын ДДКГ, мөн шилжигч, тэдний оршин суух шинэ газар буюу хүлээн авагч улсын хооронд холбогч болсон засгийн газрын бус байгууллагатай хамтран ажилладаг.

### **НҮБ-ын Дүрвэгчдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар**

НҮБ-ын Дүрвэгчдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар (НҮБ-ын ДДКГ) нь олон улсын шилжих хөдөлгөөний нэг хэсэг болсон дүрвэгчдийн асуудлаар дагнан ажилладаг.

НҮБ үүсэн байгуулагдсан цагаасаа эхлэн дэлхийн өнцөг булан бүрт, тэр тусмаа Европын дайны дараах үед дүрвэгчдийг хамгаалахад хүч бололцоогоо зарцуулж ирсэн. Дэлхийн II дайны дараа шилжигчдийг буцаах үйл ажиллагаанд зохих хараа хяналтыг тавьж амжилттай ажилласан ч тэдний өмнө Зүүн Европын дүрвэгчдийн асуудал босч ирсэн.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн зөвлөмжийн дагуу 1946 онд Дүрвэгчдийн асуудлаархи олон улсын байгууллагыг (ДОУБ) байгуулсан.

Энэ байгууллагын дүрэмд зааснаар тус байгууллага нь дүрвэгчийн хувийн байдлыг тогтоох, тэднийг бүртгэх, буцаах, улс төрийн болон бусад эрхийг хамгаалахад туслалцаа дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

ДОУБ-ын бүрэн эрхийн хугацаа 1952 оны 2 дугаар сарын 28-ны өдрөөр дуусгавар болсон бөгөөд НҮБ-ын Ерөнхий Ассамблей түүнийг залгамжилсан байгууллага байх зайлшгүй шаардлагатайг тэмдэглэсэн.

Ийнхүү 1949 оны 12 дугаар сарын 3-ны өдөр Ерөнхий Ассамблейн 319 (IV) тогтоолоор НҮБ-ын Дүрвэгчдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газрыг байгуулсан. Төв байр нь Швейцарийн Женев хотноо байрладаг бөгөөд дэлхийн мөргөлдөөнтэй цэг бүрт төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаа явуулдаг.

## НҮБ-ын Дүрвэгчдийн дээд комиссарын газрын дүрэм

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1950 оны 428(V) тогтоолын хавсралтаар ДДКГ-ын дүрмийг батлаж гишүүн улсын засгийн газрыг дүрвэгчдийн асуудлаар тус байгууллагатай хамтран ажиллах, өөрийн үүргээ биелүүлэхийгuriалсан.

НҮБ-ын ДДКГ-ын дүрэмд зааснаар энэхүү дүрэмд хамаарах дүрвэгчдийг НҮБ-ын ивээл дор, гишүүн улсын засгийн газар, бусад байгууллагын дэмжлэгтэйгээр сайн дураараа нутагтаа буцах, шинэ газарт нутагших зэрэг асуудлыг эцэслэн шийдвэрлэхэд туслалцаа дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээдэг.

НҮБ-ын ДДКГ-ын дүрэмд, Дээд комиссарын үйл ажиллагааны гол агуулга нь төрийн бодлогоос ангид байж зөвхөн дүрвэгчдэд хамаарах, нийгмийн болон хүмүүнлэгийн шинжтэй үйл ажиллагаа явуулах тухай тусгагдсан.

Дүрмийн 2 дугаар бүлэгт дүрвэгчдийг хамгаалах Дээд комиссарын үүргийг зааж өгсөн. Үүнд:

- Дүрвэгчдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц байгуулах, соёрхон батлахад тус дөхөм үзүүлэх, конвенцын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах;
- Улсуудын засгийн газартай байгуулсан тусгай хэлэлцээрийн дагуу дүрвэгчдийн нөхцөл байдлыг хөнгөвчлох, хамгаалалт шаардлагатай дүрвэгчдийн тоог цөөрүүлэх зорилго бүхий арга хэмжээг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх;
- Дүрвэгчдийн сайн дураараа нутагтаа буцах, шинэ газарт нутагшин суурьшихад тус дөхөм үзүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтыг урамшуулан дэмжих;
- Дүрвэгчдийг бусад улсын нутаг дэвсгэрт иэвтрүүлэх боломжийг хөнгөвчлөх;
- Дүрвэгчдийг шаардлагатай мөнгө, эд хөрөнгөө шилжүүлэх, зөөвөрлөхөд туслалцаа үзүүлэх;



- Улсын засгийн газраас нутаг дэвсгэрт нь байгаа дүрвэгчдийн тоо, нөхцөл байдал, холбогдох хууль тогтоомжийн талаар мэдээлэл авах;
- Засгийн газар болон засгийн газар хоорондын байгууллагуудтай нягт холбоотой хамтран ажиллах;
- Дүрвэгчдийн асуудал эрхлэх хувийн хэвшлийн байгууллагуудтай холбоо тогтоох;
- Дүрвэгчдийг хамгаалах, халамжлах асуудал эрхэлдэг хувийн хэвшлийн байгууллагуудын хүчийг нэгтгэх, уялдуулан зохицуулах зэрэг болно.

Дээд комисsar өөрийн эрх мэдлийн хүрээнд хөрөнгөө захиран зарцуулах эрхтэйгээс гадна дүрвэгчдийг нүүлгэх, нутаг буцаах асуудлыг хариуцан ажилладаг.

### **НҮБ-ын ДДКГ-ын удирдлага зохион байгуулалт**

ДДКГ-ыг Дээд комисsar удирдана. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын нэр дэвшүүлэн санал болгосноор НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас Дээд комиссарыг 3 жилийн хугацаагаар сонгодог.

Дээд комисsar нь Ерөнхий нарийн бичгийн даргад харьялагдахгүйгээр Ерөнхий Ассамблейн удирдлага дор үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ. Тэрээр эдийн засаг, нийгмийн зөвлөлөөр дамжуулан Ерөнхий Ассамблейд жил бүр илтгэлээ танилцуулна.

Дээд комисsar нь ДДКГ-ын дүрэмд зааснаар Нийгэм, эдийн засгийн зөвлөлөөс зохион байгуулагдсан дүрвэгчдийн асуудлаархи зөвлөлдөх хороонд хандах боломжтой. Хамгийн анхны хороо 1951 онд байгуулагдаж байсан бол 4 жилийн дараа НҮБ-ын дүрвэгчдэд тусlamж үзүүлэх сангийн гүйцэтгэх хороо болгон өөрчилсөн ба түүний чиг үүрэгт тус сангаас санхүүжүүлж буй дүрвэгчдэд тусlamж үзүүлэх хөтөлбөрт хяналт тавих үүргийг оруулсан. Үүний дараагаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас гаргасан саналын дагуу 1958 онд Эдийн засаг, нийгмийн Зөвлөлөөс НҮБ-ын системээс гадна байгуулагдсан. Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллагаас ялгаатай нь ДДКГ-ыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн шийдвэрээр НҮБ-ын дүрмийн 22 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдсан туслах байгууллага юм.

Олон улсын шилжих хөдөлгөөний үйл явцын зохицуулалттай холбоотой олон улсын хэлэлцээрийн зарчим, хэм хэмжээгээр тогтоосон оролцогч улсын үүрэг хариуцлага нь олон улсын байгууллагуудаар дамжин хэрэгждэг.

### **Хяналтын асуулт:**

1. Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага хэзээ үүсэж, хэрхэн хөгжив?
2. ОУШХБ-ын чиг үүрэг юу вэ?

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

3. ОУШХБ-ын дүрмийн зорилгыг тайлбарлана уу.
4. ОУШХБ-аас явуулсан үйл ажиллагааны зориго юу вэ, жишээгээр тайлбарлана уу.
5. НҮБ-ын ДДКГ-ын зорилго, чиглэл юу вэ?
6. ОУШХБ, ДДКГ-ын ялгаа юу вэ?

## **Эх сурвалж**

1. НҮБ-ын дүрэм. УБ., 1945.
2. НҮБ-ын ДДКГ-ын дүрэм. 1950.
3. ОУШХБ-ын дүрэм. 1987.
4. Дүгэrsүрэн M, Хосбаяр O. Олон улсын эрх зүй, УБ., 1999.
5. Дүрвэгчдийн эрх зүйн байдлын тухай олон улсын баримт бичгийн эмхтгэл. УБ., 2007.



## СЭДЭВ 3. Европын Холбооны Улсуудын шилжих хөдөлгөөний эрх зүйн зохицуулалт

**Сэдвийн зорилго:** Европын афд түүний нягт холбоо байгуулахад чиглэгдсэн Европын орнуудын интеграцилах үйл явц Баруун Европын орнуудын хоффонд хүн амын шилжих хөдөлгөөнийг идэвхжүүлэх хүчин зүйл болсон. Энэ үтгээр хүний эрхийг хамгаалах хүрээнд эрх зүйн нэгдсэн зохицуулалт, хүлээн зөвшөөрөгдсөн үзэл баримтлал, зарчмыг бий болгосон бөгөөд оюутанд энэхүү зохицуулалтыг судалж үнэлэлт дүгнэлт өгөх чадваар эзэмшигүүлэхэд оршино.

### Сэдвийн товч агуулга:

Улс хоорондын эдийн засгийн нэгдэлд хөдөлмөрийн шилжигчдийн үүрэг өсөн нэмэгдэж улмаар шилжих хөдөлгөөний үйл явц нь улс орнуудын интеграцын хөгжлийн хөдөлгөх гол хүч болсон байна.

Хүн амын шилжих хөдөлгөөн нь юуны өмнө чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох; аль нэг улсыг, түүний дотор төрөлх орноо орхиж явах ба буцаж ирэх; мөрдлөг, хавчлагаас болж аль нэг улсаас орогнол хүсэх, түүнийгээ эдлэх эрх зэрэг хүний эрхтэй салшгүй холбоотой.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948 он), Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966 он), Арьсны өнгөөр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (1966 он) зэрэг олон улсын нийтийн шинжтэй баримт бичигт дурдсан хүний эрх, эрх чөлөөг бүсийн шинжтэй олон улсын эрх зүйн хэлэлцээрт, тухайлбал, 1963 оны Протокол №4, 1950 оны Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах Европын конвенцид тусгалаа олсон билээ.

### Европын эрх зүйн зохицуулалтын үүсэл хөгжил

Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах Европын конвенцийг Ром хотноо 1950 оны баталж 1953 оноос хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн.

Европын орнуудын засгийн газар Хүний эрхийн түгээмэл тунхаглалын үзэл санааг анхааралдаа авч, бүх нийтээрээ хүний эрх, эрх чөлөө, иргэний болон улс төрийн эрхийг хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн. Үүний зэрэгцээ Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах Европын конвенцийг (1950 он) хэрэгжүүлэх ажлыг хангах зорилгоор Европын хүний эрхийн комисс, Европын хүний эрхийн шүүх гэсэн хоёр байгууллагыг байгуулсан. Комисс нь оролцогч улсуудаас хүний эрхийн зөрчилтэй холбоотой хүсэлтийг хүлээн авч хянах, шүүх нь өөрийн эрх мэдлийн хүрээнд холбогдох шийдвэр гаргах эрхтэй.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

Европын Конвенц хүний эрх, эрх чөлөөг бататган, хувь хүнийг төр засаг, гуравдагч этгээдийн халдлагаас хамгаалах, тэднийг өөрсдийн амьдралаа зохиох, нийгмийн амьдралд оролцох, хуулиар тогтоосон хувийн болон иргэний ашиг сонирхлоо хангахыг чармайх, тэр эрх нь зөрчигдсөн тохиолдолд тэмцэх эрхийг баталгаажуулсан.

## Европын Холбооны харьяалал

Баруун Европын орнуудын эдийн засаг, валютын холбоо зэрэг нийтийн зах зээл байгуулахтай холбоотой олон гэрээ, хэлэлцээрийг боловсруулах, байгуулах үед анхаарлын төвд байсан зүйлийн нэг бол Европын Холбооны гишүүн орнуудын хүн амын шилжих хөдөлгөөний зохицуулалтын асуудал юм.

Европын Холбооны тухай Маастрихтын гэрээнд (1992 он) оролцогч улсууд холбооны нутаг дэвсгэрийн хүрээнд хүн амын чөлөөтэй зорчих эрхийг баталгаажуулсан. Түүнээс гадна Маастрихтын гэрээнд Холбооны харьяалал гэдгийг бий болгосон. Гэрээнд гишүүн орны хүн бүр Холбооны харьяалалтай байна гэж заасан. Гэсэн хэдий ч өөрийн улсынхаа харьяалалтай байх асуудлыг энэ заалт хөнддөгтгүй. Зарим тохиолдолд Европын Холбооны хүрээнд шилжин ирэгчдийн иргэний харьяаллын асуудлыг хэрхэн шийдвэрлэх асуудал өөрийн эрхгүй урган гарна. Энэ асуултад комиссоос “гишүүн орнууд тохиолдол бүрийг өөрийн орны хууль тогтоомжоор зохицуулна” гэдэг зарчмыг хариулт болгосон байdag.

Маастрихтын гэрээний агуулгыг хараад Европын Холбооны гишүүн орнууд Холбооны Улсын нутаг дэвсгэрт өөрийн иргэдээ чөлөөтэй зорчихыг сайшаан дэмжих бодлого барихын зэрэгцээ гуравдагч орноос шилжигчдийн хувьд хатуухан байр суурьтай байсан гэж дүгнэж болох юм.

## Шенгений хэлэлцээр

Люксембургийн Шенген хотноо 1985 онд Хилийн хяналт шалгалтыг аажмаар халах тухай хэлэлцээр (Шенгений хэлэлцээр гэж нэршсэн)-т гарын үсэг зурсан. Энэхүү Шенгений хэлэлцээрийн үндсэн дээр 1990 онд түүнийг хэрэглэх, хүчин төгөлдөр мөрдөх тухай Конвенцийг баталсан.

Энэ конвенц нь Шенгений орнууд гадаад хилийн хяналтаа чангатгах, хууль сахиулах байгууллагууд, түүний дотор цагдаа, цэргийн хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, визийн бодлогыг уялдуулан нэг мөр болгох талаар тусгасан.

Хэлэлцээрийн оролцогч улсууд нутаг дэвсгэрээ хууль бус шилжих хөдөлгөөн, улсын аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалах зорилгоор гаднах хилээ бататгах талаар дараах зүйлийг харилцан тохиролцсон.



1. Европын Холбооны Улсууд хил, цагдаа, гаалийн зэрэг хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх, мэдээлэл харилцан солилцох,
2. Нутаг дэвсгэрт нь орох визийн нөхцөл, бодлогын талаар харилцан тохиролцох,
3. Гадаадын иргэн, гуравдагч орны иргэдийн асуудлыг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм журмын талаар харилцан тохиролцох,
4. Шаардлагатай үед гаднах хил дээр хамтарсан хяналт явуулах, хориглох, хязгаарлах, асуудлаар тохиролцох, Европын Холбооны гишүүн бус орны иргэдийн хууль бус шилжих хөдөлгөөнтэй тэмцэх, аюулгүй байдлыг хангах асуудлаар нэмэлт арга хэмжээ авах зэрэг.

Конвенцийн оролцогч улсууд виз олгох үйл явц, хүн амын шилжих хөдөлгөөнтэй холбогдсон нэгдмэл бодлого явуулах үүрэгтэй. Тэд гаднах хил, хилийн шалган нэвтрүүлэх боомтуудыг ажиглалтад байлгах; гадаадын иргэд тухайн нутаг дэвсгэрт нэвтрэн орох, нутаг дэвсгэрээс гарахтай холбоотой хяналт шалгалтыг үр дүнтэй болгох зорилгоор хамтран ажиллах талаар тохиролцсон байна.

Олон улсын хамтын ажиллагааг үр өгөөжтэй болгох зорилгоор Шенгений мэдээллийн сүлжээний нэгдсэн системийг байгуулж оролцогч улсын хилийн шалган нэвтрүүлэх боомт дээр хэлэлцэн тохирогч улсын хууль тогтоомжоор орохыг хориглосон иргэнийг хил нэвтрүүлэхгүй байх боломжийг бүрдүүлж өгсөн.

### **Хөдөлмөрийн шилжих хөдөлгөөний эрх зүйн зохицуулалт**

Хүн амын шилжих хөдөлгөөн нь Европын Холбооны Улсуудын эдийн засаг, хөгжилд чухал ач холбогдолтой. Сүүлийн хэдэн арван жилд Баруун Европын орнуудад хоорондоо харилцан шүтэлцээтэй хүн амын гурван хямрал нүүрлээд байгаа нь төрөлт багассан, хүн амын хөгшрөлт, хүн амын цөөрөлт юм. Урьдчилсан тооцоогоор Европын Холбооны Улсуудын эдийн засгийн хөгжилд оролцоотой идэвхтэй хүн амын тоо 1990 онд 145 сая байсан бол 2020 онд 135 сая болж буурах тооцоо байдаг. Мөн Европын Холбооны хүн амын 30-45 хувь нь 55-64 насны хооронд хөдөлмөрийн зах зээлээс явдаг бол, ажил эрхэлж байгаа 65-69 насныхан 10 хувийг эзэлдэг байна.

Европын бодлогын төвийн дүгнэлтээр Европын Холбооны Улсууд хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэртэй байдлыг барихын тулд жил бүр 1,5- 3 сая хөдөлмөрийн шилжигчдийг татаж авах буюу “импортлох” шаардлагатай болж байна.

Гэхдээ Баруун Европын орнууд 1950-аад онд их хэмжээгээр бүрэн бус, дунд боловсролтой ажиллах хүчнийг гаднаас авч байсан бол өнөөдөр Европын Холбооны Улс өндөр боловсрол бүхий хөдөлмөрийн шилжигчдийг татаж авахад голлон анхаарч байна. Тиймээс ч Франц, Их Британи зэрэг улсад өндөр боловсролтой мэргэжилтэнд ажил эрхлэх зөвшөөрлийг хурдавчилсан, хялбаршуулсан байдлаар олгодог ажээ.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

## Ромын гэрээ

Европын эдийн засгийн нийгэмлэгийг үүсгэн байгуулсан тухай 1957 оны Ромын гэрээнд Европын нэгдсэн дотоод зах зээлийг бий болгох гол нөхцөл нь гишүүн орнуудын хооронд хүн амын чөлөөтэй зорчих эрхийг хангах, саад бэрхшээлийг арилгах явдал гэж үзсэн байна.

Юуны түрүүнд энэ нь шилжих хөдөлгөөний нэг бүлэг болох хөдөлмөрийн шилжигчдэд хамаатай. Ромын гэрээнд нийгэмлэгийн дотор гишүүн орнуудын хөдөлмөрийн шилжигчдийн чөлөөтэй зорчих эрхийг баталгаажуулж хөдөлмөр эрхлэх, хөдөлмөрлөх нөхцөл, шагнал урамшуулал олгох зэрэгт үндэс угсаагаар алагчлах үзлийг гаргахгүй байх талаар заасан.

Мөн Гэрээний 48 дугаар зүйлд зааснаар хөдөлмөрийн шилжигчид дараах эрхийг эдлэнэ.

- бодитоор ажил эрхлэх,
- энэ зорилгоор гишүүн орнуудын нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих,
- аль нэг гишүүн орны нутаг дэвсгэрт ажил эрхлэхдээ тухайн орны иргэдийн нэгэн адил хөдөлмөр эрхлэлтийг зохицуулсан хөдөлмөрийн, захиргааны болон бусад хууль тогтоомжийн дагуу ажиллах,
- аль нэг гишүүн орны нутаг дэвсгэрт ажил хийж дууссаны дараа тухайн нутаг дэвсгэрт үлдэх зэрэг болно.

Мөн Ромын гэрээний гол заалтын нэг нь залуучуудын чөлөөтэй зорчих нөхцөлийг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатайг тэмдэглэсэн явдал юм.

Ромын гэрээнд оролцогч улсын нутаг дэвсгэрт байгаа оролцогч нөгөө улсын иргэнд эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласан хязгаарлалтыг тодорхой хугацаанд аажмаар, үе шаттайгаар халах агуулга бүхий заалт орсон. Хүмүүс эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх, оршин суух газраа чөлөөтэй сонгох гэдэгт өөрөө үйл ажиллагаа эрхлэх, үйлдвэр байгуулах, түүнийг удирдах ч хамаарна. Гэрээгээр аль нэг гишүүн улсын иргэн нөгөө гишүүн улсын нутаг дэвсгэрт суурин байгууллага, салбар компани байгуулахтай холбоотой хязгаарлалтыг хүчингүй болгосон.

Мөн хөдөлмөрийн шилжигчид ажил үйлчилгээ эрхэлж байгаа нутаг дэвсгэртээ тухайн орны иргэдийн нэгэн адил нийгмийн болон татварын хөнгөлөлт, орон сууц эзэмших, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байх, гэр бүлийн гишүүдтэйгээ хамт амьдрах эрхийг баталгаажуулсанд оршиж байна.

Дээр дурдсан дотоод дурэм, захирамжууд Европын Нийгэмлэгийн үйл ажиллагааны эрх зүйн эх сурвалж болохын зэрэгцээ Нэгдсэн Европын интеграциллын үйл явцыг хөхүүлэн дэмжсэн чухал ач холбогдолтой баримт бичиг болсон.



### **Хяналтын асуулт:**

1. Европын интеграцилалд шилжих хөдөлгөөний оруулсан нөлөө юу болохыг тайлбарлана уу.
2. Европын Холбооны Улсуудын шилжих хөдөлгөөний эрх зүйн зохицуулалтын эх сурвалжийг нэрлэнэ үү.
3. Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах Европын конвенцийг хэргжүүлэх зорилгоор авсан арга хэмжээг юу гэж дүгнэх вэ?
4. Холбооны харьялал гэж юу болох, түүнийг Европын Холбооны Улсууд заавал дагаж мөрдөх эсэх талаар тайлбарлана уу.
5. Шенгений хэлэлцээрийн гол агуулгыг тодорхойлно уу.
6. Европын гадаад, дотоод хилийн зааг, түүний дэглэмийг тайлбарлана уу.

### **Эх сурвалж**

1. Европын зөвлөлийн дүрэм. 1949.
2. Европын нийгмийн харти. 1961.
3. Европын эдийн засгийн нөхөрлөлийг байгуулах тухай гэрээ. 1957.
4. Европын Холбооны тухай гэрээ. 1992.
5. Европын Холбооны аль нэг улсад орогнол хүсэх өргөдлийг хянан шийдвэрлэх тухай конвенц. 1990.
6. Амарсанаа Ж. Хүний эрх. Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал. УБ., 2000.
7. Гэрэлчулун Х. Хүн амын шилжих хөдөлгөөн. УБ., 2010.

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

## СЭДЭВ 4. Шилжих хөдөлгөөн ба хүн ам зүйн асуудал

**Сэдвийн зорилго:** Олон улсын (гадаад) шилжих хөдөлгөөн нь зүй ёсны үйл явц бөгөөд хүн амыг газар нутаг, улсаар нь дахин хувааж, хүн ам зүйн бүтцэд онцгой нөлөөлдөг болохыг тогтоосон. Иймээс шилжих хөдөлгөөний дунд улсуудын хүн амын бүтэц хэрхэн өөрчлөгддөг, түүний эзрэг, сөрөг талууд, улсуудын бодлогыг судлан оюутанд цогц тэдлэг олгоход чиглэгдэнэ.

### Сэдвийн агуулга

Гадаад шилжих хөдөлгөөний дунд улсуудын хүн ам зүйн бүтэц өөрчлөгдөн шинэчлэгдэж байдаг. Тиймээс ч сүүлийн үед шилжин суурьшигчид улс орныг хүн ам зүйн хямралаас аварч болох тухай ярилцах болсон.

Хүн ам зүйн үндсэн үзүүлэлт нь хүн амын ердийн өсөлт байдаг бол нөгөө нэг үзүүлэлт нь механик өсөлт буюу шилжих хөдөлгөөн байдаг. Шилжих хөдөлгөөн нь хүн амын өсөлт, хөдөлмөр эрхлэлтэд онцгой нөлөөтэй. Шилжих хөдөлгөөнд нас биед хүрсэн хүн илүүтэйгээр оролцдог.

Дэлхийн жишигт 1000 хүнд төрсөн хүүхдийн тоо 16-аас бага байвал хүн амын нөхөн үйлдвэрлэлийн түвшинг хангаж чадахгүй, 16-25 бол дунд зэрэг, түүнээс дээш бол хангалттай гэж үздэг.

Улс оронд хүн амын төрөлт багассанаар хүн амын хөгшрөлт их болж улсын тэтгэвэр, тэтгэмжийн санг санхүүжүүлэхэд хүндрэл үүсгэдэг.

Шилжигчид аль нэг улсад суурьшиж тухайн улсын хүн ам, эдийн засаг, нийгэм соёлын амьдралд зохих хувь нэмрээ оруулж байгаа хэдий ч уугуул эх орондоо хүндрэл үүсгэж байгааг анхаардагтгүй.

### Улсуудын нөхцөл байдал

XIX зууны сүүлч, XX зууны эхэн үед Баруун, Зүүн Европын болон Тусгаар улсын хамтын нөхөрлөлийн орнуудад төрөлт эрс багасч, хүн амын хөгшрөлт ихэсч, дундаж наслалт богиносон хүн ам зүйн хямралыг бий болгосон.

XX зууны дунд үед Европын арай илүү хөгжингүй орнуудад дэлхийн хүн амын турван хувь нь оршин сууж байсан бол одоо энэ хувь тавны нэг болтлоо буурсан судалгаа байдаг. Иймээс ирээдүйд Европын Холбооны Улсууд хүн амын тэнцвэртэй байдлыг хадгалахын тулд шилжих хөдөлгөөний цэвэр жинг жилд 1 сая хүнээр барьж байх нь зүйтэй гэж үздэг байна.

Сүүлийн үед ОХУ-д хүн амын тоо нь цөөрч байгаа бөгөөд хүн ам зүйн нөхцөл байдлын хувьд таатай бус орны тоонд орсон байна. Тус улсын статистикийн хорооны



шинжээчдийн дүгнэлтээр оросын хүн амын жам ёсны хорогдлыг гадаадын буюу ихэнхдээ ТУХНО, Балтын орнуудаас шилжин ирэгчдийн урсгал нөхдөг аж. Шилжих хөдөлгөөний цэвэр жинг ойролцоогоор 500 мянган хүнээр барьж байх ёстой бөгөөд энэ тоо багасвал ОХУ-ын хүн ам цөөрөхөд хүрэх тооцоо байдаг юм байна.

Хүн ам зүйчдийн урьдчилсан судалгаагаар ОХУ-ын хүн ам 2050 оны сүүлч гэхэд 30 хувиар багасч 101,9 сая болно гэж тооцоолсон байна.

Хүн ам зүйн хүндрэлтэй байдал Америк, Австрали, Канад зэрэг өндөр хөгжилтэй орнуудыг ч тойроогүй. Тухайлбал, Канад Улсад төрөлт жил ирэх тутам багасаж байгаа хандлага ажиглагдаж байна. Энэ нь хүн ам зүйчдээс ойрын арван жилд депопуляци буюу хүн ам нөхөн үргижихгүйгээс хүн амын бууралт болж нийт хүн амын дийлэнхийг хамарсан хөгшрөх үйл явц үргэлжилнэ гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

### **Хүн ам зүйн бодлого**

Дэлхийн ихэнх улс өөрийн улсын хүн амаа өсгөх бодлого барьдаг. Энэ зорилгоор:

- төрөлтийг дэмжих замаар хүн амаа өсгөх,
- гадаад оронд ажиллаж амьдарч байгаа иргэдээ эх орондоо буцааж татах,
- үндэс угсаа нэгтнээ татах,
- өндөр мэргэжлийн, ур чадвар сайтай гадаадын иргэдийг татах зэрэг бодлого явуулдаг байна.

Улс орнууд хүн амын депопуляцийн үзэгдлийг зайлшигүй анхаарах шаардлагатай гэж үздэг. Энэ үзэгдэл нь хөдөлмөрийн зах зээл дээр хөдөлмөрийн чадвартай ажиллах хүчиний хомсдол үүсгэж гаднаас ажиллах хүч авахад хүргэдэг.

Улсууд хүн амаа өсгөх тухай хууль тогтоомжид тусгаж зарлан тунхагладаггүй хэдий ч тухайн улсын иргэний харьялалтай болох хүсэлтэй хүмүүсийг өөрсдийнх нь хүсэлтээр (натурализаци) иргэний харьялалтай болгох, давхар харьялалыг хүлээн зөвшөөрөх, иргэний харьялалыг нэг талын (төрийн) санаачлагаар дуусгавар болгохгүй байх, иргэний харьялалтай болгох шалгуур үзүүлэлтийг аль болох хялбаршуулах зэргээр хүн амын зохистой харьцааг барихыг оролддог байна.

Улс оронд орж ирэх шилжигчдийн урсгал нь гол төлөв zaluuчуud байдаг нь хүн амын жам ёсны өсөлтийн динамикийг нөхөн zaluujuuldag байна.

Шилжин ирэгчид нь улс орны хүн амын уналт буюу зогсонги байдлаас гаргах, хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болдог бөгөөд улс орны эдийн засгийн хөгжилд шууд нөлөөтэй.

Канадын Эдийн засгийн зөвлөлийн албан ёсны төлөөлөгчийн үзэж байгаагаар Канадад гаднаас шилжин ирэгчид хүн амын өсөлтийн 60 хувийг нөхөх ба энэ ч

# ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ БА ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

Үүднээс шилжин ирэгчдийг даган гарах сөрөг, хүндрэлтэй үр дагаврыг үл хайхран гаднаас ирэх шилжих хөдөлгөөнийг урамшуулан дэмжих нь зүйтэй гэж үздэг байна.

## Ухаантай тархийг татах

“Ухаантай тархийг” татах үйл явц 1960-аад оноос эхэлж, европын орнуудаас, түүний дотор Англи, Ирланд, Орос зэрэг орны голдуу өндөр мэргэжлийн инженер-техникийн ажилтан, эрдэмтэд АНУ, Канадад шилжин суурьшснаар өرنөж 1980-1990 онд ОАБНУ, Израиль, Саудын Араб, болон Персийн булангийн орнуудад шилжин суурьшсан байна. Оршин суугаа газраа өөрчлөх гол өдөөгч хүчин зүйл нь хөдөлмөрийн бүтээмжээ ашиглаж олох өндөр цалин хөлс, уран бүтээлийн хувьд өсөх өргөн боломж байдаг.

Хүлээн авагч улс орнууд гаднаас аль болох “ухаантай тархийг” татах, урхидах бодлого явуулж байгаа нь илгээгч буюу донор орнуудад оюуны хүчин чадлаа алдах хүндрэлтэй асуудлыг бий болгодог.

Шилжигчдийн дунд шинжлэх ухааны докторууд, нарийн мэргэжлийн эмч зэрэг өндөр боловсрол мэргэжилтэй залуу, дунд насныхан байдаг бөгөөд эднээр дамжуулан цэрэг, шинжлэх ухаан, техник технологи, инновацитай холбоотой оюуны өмчөө гадагш нь алддаг.

## Байнга оршин суух зөвшөөрөл

Мэргэжил боловсролтой, өндөр зэрэглэлийн, ховор мэргэжилтэн, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагч нь очсон газартаа ажлын шинэ байр бий болгох, бизнесийн үйл ажиллагаа явуулах нь хүлээн авагч орны эдийн засагт сайнаар нөлөөлдөг. Ийм ч учраас Америк, Канад зэрэг олон улсад гадаадын хөрөнгө оруулагч, үйлдвэрлэгч нарыг татах зорилгоор хөрөнгө оруулалт, худалдааны тусгай хөтөлбөрийг зарладаг.

АНУ байнга оршин суугчиддаа “ногоон карт” олгож зөвшөөрөл олгодог бол Европын Холбооны Улсууд тус тусынхаа хуулиар “байнгын оршин суугч” байх зөвшөөрлийг зохицуулдаг хэдий ч Европын Холбооны зүгээс байнгын оршин суугчийн бас нэгэн шинэлэг хэлбэрийг бий болгосон нь “цэнхэр картын систем” юм. Энэ нь мэргэжлийн өндөр ур чадвар шаардах ажлын байранд Европын Холбооноос бусад, гуравдагч орны иргэдийг хөдөлмөр эрхлэлтэд зуучлах зорилгоор Европын Холбоонд багтдаг орнуудын нутаг дэвсгэрт удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгох хэлбэр юм. Европын Холбооны Улсууд өөр орны иргэд ихэвчлэн нарийн мэргэжлээр суралцдаг бөгөөд ингэж суралцсан мэргэжилтнийг эх оронд нь буцаан алдахаас сэргийлж, нөөц бололцоог нь өөрийн орондоо ашиглах зорилгоор ийм зохицуулалтыг бий болгосон.



### **Хяналтын асуулт:**

1. Хүн ам зүйн хямрал гэж юу вэ? Түүнийг хэрхэн зохицуулах вэ?
2. Хүн ам зүйн бүтцийг өөрчилдөг нийгмийн үзэгдлийг тайлбарлана уу.
3. Улс орнуудад нүүрлэсэн хүн амын хямрал, түүнийг хэрхэн даван туулж байгааг жишээгээр тайлбарлана уу.
4. “Ухаантай тархи” татах үйл явцын, түүний эерэг, сөрөг тал болон эрх зүйн зохицуулалтыг тайлбарлана уу.
5. “Ухаантай тархи”-ийг илгээгч буюу донор орны нөхцөл байдлыг тайлбарлана уу.
6. Байнга оршин суух зөвшөөрөл гэж юу болох, өөрийн улсын эрх зүйн зохицуулалттай холбож тайлбарлана уу.

### **Эх сурвалж**

1. Демографический понятийный словарь. /Под ред. Л.Л. Рыбаковского. М., 2003.
2. Демографический энциклопедический словарь /Гл. ред. Д.И.Валентей. М., 1985.
3. Монгол Улсын хүн ам зүйн хөгжлийн төлөв байдал. УБ., 2008.
4. Безвербный В.А. Миграционные процессы как фактор внутренней безопасности и территориальной целости государства //Миграционное право. М. 2008. №2.
5. Влияние незаконной миграции на криминогенную обстановку в РФ. Тенденции правового регулирования противодействия незаконной миграции» //Миграционное право. 2008. №1.